

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/Бүрэн эрхийн хугацааны 2009 оны жилийн эцсийн өссөн дүнгээр/

2010-03-26.

Эрдэнэт хот

Д/д	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн талаархи тэмдэглэл
<p>Нэг: Нийгмийн хөгжлийн бодлого</p> <p>Өрх гэр бүлийг дэмжин, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.</p> <p>1. Боловсрол, соёл, хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлого, зохицуулалт</p>			
1.1.1.	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхэд хүмүүжих таатай орчинг бүрдүүлж, хүүхдийн сургалт хүмүүжил, сургалтын ажлын чанарт ахиц гаргана.	<p>1. Захын гэр хороолол буюу Эрдэнэ, Их залуу, Баянбулаг, Рашаант, Баянцагаан багт шинээр цэцэрлэг барьж, ашиглалтанд оруулах.</p> <p>2. 2, 7 болон Жаргалант сумын цэцэрлэгийг өөрийн хүчин чадлыг бүрэн ашиглан ажиллах боломжоор хангах.</p> <p>3. Цэцэрлэгүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангалтыг 50 хувьд хүргэх.</p>	<p>Их залуу багт 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга барихаар улсын төсөвт 450.0 сая төгрөг тусгагдсаны дагуу барилгын ажлыг 2009 оны 7 дугаар сард эхлүүлж, ажлын явц 70,0 хувьтай байна.</p> <p>Баянцагаан багт баригдах цэцэрлэгийн зураг, төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба шаардагдах 500,0 сая төгрөгийг 2010 оны улсын төсөвт тусгуулан батлагдаад байна.</p> <p align="right">Хэрэгжиж байна 30%</p> <p>Жаргалант сумын болон Баян-Өндөр сумын 2 дугаар цэцэрлэгт тус бүр 1, 7 дугаар цэцэрлэгт 2 бүлгийг нээн, тохижуулж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж, хүчин чадлаа бүрэн ашиглаж байна.</p> <p align="right">Биелсэн 100%</p> <p>“Тогтвортой амьжиргаа II” төслийн хүрээнд аймгийн 11 цэцэрлэгт 47.3 сая төгрөгийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, ширээ, сандал, тоглоом бүхий хөрөнгө оруулалт хийснээр тоглоомын хангалт 30 хувьтай байна.</p> <p align="right">Хэрэгжиж байна 50%</p>

		<p>4. Цэцэрлэгүүдийг сургалтын техник, хэрэгсэлээр хангах, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх.</p>	<p>Цэцэрлэгүүдийг техник, хэрэгслээр хангах, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор олон улсын болон төсөл хөтөлбөртэй хамтран ажилласнаар 18-р цэцэрлэгт дүрслэх урлагийн хичээлийн иж бүрэн үзүүлэн, Жаргалант сумын 3-р цэцэрлэгт 4.3 сая, 22-р цэцэрлэгт 2.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилтээр 7 дугаар цэцэрлэгт 1.9 сая төгрөгийн хүүхдийн ор, орны цагаан хэрэгсэл олголоо.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>5. Цэцэрлэг, сургуулийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтэд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлж, эрүүл ахуйн стандартыг мөрдөн ажиллах.</p>	<p>Цэцэрлэг, сургуулиудын ариутгал, халдваргүйтэлд орон нутгийн төсвөөс 4.8, улсын төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулж, ариутгал, халдваргүйтлийг тогтмол хийж байна.</p> <p style="text-align: right;">Биелсэн 100%</p>
		<p>6. 1, 2, 3, 6, 8, 10, 15, 16, 17, 18 дугаар цэцэрлэгийн барилгуудад их засвар хийх.</p>	<p>Орон нутгийн төсвөөс 16-р цэцэрлэгийн дээвэр, сантехникийг засварлахаар 18.0 сая, 19-р цэцэрлэгийн шугам засахад 4.9 сая, 17-р цэцэрлэгийн сантехник засварлахад 13.0 сая төгрөг тус тус зарцуулав.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>7. 3, 4, 10, 16, 18, 19, 20, 22 дугаар цэцэрлэгүүдийн гаднах хүүхдийн тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах.</p>	<p>“Тогтвортой амьжиргаа II” төслөөс 2-р цэцэрлэгт 3.7 сая, 15–р цэцэрлэгт 7.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулав.</p> <p>Бусад цэцэрлэгүүдийн тоглоомын талбайг тохижуулах ажлыг 2010 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>8. СӨБ-ийн хувилбарт сургалтыг ашиглан СӨБ-д хамрагдалтыг 1,5 хувиар нэмэгдүүлж, стандарт хангалтын хувийг 70 хувьд хүргэх.</p>	<p>Хувилбарт сургалтанд 498 хүүхэд хамрагдаж, энэ нь СӨБ-д хамрагдалтын хувийг 10.9 хувиар нэмэгдүүлж байна. СӨБ-ийн суурь мэдлэгийн түвшингийн стандарт хангалт 82,0 хувь байгаа нь өмнөх оноос 13.5 хувиар нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;">Биелсэн 100%</p>
		<p>9. Хүүхдүүдийг тэжээллэг, эрүүл хоол хүнсээр хангах зорилгоор цэцэрлэгүүд туслах аж ахуй хөгжүүлэх санал санаачлагыг дэмжин ажиллах.</p>	<p>Цэцэрлэгийн хүүхдийн хоолыг төр бүрэн хариуцах болсон бөгөөд оны эхэнд хоолны мөнгөний хүрэлцээ хангалтгүй байсан боловч 4 дүгээр сараас нэг хүүхдэд оногдох хүүхдийн хоолны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн тул хүүхдийн хоолны илчлэг, норм</p>

			<p>стандартын шаардлагыг хангаж байна.</p> <p>Цэцэрлэгүүд өөрсдийн хүчээр хүүхдийн хоолыг бэлтгэн нийлүүлэх болсонтой холбоотойгоор 4, 16, 22, 2-р цэцэрлэг өөрийн эзэмшил 230 кв.м талбайд төмс, хүнсний ногоо тарьж, 712.0 мянган төгрөгийн ургац хураан авч, хоол хүнсэндээ хэрэглэж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
1.1.2.	<p>Ерөнхий боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, сурагчдын сурах идэвхийг нэмэгдүүлэн, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</p>	<p>1. Шанд, Эрдэнэ, Дэнж, Их залуу багт спорт, урлагийн заалтай сургууль барьж ашиглалтанд оруулах.</p>	<p>Шанд, Эрдэнэ, Дэнж, Их залуу багуудад баригдах сургуулиудыг нэг загвараар барихаар зураг, төсвийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд хөрөнгийн асуудлыг, судалгаа тооцооны хамт холбогдох дээд шатны байгууллагад тавиад байна.</p> <p>2009 онд сургуулиудын зураг, төсөв, холбогдох тооцоо судалгааг хийхээр төлөвлөсөн бөгөөд 2010 оноос хэрэгжиж эхлэхээр үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан болно.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
		<p>2. 14 дүгээр сургуулийн дэргэдэх дутуу баригдсан спорт заалыг үргэлжлүүлэн барих.</p>	<p>Тасарсан.</p>
		<p>3. “Орхон” цогцолбор сургуулийн III, Баян-Өндөр цогцолбор сургуулийн II, “Эрдэнэт” цогцолбор сургуулийн IV байранд спорт заал барих.</p>	<p>6-р бага сургуулийн спорт заалны зураг төслийн ажил хийгдсэн бөгөөд уг заалыг барих хөрөнгийн асуудлыг “Ирээдүйн одод”, “Эрдэнэт” цогцолбор сургуулийн IV байрны спорт заалны хамт холбогдох газарт тавин хөөцөлдөж байна.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
		<p>4. “Наран” цогцолбор сургуулийн хичээлийн I байр, 6-р цэцэрлэгийг хэрэглээний халуун, хүйтэн усны шугаманд холбох.</p>	<p>2010 оноос хэрэгжиж эхлэхээр хөтөлбөрт тусгагдсан болно.</p> <p>Хугацаа болоогүй.</p>
		<p>5. Суралцагчдын стандарт хангалтын хувийг хүрсэн түвшингээс бууруулахгүй байх.</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролыг 582, суурь боловсролыг 1894, бүрэн дунд боловсролыг 1797 сурагч төгсөж, бага боловсролын стандарт хангалт 99.12, суурь боловсролын стандарт хангалт 98.8, бүрэн дунд боловсролын стандарт хангалт 99.9 хувьтай дүгнэгдсэн нь өмнө оны төгсөлтийн шалгалтын түвшинд байгаа ба улсын дундаж стандарт хангалтаас 15 хувиар дээгүүр байна.</p>

			Биелсэн 100%
		6. Олон улсын болон улсын олимпиадад медальт байр эзэлж, онцгой амжилт гаргасан сурагчдыг шагнаж урамшуулах.	<p>2008 онд улсын төрөлжсөн олимпиадад амжилттай оролцсон 13 сурагчийг 4.3 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.</p> <p>Энэ оны улсын олимпиадад 5 хичээлээр 12 сурагч байр эзэлснээс 4 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		7. “Эрдэнэт” цогцолбор сургуулийн I, II, “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн III, “Наран” цогцолбор сургуулийн I, II, “Орхон” цогцолбор сургуулийн II байрууд болон 2, 7, 14 дүгээр сургуулиудад их засвар хийх.	<p>“Эрдэнэт” цогцолбор сургуулийн хичээлийн I байрыг Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжүүлж буй “Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр II”-ийн хүрээнд 280.0 сая төгрөгөөр засварлав.</p> <p>Улсын төсвөөс “Наран”, “Эрдэнэт” цогцолбор сургуулийн хичээлийн I, II байрны дээврийн засварт 45.0 сая, орон нутгийн төсвөөс “Орхон” цогцолбор сургуулийн II байрны дээврийн засварт 15.1 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Дэлхийн банкны “Үр дүнд түргэн хүрэх санаачлага” төслөөс 7-р сургуулийн хичээлийн байранд их засвар хийхээр 30.0 сая төгрөг батлагдсан хэдий ч аваарын байдлаас шалтгаалан 17 дугаар сургуулийн уурын зуухыг засварлахаар хөрөнгийг шилжүүлэв. Мөн уг төслийн хүрээнд Жаргалант сумын сургуулийн дотуур байранд 94.0 сая төгрөгөөр их засвар хийлээ.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		8. Спортын гүнзгийрүүлсэн сургалттай “Орхон” цогцолбор сургуулийг спортын заалны хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах, “Эрдэнэт” цогцолбор сургуулийн I, “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн II, III, “Наран” цогцолбор сургуулийн I, II, “Орхон” цогцолбор сургуулийн I, II байрууд болон 2, 7, 14, 18 дугаар сургуулийн гаднах спортын талбайг тохижуулах.	<p>“Орхон” цогцолбор сургууль дээр хичээллэж байсан спортын мэргэжлийн сургалттай ангийг түшиглэн биеийн тамир, спортын мэргэжлийн сургалттай “Ирээдүйн одод” бие даасан дунд сургууль байгуулж, Дэлхийн банкны санхүүжилтээр 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.</p> <p>“Орхон” цогцолбор сургуулийн гаднах спорт талбайг орон нутгийн төсвөөс 9.6 сая, “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс 24.0 сая төгрөгөөр засварласнаас гадна уг төслөөс “Эрдэнэт” цогцолбор сургуулийн 1-р байр, 2-р сургуулийн спортын гаднах талбайг 33.0 сая төгрөгөөр тохижууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>

		<p>9. “Баян-Өндөр” цогцолборын Хөгжмийн сургуулийг үндэсний болон сонгодог хөгжмийн зэмсэг, урлагийн хувцас, хэрэгсэлээр хангах.</p>	<p>Хэрэгжиж эхлээгүй байна.</p> <p>Тасарсан.</p>
		<p>10. Сургууль бүрийг 2-4 мэдээлэл зүйн кабинеттай болгон, нэг компьютерт ноогдох хүүхдийн тоог бууруулж, нэгдсэн сүлжээ, интернетэд холбох.</p>	<p>“Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас “Орхон”, “Наран” цогцолбор, Жаргалант сумын сургуульд тус бүр 10, 7-р сургуульд 5 компьютер, БСШУЯ-аас 17-р сургуульд 10 компьютер бүхий кабинет, Азийн хөгжлийн банкнаас 17, “Ирээдүйн одод”, Жаргалант сумын сургууль, БСГ-ын “Бага боловсролын багшийг хөгжүүлэх сургалтын төв”-д нийт 16 компьютер нийлүүлж, сургуулиудын мэдээлэл зүйн танхимын тоо 5-аар нэмэгдэж, өмнөх онд нэг компьютерт 44 хүүхэд оногдож байсан бол 2009 онд 22.7 хүүхэд оногдож, сургалтын орчин сайжирлаа. Мөн сургуулиудын 76.9 хувь нь интернэтэд холбогдлоо.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>11. Сургуулиудын хоолны газрын тоног төхөөрөмжийг шинэчлэн, сурагчдад халуун хоолоор үйлчлэх боломжийг бүрдүүлэх.</p>	<p>БСШУЯ, “Үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл”-ээс 7-р сургуульд 8.2, Дэлхийн банкнаас “Ирээдүйн одод” дунд сургуульд 3.7 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэв.</p> <p>“Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд нийт сургуулиуд долоо хоногийн 3-4 хоногт сурагчдад халуун хоолоор үйлчилж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>12. Сургуулийн номын сангийн ашиглалтыг сайжруулж номын фондыг багш, сурагчдад нэн шаардлагатай номоор хангахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Хөдөөгийн боловсролыг дэмжих төслөөс Албан бус боловсролын төвд 320 хичээлээс гадуур унших ном, 38 төрлийн 245 дүйцсэн хөтөлбөрийн ном нийлүүлж, “Тогтвортой амьжиргаа II” төслөөс Жаргалант сумын сургуулийн номын санг 4.3 сая төгрөгөөр тохижууллаа.</p> <p>Ерөнхийлөгчийн санаачилгаар олгосон дэлхийн шилдэг 50 боть ном, АНУ-ын Элчин сайдын яамнаас буцалтгүй тусламжаар олгосон 10.0 мянган ам.долларын сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах, БСШУЯ-наас шилжилтийн 2.7-р ангийн хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмж, “Үр дүнд түргэн хүрэх санаачлага” төслөөс “6 настай суралцагч”, “Нийгмийн ажилтны үйлчилгээ”, “Дүрслэх урлаг” багшийн ном зэрэг</p>

			10-аад төрлийн 8.6 сая төгрөгийн номыг салбарын байгууллагуудад олгож, 2009 онд сургуулийн номын сангуудыг 40.0 орчим сая төгрөгийн номоор хангасан байна. Хэрэгжиж байна 50%
		13. Сургуульдаа унаагаар ирдэг сурагчдын унааны хөнгөлөлтийн асуудлыг шийдвэрлэх.	Төмөр замын “Эрдэнэт” өртөө өөрийн унаагаар вокзалаас 18-р сургуульд суралцдаг хүүхдийг өглөө, орой өдөрт 2 удаа зөөвөрлөж, шатахууны зардалд аймгийн Засаг даргын нөөц сангаас 2.6 сая төгрөгийг зарцуулж байна. Ахмадын үйлчилгээнд явдаг автобусыг өглөө Гэр хорооллын чиглэлээс хотын төвийн сургуулиудад суралцаж буй 4000 гаруй хүүхдүүдэд зориулан нэг удаа төлбөргүй явуулж байна. Биелсэн 100%
		14. Малчдын хүүхдийн дотуур байр байгуулах.	Спортын мэргэжлийн сургалттай дунд сургуулийг дотуур байртай байгуулж, Дэлхийн банкны санхүүжилтээр “Ирээдүйн одод” сургуульд 30.0 сая төгрөгийн ор, хөнжил, гал тогооны тоног төхөөрөмж зэргийг нийлүүлж, дотуур байранд 50 сурагч амьдарч байгаагаас 8 нь малчдын хүүхэд байна. Жаргалант сумын сургуулийн дотуур байранд малчдын 38 хүүхэд амьдарч байна. Хэрэгжиж байна 90%
1.1.3.	Албан бус боловсролын сургалтын орчинг сайжруулж, сургууль завсардсан хүүхдэд нөхөн боловсрол олгож, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил эзэмшүүлэх болон мэргэшлийн ур чадварын сургалтанд ажилгүй иргэдийг хамруулж, сургалтын үр дүнг нэмэгдүүлнэ.	1. Сургууль завсардсан сурагчдын 90 хувьд нөхөн боловсрол олгон, бичиг үсгийн боловсрол олгох дүйцсэн хөтөлбөрт сургалтанд жил бүр 80-аас доошгүй иргэнийг хамруулах. 2. Албан бус боловсролын төвийн “Түмэн-Од” хөдөлмөр зуслангийн үйл ажиллагааг дэмжин ажиллах. 3. Телевиз, богино долгионы радио, интернет ашиглан амьдрах ухааны зайны	Аймгийн хэмжээнд сургууль завсардсан 21 хүүхэд байгаагийн 5-ийг нь сургуульд буцаан оруулж, 8-ийг нь Албан бус боловсрол төвд хамруулаад байна. Өнгөрсөн хичээлийн жилд бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтаар суурь боловсролыг 19, бүрэн дунд боловсролыг 22 суралцагч эзэмшиж төгссөнөөс гадна энэ хичээлийн жилд 69 хүүхдийг шинээр хамруулав. Хэрэгжиж байна 90% Тайлант хугацаанд “Түмэн-Од” зуслангийн үйл ажиллагаа санхүүгийн асуудлаас шалтгаалан ажиллаагүй. Тасарсан. Долоо хоногийн 4 дэх өдөр бүр “Боловсролын цаг”, Мягмар, Баасан гаригуудад 2 удаа “Амьдрах ухаан”

		<p>сургалтыг сард 2-оос доошгүй удаа явуулах.</p>	<p>нэвтрүүлгийг хүргэж хэвшсэнээс гадна Боловсрол FM-107.6 радиогоор “Монголын нууц товчоо” зохиолоор бүтээгдсэн “Сонсдог драм” цувралыг 3-р сараас эхлэн өдөр бүр 2 удаагийн давтамжтайгаар “Орхон XXI зуун” мэдээллийн төвөөс эрхлэн нэвтрүүлж, нэвтрүүлгийн талаарх иргэдийн санал бодол, дараагийн нэвтрүүлгээр ямар мэдээлэл авах хүсэлтэй буй судалгааг утсаар авч ажиллаж байна.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран “Гялгар уутны хэрэглээнээс татгалзъя” сургалтыг иргэдэд болон 2, 7-р сургуулийн багш нарт явуулж, “Шинэ мэдээ” сонинд 4 цуврал хичээл, мэдээллийг хэвлүүллээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
		<p>4. Жилд 370-аас доошгүй иргэдийг мэргэжил олгох сургалтанд, 100-аас доошгүй иргэдийг албан бус секторт ажиллагсад, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах.</p>	<p>Итгэмжлэгдсэн эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран 16 төрлийн мэргэжлээр 19 удаагийн сургалт зохион байгуулж, 427 иргэнд зөөгч бармен, талх-нарийн боовчин, худалдагч-нярав, барилгын засал, чимэглэлчин, компьютерийн засварчин, сантехникч, үсчин зэрэг мэргэжлүүдийг эзэмшүүлснээс суралцагчдын 59.5 хувь нь мэргэжилгүй, нийгмийн эмзэг бүлэгт хамаарагдах иргэд байна. Албан бус секторт ажилладаг болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг 166 иргэнийг бизнес эрхлэх, аж ахуйн ур чадвар эзэмших сургалтад хамрууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
		<p>5. Мэргэжил олгох, зөвлөгөө өгөх сургалтын танхимыг шинэчилж, техник тоног төхөөрөмжөөр хангах.</p>	<p>Мэргэжил олгох, зөвлөгөө өгөх сургалтын танхимын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах зорилгоор 1.1 сая төгрөгийн өртөг бүхий компьютер, техник хэрэгслээр хангалаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>6. Мэргэжил олгох сургалтуудыг орон нутгийн сургалтын байгууллагуудыг түшиглэн явуулах.</p>	<p>НХХЯ-наас сургалтын байгууллагуудын дунд зарласан тендерт шалгарсан Технологийн сургууль тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин, автомашины завсарчин, бульдозерийн машинист зэрэг мэргэжлээр 64 хүнийг сургаж, 8.0 сая төгрөг, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв барилгын засал чимэглэлчин, сантехник, дархан-сийлбэрчин, мужаан</p>

			<p>зэрэг мэргэжлээр 72 хүнийг сургаж, 7.7 сая төгрөг, “ВВД” сургалтын төв барилгын засал чимэглэлчин, тогооч-талх нарийн боов, худалдагч-нярав мэргэжлээр 124 хүнийг сургаж, 9.3 сая төгрөг, “ТОДГ” сургалтын төв зөөгч-бармен, зочид буудлын үйлчилгээний ажилтан мэргэжлээр 40 хүнийг сургаж, 1.8 сая төгрөг зарцуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас суралцагчдын зардлыг санхүүжүүлсэн бөгөөд нийт 8 сургалтын байгууллагатай хамтран мэргэжлийн сургалт явуулсны 4 нь орон нутгийн байгууллагууд байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
1.1.4.	Их, дээд болон мэргэжлийн анхан ба дунд шатны сургууль байгуулах, сургалтын чанарыг сайжруулж, мэргэжлийн боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллана.	<p>1. МСҮТ-ийг уул уурхайн салбарын ажилтан бэлтгэх салбараар өргөжүүлэх, Хангайн бүсийн түшиц сургууль болгох.</p> <p>2. Мэргэжлийн сургуулиудыг спорт заал, оюутны дотуур байр бүхий оюутны сурах боломжийг бүрэн хангасан орчин бүрдүүлэх санаачлагыг дэмжих.</p> <p>3. Үйлдвэрлэлийн сургалт, дадлага хийх газар байгуулах, оюутны байр байгуулах санаачлагыг дэмжих.</p> <p>4. Олон улсын стандартад нийцэхүйц гадаадын дээд сургуулийн салбар байгуулах.</p>	<p>МСҮТ-ийг уул уурхайн чиглэлээр ажилтан бэлтгэх салбараар өргөжүүлэхээр судалгаа, тооцоо хийж, саналаа БСШУЯ-нд хүргүүлсэн хэдий ч дадлага хийх орчин нөхцөл бүрдээгүй гэдэг шалтгаанаар энэ жилийн хувьд хасагдсан бөгөөд орчин нөхцлөө сайжруулах чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлж эхлэв.</p> <p>Хангайн бүсийн түшиц сургууль болох эдийн засгийн болон санхүүгийн нөөцийн судалгаа, тооцооны ажлыг 2010 онд хийхээр төлөвлөж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p> <p>МУИС-ийн ОАСС спорт заал барихаар зураг, төслийн ажлыг хийж гүйцэтгэн, төлөвлөсний дагуу барилгын ажил эхлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p> <p>“Баянсацо” ХХК нь Дэнж багт байрлах ашиглагдахгүй байсан “Баян дэнж” худалдааны төвийг засварлан 48 оюутны дотуур байр ашиглалтанд оруулав.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p> <p>Технологийн сургуулийг түшиглэн Оюутны хотхон бүхий орчин үеийн сургууль байгуулахаар төлөвлөсний дагуу сургуулийн хотхоны газрыг холбогдох газрууд судлан тогтоож, БСШУЯ-нд саналаа хүргүүлсний дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр байгуулахаар шийдвэрлэгдлээ.</p>

			Хэрэгжиж байна 10%
		5. МУИС-ОАСС-ийн дэргэд “Бүсийн Эрдэм шинжилгээний төв” байгуулах.	МУИС-ОАСС нь эрдэм шинжилгээний төв байгуулах төсөл, хөтөлбөрөө боловсруулж байгаа ба холбогдох газруудад саналаа хүргүүлсэн болно. Хэрэгжиж байна 10%
1.1.5.	Боловсролын салбарыг мэргэжлийн өндөр чадавхитай боловсон хүчнээр бүрдүүлж, тэдний мэргэжил дээшлүүлэх, нийгмийн асуудлыг дэс дараатай шийдэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	1. Багш, эмч нарын “Нийгмийн дэмжлэгийн сан”-гийн хөрөнгийг жил бүр 10.0-аас доошгүй сая төгрөгөөр нэмэгдүүлэх.	Нийгмийн дэмжлэгийн сангийн хөрөнгийг орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тайлант онд 260 ажилтанд 8.1 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг, 22 хүнд 4.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Хэрэгжиж байна 50%
		2. Багш нарыг ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд шаардлагатай орчин нөхцөл бүрдүүлэх.	Сургууль бүр багш нарын мэргэжил дээшлүүлэх “Багшийн хөгжлийн төв” байгуулан тохижуулснаас гадна БСГ-ын дэргэд Байгалийн ухаан, Бага боловсрол, Биеийн тамир-Эрүүл мэнд, Технологи, Хөгжим, Мэдээлэл зүй-Зайны сургалтын төв, Солонгос хэл, соёлын төвүүдийг тус тус байгуулан, аймгийн төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран 24 удаагийн сургалтыг явуулж, төвлөрсөн ба төвлөрсөн бус сургалтад давхардсан тоогоор 3000 гаруй багш, удирдах ажилтан хамрагдав. Монголын багш нарын хөгжлийг дэмжих нийгэмлэгийн Орхон аймгийн салбар зөвлөлийг байгуулж, “Монголын багш нарын өмнө тулгамдаж буй асуудлууд, багшийн хөгжлийг хангах арга замууд” хэлэлцүүлгийг бүх түвшний боловсролын салбарын төлөөлөлтэй зохион байгууллаа. Мөн багш нарыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр ХУИС-ийн Эрдмийн сургуультай хамтран магистрын сургалтыг боловсрол судлал, хэл шинжлэлийн чиглэлээр, “Маргад” дээд сургууль, УБИС-тай хамтарч технологийн багш, мэдээлэл зүйн багш бэлтгэх сургалтыг орон нутагт зохион байгуулан явуулж байгаа нь багш нарын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэж байна. Хэрэгжиж байна 70%
		3. Хөрвөх чадвартай багш бэлтгэх	Мэдээлэл зүйн чиглэлээр хөрвөх багш бэлтгэх

	сургалтууд зохион байгуулах.	сургалтыг 2 дахь удаагаа зохион байгуулж, 45 багш хамрагдаж байна. Хэрэгжиж байна 50%
	4. Боловсролын салбарын аймгийн зөвлөлийг байгуулж, салбарын үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зөвөлгөө өгч ажиллах.	Аймгийн Боловсролын зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулав. Зөвлөл нь Боловсролын салбарт тулгамдаж буй асуудал, Эрдмийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар, холбогдох ажлыг зохион байгуулж, аймгийн Боловсрол соёлын газарт үүрэг даалгавар өгөн ажиллаж байна. Хэрэгжиж байна 70%
	5. Цэцэрлэгийн тогооч, хоол бэлтгэгч, үйлчлэгч нарт илчлэг, чанартай хоол хүнс бэлтгэх, цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийх талаар сургалтыг улирал бүр зохион байгуулах.	Нийгмийн дэмжлэгийн сангаас сургууль, цэцэрлэгийн 24 эмчид 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн Улаанбаатар хотод хүүхдийн хоол, хүнсний эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр сургалтанд хамрууллаа. Хэрэгжиж байна 30%
	6. Жил бүр багш нарыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж, эрүүл мэндийг сахин хамгаалах ажлыг үе шаттай зохион байгуулах.	Сургууль, цэцэрлэгийн багшийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах ажлыг тусгай графикайн дагуу зохион байгуулан, багш нарыг бүрэн хамруулж эрүүл мэндийн байдлыг байгууллагын эмч хяналтандаа авч ажиллаж байна. Хэрэгжиж байна 90%
	7. ОХУ-ын Буриад улстай багш нарын мэргэжил дээшлүүлэх, багш солилцон ажиллуулах, амраахаас гадна мэргэжлийн олимпиад, урлаг, спортын арга хэмжээ хамтран зохион байгуулах.	ОХУ-ын Улаан-Үд хотын Боловсролын газартай хамтран ажиллах гэрээний дагуу “Байкальские волны” хүүхдийн зусланд 20 хүүхэд, Орос хэлний багш нарыг амраав. Хэрэгжиж байна 50%
	8. Багш, арга зүйчдийг гадаадад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Ертөнц дахины Энх тайвны Монголын холбооны шугамаар БНСУ-ын Чэжү арал дээр “Гэр бүл, энх тайван, эрүүл мэнд”-ийн сэдвээр 7 хоногийн сургалтад БСГ-ын Биеийн тамир, эрүүл мэндийн сургалт хариуцсан мэргэжилтэн хамрагдан, сургалтын төлбөрт 1300 ам.доллар зарцуулав. Удирдлагын менежмент, Ертөнц дахины Энх тайвны холбооноос зохион байгуулсан ёс зүйн сургалтад хамрагдаж, 20 багш, удирдах ажилтан БНХАУ, ОХУ, Япон, Солонгос, АНУ-д мэргэжил дээшлүүлэн, гадаадын ерөнхий боловсролын дунд сургуультай танилцаж,

			туршлага судаллаа. Хэрэгжиж байна 90%
		9. Боловсролын салбарт ажиллаж буй гадаадын сайн дурын ажилтнуудыг багш нарын мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх ажилд татан оролцуулах.	Боловсролын салбарт АНУ-ын Энх тайвны корпусаас 2, БНСУ-ын Койка олон улсын байгууллагаас 1, БНХАУ-аас 5, АНУ-аас "Eagle" сургуулийн урилгаар 1, Туркээс 12 нийт 21 гадаадын мэргэжилтэн ажиллаж байна. Гадаадын мэргэжилтнүүдтэй хамтран Англи хэлний олимпиад зохион байгуулсанаас гадна мэргэжил, арга зүйн сургалтыг 2 удаа 50 багшийг хамруулан зохион байгууллаа. Мөн сайн дурын ажилтнууд сургуулийнхаа багш нарт тусгай хөтөлбөрийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтууд хийж, хамтран хичээл зааж, ярианы хичээлийг явуулж байна. Хэрэгжиж байна 90%
1.1.6.	Уран бүтээлчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулах замаар уран бүтээлийн чанар, хүртээмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ ардын авъяастныг нээн илрүүлж, дэмжин ажиллана.	1. Уран бүтээлчдийг мэргэжлийн төрөлжсөн сургалт, уралдаануудад тасралтгүй оролцуулж, төрөл бүрийн арга хэлбэрээр уран бүтээлийг тайлагнах.	2009 онд мэргэжлийн уран бүтээл 2, уран сайханчдын тайлан тоглолт 4 удаа явагдаж, улсын уралдаанд 3 уран бүтээлч, цэнгээнт бүжгийн 4 хамтлаг оролцоод байна. Морин хуурч, хөөмийч "Хөөмийн олон улсын симпозиум" наадамд, "Эрдэнэт" дуу бүжгийн чуулга Унгар улсын Секешфехевар хотод явагдсан "Хааны өдрүүд" олон улсын наадамд амжилттай оролцлоо. Дуу бүжгийн чуулга "Бид нэг гэр бүл" концертоо МҮОНТВ-д, Хүүхэлдэйн театр хошин шогийн хөтөлбөрөө Өвөр Монголын "Одон" телевизэд бичүүллээ. БСШУЯ, Соёл, урлагийн хороо, Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын газар хамтран зохион байгуулсан "Сайн ноён хан аймгийн уртын дууны наадам"-д манай аймгаас 6 хүн оролцон 1 алт, 1 мөнгөн медалиар шагнагдаж 1 уран бүтээлч тусгай байранд шалгарлаа. Аймгийн Номын төв нь өөрийн номын санч 15, сургуулийн номын санч 19, дээд сургуулиудын номын санч 5 нийт 39 хүнд 3 удаагийн сургалт явуулж төв, орон нутгаас багш нарыг урин хичээл заалгаж мэргэжил дээшлүүлэв. Хэрэгжиж байна 70%

		<p>2. Уран бүтээлчдийн сонгон шалгаруулалтыг жилдээ 1-ээс доошгүй удаа явуулах.</p>	<p>Уурхайчин соёлын ордон УБ хотоос Урлагийн гавъяат зүтгэлтэн Ч.Сангидорж ахлагчтай 3 хүний бүрэлдэхүүн бүхий түвшин тогтоох баг урин ажиллуулж, “Эрдэнэт” чуулгын уран бүтээлчдийг аттестатчилав. Ур чадварын хувьд шаардлага хангаагүй зарим уран бүтээлчидтэй гэрээ цуцлах арга хэмжээ авч байна.</p> <p>Хүүхэлдэйн театр өөрийн уран сайхны зөвлөлийн хүрээнд ур чадварын шалгалт явууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		<p>3. Хүүхдийн ордон-Хүүхэлдэйн театр болон мэргэжлийн урлагийн байгууллагуудын бүтэц, хэлбэрийг сайжруулах.</p>	<p>Хүүхдийн ордон-Хүүхэлдэйн театрын бүтэц зохион байгуулалтыг өөрчилж Орхон аймгийн “Хүүхэд залуучуудын театр” нэртэй болгож, дагнасан мэргэжлийн урлагийн байгууллагын бүтэц, хэлбэртэйгээр өөрчлөх асуудлыг холбогдох судалгаа, саналын хамт БСШУЯ-нд хүргүүлэв.</p> <p>Уг асуудлаар БСШУЯ дэмжсэн хариу ирүүлж, бүтцийг өөрчлөх бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Ардын авъяастныг нээн илрүүлэх, урамшуулах арга хэлбэрийг боловсронгуй болгох.</p>	<p>БСШУЯ-наас ирүүлсэн маягтын дагуу биет бус соёлын өвийг тээгч ардын авъяастнуудын судалгааг гаргаж байна.</p> <p>Ардын авъяастан уран сайханч 100-аад хүний материал бүрдүүлэн түүндээ тулгуурлан Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан” номыг хэвлүүлсэн.</p> <p>Өмнөх онд улсын чанартай уралдаанаас тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчид, авъяаслаг хүүхдүүдэд 240.0 мянган төгрөгийн урамшуулал олгосны зэрэгцээ 5 хүнийг аймгийн Засаг дарга, ИТХ-ын шагналаар шагнаж урамшууллаа.</p> <p>Төвийн бүсийн аймгуудын Хүүхдийн урлагийн наадмыг урлагийн 4 төрлөөр зохион байгуулж, 5 аймгийн 45 авъяастан сурагч, морин хуурын 3 хамтлаг оролцлоо.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
<p>1.1.7.</p>	<p>Иргэдийн соёл мэдээллийн нийтлэг хэрэгцээг хангагч байгууллагуудад</p>	<p>1. Музейн үзмэр, түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, баяжилтыг сайжруулж, сургалт танин мэдэхүйн хөтөлбөрт хамралтыг 30 хувьд хүргэж,</p>	<p>2009 онд сан хөмрөгийн баяжилтаар 15 нэр төрлийн үзмэрийг 1.9 сая төгрөгөөр худалдан авлаа. Мөн улсын тооллогын мөрөөр Үндэсний түүхийн музей дээр зохион байгуулагдсан үзмэр солилцоогоор бусад</p>

	<p>үйлчилгээний шинэ арга хэлбэрийг нэвтрүүлэх, орчин нөхцлийг нь сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.</p>	<p>үзэгчдийн тоог өмнөх 4 жилийн дундажаас 15 хувиар нэмэгдүүлэх.</p>	<p>музейгээс 221 үзмэр шилжүүлэн авч, үзэсгэлэн гаргалаа. Музейн сан хөмрөгийг биологийн хортонгоос хамгаалах хор цацах, гэрлийн хүчдэл бууруулах, цэвэрлэгээ арчилгааг сайжруулах арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Сургалт танин мэдэхүйн чиглэлээр боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж, сурагчдын амралтаар тусгай хуваарь гарган, сурагчдыг музей үзүүлэх, уламжлалт тоглоом наадгай зааж сургах, тоглуулах, үндэсний тоглоом наадгайн танхим ажиллуулж мэдээллийн хэрэгслээр сурталчлах, аймгийн хэмжээний дурсгалт газруудын маршрут гаргаж, тойрон аялал зохион байгуулах зэргээр соёл хүмүүжлийн 7 ажил, сургалт танин мэдэхүйн 21 арга хэмжээ, 3 удаа үзэсгэлэн зохион байгууллаа.</p> <p>2009 онд нийт 5609 хүнд үйлчилснээс 3731 хүүхэд хамрагдсан ба нийт 1.9 сая төгрөгийн орлого орсон байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
	<p>2. Музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах.</p>	<p>Музейн барилгын зураг төсвийн ажил хийгдсэн бөгөөд 2010 оноос хэрэгжихээр төлөвлөгдсөн болно.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 10%</p>	
	<p>3. Түүхийн дурсгалт газар, хэрэгсүүрийн тооллого явуулж, бүртгэлжүүлэх.</p>	<p>Баянцагаан багийн нутаг дэвсгэр дээр байгаа айлын хашааны газарт орсон дурсгалуудыг газар дээр нь үзлэг хийж хяналт тогтоон холбогдох байгууллагад мэдэгдлээ.</p> <p>Жаргалант сумын Айргийн гозгор, Дулаан уул, Дэл хад зэрэг 32 үл хөдлөх дурсгалыг бүртгэн авч байрлалыг JPS-р тодорхойлсон ба зураг картыг бүрдүүллээ.</p> <p>Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг Хадтай уул, Өндөрлөг зэрэг 4 газрын үл хөдлөх түүх, соёлын дурсгалт зүйлийн тодорхойлолт байршлыг тодорхойлон бүртгэсэн ба дээр дурьдсан газруудыг хамгаалалтанд авах зорилгоор МУИС-ийн Археологийн тэнхимийн багш, оюутнуудтай хамтарсан малтлага хийлээ.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын Чингэлийн голын сав дагуух эртний булш,</p>	

			хиргисүүрүүдийн зэрэглэлийг тогтоон аймгийн хамгаалалтанд авлаа. Хэрэгжиж байна 90%
		4. Номын төвийн үйл ажиллагааны бүртгэл мэдээллийг бүрэн автоматжуулах техникийн нөхцлийг бүрдүүлэх.	Номын төвийн үйл ажиллагааны бүртгэл мэдээллийг бүрэн автоматжуулах техникийн нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн тооцоог хийж, БСШУЯ-нд хөрөнгийн асуудлыг тавиад байна. Хэрэгжиж байна 30%
		5. Уншлага үйлчилгээнд хамрагсдын тоог жил тутам 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх.	2009 онд Номын төвд 5820 хүн шинээр карт нээлгэж, давхардсан тоогоор 44921 хүн үйлчлүүллээ. Зөврөөр ном уншуулах аргыг сэргээн ашиглаж эхэлсэн нь үр дүнгээ өгч байна. Мөн 636 нэрийн 993 номоор баяжилт хийж, 107.7 мянган төгрөгийн ном хэвлэл олгож, 4675.3 мянган төгрөгийн ном, соёлын бараа худалдан борлуулаад байна. Хэрэгжиж байна 50%
		6. Номын төвийн өргөтгөлийг ашиглалтанд оруулах .	Номын төвийн өргөтгөлийн барилгын зураг хийгдэж хөрөнгийн асуудлаар БСШУЯ-нд санал тавиад байна. Хэрэгжиж байна 30%
		7. Соёлын төвүүдийн ажил үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлж, соёлтой, тохилог орчинг бүрдүүлэх .	Соёлын төвүүдийн орчинг сайжруулах зорилгоор “Тогтвортой амьжиргаа II” төслийн санхүүжилтээр Баян-Өндөр соёлын төвд 13.1 сая, Эгшиглэн 14.7 сая нийт 27.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангав. Аймгийн соёлын зөвлөлөөс соёлын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийн аймаг, сумын Засаг дарга нарт холбогдох үнэлгээг хүргүүллээ. Энэ ажлын мөрөөр “Уурхайчин” соёлын ордонтой хамтран соёлын төвийн ажиллагсдыг “Соёлын ажлын арга зүй”, “Хөтлөгчийн уран чадвар” сэдэвт сургалтуудад хамрууллаа. Соёлын төвүүд ардын авьяастнуудыг дэмжих зорилгоор уламжлалт бий биелгээ, ардын дуу, ардын аман зохиолын чиглэлээр клубууд нээн ажиллуулах, тэднийг сурталчлах, уралдаан зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хэрэгжиж байна 50%

		8. Алслагдсан 2-3 багт соёл мэдээллийн төв шинээр байгуулах.	Алслагдсан багуудад соёлын төв барих асуудлыг соёл, спортын хосолмол зориулалттай байх бодлого баримталж байгаа бөгөөд уг ажлыг 2010 оноос хэрэгжүүлж эхлэхээр уг төлөвлөгөөнд тусгасан болно. Хугацаа болоогүй.
		9. Жаргалант сумын “Соёл, мэдээллийн төв”-ийн заалны халаалтын асуудлыг шийдвэрлэх.	Соёлын төвийн халаалтын системийг шинэчлэх тооцоо хийгдэж, орон нутгийн төсвөөс 8.2 сая төгрөг батлагдан, Жаргалант сумын соёл, мэдээллийн төвийн заалны халаалтыг бүрэн шинэчилж, үйл ажиллагаа хэвийн явуулж байна. Биелсэн 100%
		10. Соёлын төвүүдийн номын санг өргөжүүлэх.	Соёлын төвүүд номын сангаа өөрсдийн нөөц бололцоонд түшиглэн өргөжүүлж, “Эгшиглэн” Соёлын төв нь 12 суудалтай уншлагын танхим, Жаргалант сумын соёл мэдээллийн төв нь шинээр 10 суудалтай уншлагын танхимтай болсон. “Дэлхийн Зөн” ОУБ “Хүний хөгжлийн төв”-ийг Шанд багт байгуулан, номын сангийн үйлчилгээ явуулах танхим гаргаж, ширээ сандал, номын тавиураар хангаж, материаллаг нөхцөл бүрдүүлэв. БСШУЯамнаас сургуулийн номын сангуудад түгээсэн 100 гаруй нэр төрлийн 2.0 сая төгрөгийн өртөгтэй номыг 3 соёлын төвд 2 иж бүрдлийг олголоо. Хэрэгжиж байна 50%
1.1.8.	Аймгийн соёлын салбарын ирээдүйн хөгжлийн төлөв байдлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулна.	1. Соёлын салбарын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулах.	Монгол улсын соёл урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд оруулах саналаа нэгтгэж, БСШУЯ-нд хүргүүллээ. Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах болсны улмаас Мастер төлөвлөгөө 2009 онд батлахгүй болж үүнтэй холбогдуулан боловсруулах урт хугацааны хөгжлийн хөтөлбөр хойшлогдож байна. Хэрэгжих шатандаа 10%
		2. Уурхайчин соёлын ордон, “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн Хөгжмийн сургуулийн материаллаг баазыг түшиглэн бүсийн сургалтын төв байгуулах ажлыг БСШУЯамны бодлоготой уялдуулан зохицуулах.	Орон нутгийнхаа соёлын байгууллага тухайлбал “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн Хөгжмийн анги, “Уурхайчин” соёлын ордны материаллаг болон хүний нөөц дээр тулгуурлан бие даасан Хөгжмийн сургууль байгуулах асуудлыг Монгол улсын Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд санал

			<p>хэлбэрээр хүргүүлэв. Үүнтэй холбогдуулан баруун бүс нутгийн сургууль буюу Завхан аймгийн Хөгжмийн коллежийн туршлагыг судлах арга хэмжээг 2010 оны 1-р сард зохион байгуулав.</p> <p>Хэрэгжих шатандаа 30%</p>
		3. Соёлын байгууллагуудын их засвар, хөрөнгө оруулалтыг жил бүрийн үндсэн чиглэл, төсөвт тусгаснаар үйлчилгээний соёлтой тохилог орчин бүрдүүлэх.	<p>Соёлын төвүүдийн орчинг сайжруулах зорилгоор “Тогтвортой амьжиргаа II” төслийн санхүүжилтээр Баян-Өндөр соёлын төвд 13.1 сая, Эгшиглэн 14.7 сая нийт 27.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил нийлүүллээ.</p> <p>Мөн Жаргалант сумын Соёлын төвийн халаалтын системийг шинэчлэв.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
1.1.9.	Хүүхдийн нийгмийн хамгааллыг тогтолцоог боловсронгуй болгоно.	1. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийн, эрчимжүүлэх.	<p>Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар багийн Засаг дарга нарын бүрэн эрхийн хэрэгжилтэд мониторинг хийв. /Баян-Өндөр сумын 19 багийн Засаг дарга нар хамрагдлаа/.</p> <p>Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах гурав дахь шатны үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилтэд 5 зорилтын хүрээний 38 үзүүлэлтээр мониторинг хийж дүгнэхэд хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт 98.5 хувьтай дүгнэгдлээ.</p> <p>Биелсэн 100%</p>
		2. ЕБС, цэцэрлэг, зуслангуудын эрүүл ахуйн орчны чанарыг дээшлүүлэх чиглэлээр боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн болон хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах.	<p>Сургууль, цэцэрлэгийн орчны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилгоор аймгийн сургууль, цэцэрлэгүүдийн дунд “Сургалтын эрүүл аюулгүй орчин бүрдүүлье” сэдэвт жилийн аяныг зохион байгуулж дүгнэлээ.</p> <p>2008-2009 оны хичээлийн жилд “Сургууль, цэцэрлэгийн орчны эрүүл ахуйг сайжруулъя” аяныг зохион байгуулж, аянд ерөнхий боловсролын 16 сургууль, 18 цэцэрлэг хамрагдаж хамрагдаж байсан сургуулиудад боловсролын стандартад нийцсэн эрүүл мэндийн 6, чийрэгжүүлэлтийн 6, биеийн тамирын 4 танхимыг ажиллуулж байгаа нь үр дүнгээ өгч байна.</p> <p>Сар бүр зохион байгуулж буй эрүүл мэндийн өдөрлөгийг “Хамуу өвчнөөс сэргийлье”, “Орчны эрүүл</p>

			<p>ахуйг сайжруулъя”, “Сүрьеэгийн халдвараас сэргийлье, “Халдварт өвчнөөс сэргийлье”, “Тамхины хор хөнөөлөөс сэргийлье”, “Гараа зөв угааж хэвшье, гарын ариун цэврийг сахъя”, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлье” сэдвүүдээр зохион байгуулж, давхардсан тоогоор 552 багш, ажиллагсад, 6857 эцэг эх, 23000 хүүхэд хамрагдаж, өдөрлөгийн үеэр 121 сурталчилгааны самбар, 519 зурагт хуудас, 3918 гарын авлага материал тарааж, нийтийн хүртээл болгов.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн нөхцөлд сурч боловсрох хөгжих боломжийг сайжруулах.</p>	<p>Манай аймагт хөгжлийн бэрхшээлтэй 330 хүүхэд байгаагаас 95 нь гэртээ байнгын асаргаатай хэвтэрт байдаг хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн тусгай бүлэгт 60 хүүхэд, ердийн бүлэгт 104 хүүхэд, цэцэрлэгт 31 хүүхэд сурч хүмүүжиж, сургууль, цэцэрлэгт хамрагдалт 62 хувьтай байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооноос санаачлан хүүхдүүдийн дунд шүрэн эдлэлийн дугуйланг ажиллуулж, дугуйлангийн зардлыг халамжийн зардлаас хариуцаж байна.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр орон нутгаас хөгжлийн бэрхшээлтэй гэрийн хэвтэрт байгаа 10 хүүхдэд 150.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгов.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>4. Хүүхдийн эрх, нийгмийн хамгаалал дахь төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоог нарийвчлан тогтоох.</p>	<p>Аймгийн хэмжээнд хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын хүлээх үүрэг, оролцоог аймгийн Хүүхдийн төлөө хэлтсээс холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээр зохицуулан ажиллаж байна.</p> <p>ХБХ-ийн эцэг эхийн холбоо, “Дэлхийн Зөн” ОУБ-ын ЭНХХ, Найдвар төв. Боломж төсөл, Кристина Нобел сангийн ХИТХ, “Миний гэр” цэцэрлэг зэрэг төсөл хөтөлбөр үйл ажиллагаа явуулж, эдгээр төсөл хөтөлбөрт 3287 хүүхэд хамрагдаж байна</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дараах 6 зарчмыг</p>

			<p>хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хүүхдийн нас, бие бялдар, сэтгэхүйн онцлогт тохирсон эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх. ✓ Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмнэлгийн байгууллагуудтай хамтран ажиллах. ✓ Хүүхдийн өсөлт хөгжилтөнд хяналт тавьж баталгаатай хоол хүнс хувцас, тоглоом бусад шаардлагатай зүйлээр хангах. ✓ Нэн ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх хүүхэд гэр бүлийг хамтатган авч үзэх. ✓ Хүүхдийн хамгааллын бүхий л үйл ажиллагаа, үйлчилгээ хүүхдийн эрхэд суурилсан байх. ✓ Хүүхдийг эрсдэлгүй орчинд эсэн мэнд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагын хамтын оролцоонд түшиглэх. <p>“Дэлхийн Зөн” ОУБ-ын ЭНХХ-ийн хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр нь эмзэг бүлгийн хүүхдүүдээс тусгай шалгуураар сонгон авч, Баян-Өндөр сумын 9 баг, Жаргалант сумын 3 багийн 3080 хүүхэд гэр бүлийг хамруулан дэмжлэг тусламж үзүүллээ.</p> <p>Жи Си Эс олон улсын байгууллагаас санхүүждэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “Найдвар” төв тогтмол үйл ажиллагаа явуулж, 20 хүүхэд хамрагдаж байна.</p> <p>Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгээс санхүүждэг сонсгол хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан “Боломж” төсөл хэрэгжиж, энэ онд 8 хүүхдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлж, 10 гаруй хүүхдийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулж, давхардсан тоогоор 40 гаруй хүүхдэд сургалт зөвлөгөө өгсөн.</p> <p>Кристина Нобел сангийн тусламжийн хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт хамрагддаг 32 хүүхдийн гэр бүлд сар бүр 35.0 мянган төгрөгийн тэтгэлэг өгдөг нь үр дүнгээ өгч байна.</p> <p>Си Эм Сэ олон улсын байгууллагын төслөөс</p>
--	--	--	--

			<p>Рашаант Шанд багийн эмзэг бүлгийн айл өрхийн 4-5 настай 60 хүүхдийг “Миний гэр” цэцэрлэгт хамруулж, хүүхдийн хоол хүнсийг бүрэн хариуцаж, эцэг эх, гэр бүлд нь туслаж, амьжиргааг нь дээшлүүлж байна. Төслөөс гэр хороололд тохилог номын сан, интернетийн төв, цэцэрлэгийн шинэ байртай боллоо.</p> <p>Аграпа олон улсын байгууллагаас санхүүждэг “Гэр” цэцэрлэг нь Говил багийн эмзэг бүлгийн айл өрхийн 40 хүүхэд, өдөр өнжүүлэх бүлэгт 20 хүүхэд хамруулан, гэр бүлд нь халамж үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
1.1.10.	Хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх нөхцлийг сайжруулж, тэдний хөгжлийг дэмжин, төлөвших явцад нь эерэг нөлөө үзүүлнэ.	1. Хичээлээс гадуур зохиогддог соёл, спорт, хүүхэд хөгжүүлэх олон нийтийн арга хэмжээг аймгийн нэгдсэн төлөвлөгөөгөөр зохицуулж, тэдгээрт хамрагдалтын хувийг ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын 40 хувьд хүргэх.	<p>ЕБС болон сургуулиас гадуур явагддаг дугуйлан секцэнд нийт сурагчдын 42.2 хувь нь буюу 8000 гаруй хүүхэд хамрагдаж, өөрсдийн авъяас чадвараа хөгжүүлж байна. 2009 онд нийт 157 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 118024 хүүхэд хамрагдлаа. Үүнээс урлагийн 27, спортын 12, уулзалт, ярилцлага 25, аян өдөрлөг 17, судалгаа 6, сургалт 21, бусад 67 арга хэмжээг зохион байгууллаа.</p> <p>Мөн хүүхдийн эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн өдөрлөгүүдийг сар бүр тодорхой сэдвүүдээр зохион байгуулж, давхардсан тоогоор 80.0 мянга гаруй хүүхдийг хамрууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		2. Хүүхдийн ордонг ашиглалтад оруулж, хүүхдийн хөгжлийн төв байгуулах.	<p>Хүүхдийн ордонг орон нутгийн өмчид авч, улсын төвлөрсөн төсвөөс 200.0 сая төгрөг батлагдан барилгын ажлыг үргэлжлүүлж, ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		3. Хүүхдийн өөрөө удирдах ёсны буюу оролцооны байгууллагыг дэмжин, хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	<p>НҮБ-ын хүүхдийн сантай хамтран Хүүхдийн өөрөө удирдах ёсны буюу оролцооны байгууллагыг дэмжин хөгжүүлэх, чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүллээ.</p> <p>Аймгийн хэмжээнд хүүхдийн оролцооны 27 байгууллагад 9.0 мянга гаруй хүүхэд хамрагдаж, 17 сургуулийн өөрөө удирдах зөвлөлийн дэргэд өсвөр үеийн оролцоо, мэдээлэл харилцаа холбоо, хүүхдийн эрх, бусдын төлөө, эрүүл мэнд, эрүүл амьдралын төлөө, хүүхдийн хөгжил, ёс суртахуун, гишүүнчлэл</p>

			<p>зохицуулалт, утга зохиолын зэрэг 7 секторт 420 хүүхэд гишүүнчлэлээр бүртгэгдэж, үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл энэ жилээс сургуулиуд дээр ажиллах журам, хуваарь гарган, 12 сургууль дээр ажиллав. Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн удирдах зөвлөлд байх Хүүхдийн парламентийн төлөөлөгчид сар бүр өөрийн сургууль дээр хүүхдэд нөлөөлөх чиглэлээр зохиосон ажлаа танилцуулж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж гарган ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн оролцооны байгууллагын нэрэмжит өдөрлөгийг 8 сургууль дээр зохион явуулж, өдөрлөгт давхардсан тоогоор хүүхдийн оролцооны 15 байгууллагын 600 хүүхэд, 150 ангийн дарга хамрагдсан.</p> <p>Сайн үйлсийн аяны хүрээнд хүүхдийн оролцооны байгууллагуудын оролцоотойгоор 14 удаагийн арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, Хот тохижуулах газрын ажиллагчдыг хамруулан зохион байгуулсан.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
		<p>4. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангах зорилгоор хүүхдийн редакци байгуулан, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээтэй ажиллах.</p>	<p>Хүүхдийн редакцийг шинээр байгуулан телевиз, радио FM, сонины редактор, өсвөрийн сэтгүүлч, сурвалжлагч хүүхдүүдийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн байгууллагуудаас хэвлэлийн бага хурал 4, телевизийн шууд ярилцлага 4, телевизийн нэвтрүүлэг 3, сонин хэвлэлд 8 мэдээ мэдээлэл, нэвтрүүлгийг явуулж, олон нийтийн хүртээл болголоо.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үндэслэн “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн эрхийг хамгаалах, хянах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг боловсруулан, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл аймгийн салбар зөвлөл болон орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй хэвлэл мэдээллийн 12 байгууллага нэгдэн</p>

			гарын үсэг зурж, хамтран ажиллах шийдвэрийг гаргалаа. Хэрэгжиж байна 50%
		5. Хүүхдэд эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэгдсэн цуврал арга хэмжээний хөтөлбөр, графикийг олон нийтийн оролцоонд түшиглэн боловсруулж, хэрэгжүүлэх.	Хүүхдэд эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр цуврал арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр цуврал лекц 8, урлаг, спортын уралдаан, тэмцээн 14, бусад арга хэмжээ 12-г зохион байгуулж, 12159 хүүхэд хамрууллаа. Хэрэгжиж байна 70%
		6. Хүүхдийн байгууллага, зуслангуудын материаллаг бааз, хангамжийг сайжруулж, жил бүр зусланд 2500-аас доошгүй хүүхдийг амруулах.	2009 онд аймгийн хэмжээнд хүүхдийн зусланд 2680 хүүхэд амраалаа. “Янзага” зуслан байгууллагын дотоод нөөц бололцоог дайчлан 16 хүүхэд амрах нэг байрыг барьж ашиглалтанд орууллаа. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Найрамдлын Эрдэнэс” зуслангийн орыг шинэчлэхэд болон үйлчилгээнд зориулж, 125.0 сая төгрөг зарцуулав. Хэрэгжиж байна 90%
1.1.11.	Залуучуудын талаар баримтлах бодлогын цөмийг оюутан, залуу гэр бүлийн нийгмийн асуудлыг дэмжин туслахад чиглүүлнэ.	1. Залуучуудыг дэмжих аймгийн хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх.	“Орхон аймгийн Залуучуудын хөгжлийн 2009-2012 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж батлууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжиж байна 70%
		2. Оюутнуудад унааны хөнгөлөлт үзүүлэх.	Оюутны унаа тээврийн асуудлыг хөнгөвчлөх чиглэлээр төрийн захиргаа, зорчигч тээврийн байгууллага, Оюутны холбооны гурвалсан судалгааг үндэслэн туршилтын журмаар ердийн тарифаас 50 төгрөгийн хөнгөлөлттэйгээр 2 чиглэлд автобус явуулж туршилт хийлээ. Одоогийн байдлаар МУИС-ийн ОАСС-ийн оюутнуудад “ББ-Од” ХХК 50 төгрөгийн хямдралтай үйлчилж байна. Хэрэгжих байна 70%
		3. Аймгийн Оюутны болон Залуучуудын холбоодтой гэрээ байгуулсны үндсэн дээр дэмжиж ажиллах.	Оюутны холбоо болон Залуучуудын холбооноос гаргасан санал санаачлагыг дэмжиж хамтарч ажиллалаа. Сургуулийн захиргаа болон Оюутны холбооны тодорхойлолтыг үндэслэн 2009 оны шилдэг оюутнаар Технологийн сургуулийн болон МУИС-ийн

			<p>ОАСС-ийн III курсын 2 оюутныг шалгаруулж, тэтгэлэг олголоо.</p> <p>Хангайн бүсийн их, дээд сургуулиудын оюутны ерөнхий эрдмийн олимпиадыг 5 төрлөөр зохион байгуулж, 4 аймаг хотын 43 оюутан оролцож, багийн дүнгээр манай аймгийн баг тэргүүн байр эзлэв. Олимпиадын ажиллагаанд зориулж, орон нутгийн төсвөөс 2.5 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		4. Залуу гэр бүлд орон сууцны зээл олгоход дэмжлэг үзүүлэх.	Хэрэгжиж эхлээгүй байна Тасарсан
		5. Залуучуудын амралт чөлөөт цагийн цогцолбор байгуулах.	“Амралт чөлөөт цагийн бүс”-ийн зураг төслийн сонгон шалгаруулалт зарлаад байна. Цаашид 2010 онд шалгарсан зураг төслийн дагуу барилгын ажил хийж гүйцэтгэнэ. <p>Хэрэгжиж байна 10%</p>
2. Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, зохицуулалт			
1.2.1.	Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	1. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сурталчилгааны агуулга, хэлбэр, чанар, үр дүнг сайжруулж, иргэд, хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, жил бүр хүн амын 90-ээс доошгүй хувийг хамруулах.	<p>Нийгмийн эрүүл мэнд, эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх чиглэлийн эрүүл мэндийн сургалтанд давхардсан тоогоор 21938 хүн, сурталчилгаанд 109421 хүнийг хамруулан, 46604 сурталчилгааны гарын авлага, материал түгээлээ.</p> <p>Засгийн газрын 2009 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажилласнаар орон даяар явагдсан нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх уралдаанд манай аймаг тэргүүн байр эзэлж Ерөнхий сайдын батламжаар шагнагдлаа. Уг тогтоолын хүрээнд “Идэвхитэй хөдөлгөөн-эрүүл аж төрөх ёс” уриан дор 1 сарын аян, “Эмч миний дотны анд” хөдөлгөөн, “Эрүүл мэнд бүх нийтийн үйлс” 3 сарын аяныг “Халдварт өвчнөөс сэргийлье”, “Цэвэр орчин эрүүл хот”, “Осол гэмтлээс сэргийлье” гэсэн уриан дор тус тус зохион байгууллаа.</p> <p>Аяны хүрээнд эмч, үйлчүүлэгчидтэй хэрхэн харьцах, эрүүл мэндийн боловсрол олгох зурагт хуудсыг тараах, “Эмчийн нэг өдөр” баримтат кино, “Эмч миний дотны анд”- TV шторк хийж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, автомашингүй нэг өдөр, бүх нийтийн гүйлт, бүх нийтийн цэвэрлэгээ зэрэг олон ажлыг зохион</p>

			<p>байгууллаа. Хотын их цэвэрлэгээний өдөрт 357 аж ахуй, нэгж, 4573 хүн оролцож, 19.8 мянган м.кв талбайг цэвэрлэж, 362 м.куб хогийг цэвэрлэж, 58 байгууллагад 700 гаруй хүнд халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгууллаа.</p> <p>Томуугийн А хүрээний H1N1 вирусийн өвчлөлийн үед өрхийн эмнэлэг дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар “Мэндбулаг” өрхийн эмнэлэг дээр, хүүхдийн байгууллага дээр авах арга хэмжээний талаар 5-р цэцэрлэг, 6-р сургууль дээр үзүүлэх сургалтыг зохион байгууллаа. Мөн уг халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 шторк, 2 төрлийн 300 зурагт хуудас, 7318 гарын авлага бэлтгэн 4 телевиз, байгууллага, олон нийтэд түгээх арга хэмжээ авлаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Хүүхдийн шүдний эмнэлгийн талаархи санал санаачлагыг дэмжин аймгийн хэмжээнд 6-15 насны хүүхдийн амны хөндийн өвчнийг оношлох, эмчлэх, үе шаттайгаар эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>Сургуулийн 14511 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийхэд 85,0 хувь нь өвчтэй байна. Шүдний цоорол өвчин үүсэх хор уршгийн талаар 14-р сургуулийн 7 бүлгийн 268 хүүхдэд үзүүлэх сургууль хэлбэрээр сургалт явуулж, амны хөндийн эрүүл ахуйг сахих талаар зөвлөгөө өгч, сургалт сурталчилгааны материал түгээв.</p> <p>Солонгос улсын шүдний эмч нарын багийг аймагт ажиллуулж 500 хүүхдэд үзлэг эмчилгээ, Япон улсын Ачи ганкуйн их сургуулийн профессор, багш нар ЭМШУИС-ийн багш, оюутнуудтай хамтран 250 хүүхдэд амны хөндийн үзлэг, эмчилгээ хийж, шүд угаах талаар сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран 2, 17–р сургуулийн нийт 3 бүлгийн 110 сурагчдын амны хөндийн өвчнийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан, 3 сарын турш хэрэглэх оо, сойзоор хангасан. Эдгээр ажлыг зохион байгуулсаны үр дүнд хүүхдийн шүдний өвчин буурч 83.5 хувьтай болоод байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%%</p>
		<p>3. Эрүүл мэндийн боловсрол олгох</p>	<p>Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын танхим</p>

		сургалтын танхимыг тохижуулах.	байгуулж, сургалтын өрөөг 2.0 сая төгрөгөөр бүрэн тохижуулаад байна. Хэрэгжиж байна 30%
		4. МХГ-ын орчны эрүүл мэндийн хими, нян судлалын лабораторийг хүнд металл, хор судлал, барилгын материалын чиглэлээр шинжилгээ хийх хүчин чадлыг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэх.	Орчны эрүүл мэндийн хими, нян судлалын лабораторийг хүнд металл, хор судлал, барилгын материалын чиглэлээр шинжилгээ хийх 25 төрлийн 40,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүллээ. Одоогоор хүнсний бүтээгдэхүүнд меламина, будагч бодис тодорхойлох, нян судлалын лабораторид тэжээлт орчин, хлороформ, усны шүүлтүүрийг авахад орон нутгийн төсвөөс 500.0 мянган төгрөг зарцуулж, шинжилгээ хийгдэж байна. Цаашид хүнсний бүтээгдэхүүнд хорт бодис, пестицид тодорхойлох урвалжууд шаардлагатай байна. Хэрэгжиж байна 50%
		5. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон хүн амыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах хувийг жил бүр 2,0 хувиар дээшлүүлж, өвчлөлийг бууруулах арга хэмжээ авах.	“Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг” ТББ-ын Орхон аймаг дахь салбарын “Ирээдүй” төвтэй хамтран 3 цогцолбор сургуулийн 3749 сурагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, сургалт зохион байгууллаа. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хувийн хэвшлийн эмч нартай хамтран эмзэг бүлгийн 689 эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, 726.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эмчилгээ хийв. Аймгийн хэмжээнд нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 235463 иргэн, түүн дотроос нөхөн үржихүйн насны 22947 эмэгтэйчүүд хамруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2107 буюу 2.1 хувиар нэмэгдсэн байна. Биелсэн 100%
1.2.2.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний түргэн шуурхай байдлыг хангаж, чанар хүртээмжийг сайжруулна.	1. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв болон өргөжихтэй холбогдуулан алсын дуудлагын түргэн тусламжийн үйлчлэх хүрээний радиусыг 3 дахин нэмэгдүүлэх.	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг Засгийн газрын 2008 оны 56 дугаар тогтоолоор байгуулж, удирдлага, зохион байгуулалтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлээд байна. Эрүүл мэндийн сайдын тушаалд заасны дагуу ойролцоо 4 аймгийн 42 суманд эрүүл мэндийн тусламж үзүүлэхээр гэрээ байгуулан, ирэх оноос гэрээний дагуу ажиллахаар бэлтгэлийг хангаж байна. Одоогоор эх,

			<p>хүүхэд, осол гэмтэлтэй холбоотой яаралтай дуудлаганд харьяалал харгалзахгүй үйлчилж эхлээд байна. Хэрэгжиж байна 30%</p>
		<p>2. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн чадавхийг бэхжүүлж, оношлогоо эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах.</p>	<p>Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор бөөрний гемодиализийн 207,4 сая төгрөгийн 2 аппарат дагалдах хэрэгсэлийн хамт, 18.6 сая төгрөгийн өртөг бүхий амьсгалын аппарат, нүдний хагалгааны 600.0 мянган төгрөгийн иж бүрдэл, нүдний электрон микроскоп, үйл оношийн тасагт 1.2 сая төгрөгийн 3 хөргөгч, цаг товлох үйлчилгээнд 8 компьютерийг улсын төсвөөс, хүлээн авах, дотор, мэс засал, гэмтлийн тасагт орчин үеийн шаардлагад нийцсэн 44.0 сая төгрөгийн өртөг бүхий өргөх механизмыг орон нутгийн төсвөөс тус тус нийлүүлж, ашиглаж байна.</p> <p>БОЭТ-ийн чадавхи сайжруулах ажлын хүрээнд хүлээн авах тасгийг сэхээний тасагтай нэгтгэн "Хүлээн авах-эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн тасаг" болгон өөрчилж, үйл ажиллагааг өргөтгөн, хүлээн авахын 4 сувилагч, сэхээний 4 сувилагч, 2 асрагчаар орон тоог нэмэгдүүлэн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3. Шинээр 40 ортой амаржих газар, Дэнж багт эмнэлгийн өргөтгөл барьж, ашиглалтанд оруулах.</p>	<p>Эрүүл мэндийн газар нь төрөх тасгийн 1-р давхарт байрлаж байсныг чөлөөлөн, НҮБ-ийн хүн амын сангийн "Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах" Люксембургийн төслөөр хэрэгжиж байгаа зайн оношлогоо болон "Эхийн амрах байр"-ыг стандартын дагуу тохижуулан ашиглалтанд орууллаа.</p> <p>Шинээр амаржих газар барих талаар ЭМЯ-нд санал хүргүүлсэн боловч эдийн засгийн хүндрэлтэй байгаагаас шалтгаалан шийдвэрлэх боломжгүй болсон ч Эрүүл мэндийн газрыг орон нутгийн өмчийн байранд оруулснаар төрөх тасгийн хүчин чадлыг нэмэгдүүлээ.</p> <p>Дэнж багт баригдах 40 ортой эмнэлгийн санхүүжилтэд дутуу байсан 300.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн барилгын ажил 75 хувьтай байна.</p>

		<p>4. Өрхийн эмнэлгүүдийн материаллаг бааз, үйлчилгээг сайжруулснаар гэрийн идэвхитэй эргэлтийг 20 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгийг 60 хувьд хүргэх.</p>	<p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p> <p>Нийт үзлэгээс урьдчилан сэргийлэх үзлэг 62,8 хувийг эзэлж, гэрийн эргэлт 21.8 хувь байна. “Ачлалт нар”, “Анхны оч”, “Мөнхсүндрэл 2” өрхийн эмнэлэг 1.7 сая төгрөгөөр тарианы өрөөгөө тохижуулан, “Хос чагнуур”, “Мэндбулаг”, “Анхны оч”, “Гэрэлт мандах” өрхийн эмнэлгүүд интернетэд холбогдон үйл ажиллагаандаа хэрэглэж байна.</p> <p style="text-align: center;">Биелсэн 100%</p>
		<p>5. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагыг дэмжин ажиллаж, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.</p>	<p>Хувийн хэвшлийн 49 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, улсын болон хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан ажилтанг Эрүүл мэндийн газарт орон тоогоор ажиллуулж эхэлсэн. Хувийн хэвшлийн төрөх эмэгтэйчүүдийн 8 эмнэлэг, шүдний 15 эмнэлэгтэй хамтран эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн үзлэг, амны хөндийн үзлэг, охидын үзлэг, томуугийн үзлэгийг хамтран зохион байгууллаа.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудад зөвшөөрөл олгох комиссын хурлаар сувилахуй, шүд, чих хамар хоолой, бариа засал, эмэгтэйчүүдийн чиглэлээр 4 үүдэн эмнэлэг, Дэнж, Говил багт салбар эмийн сан ажиллуулахаар зөвшөөрөл олгогдсон.</p> <p>Өсвөр үеийн сургагч багш бэлтгэх ажлыг хувийн хэвшлийн “Ирээдүй” эмнэлэгтэй хамтран зохион байгуулж байна. Дээд сургуулиуд, хүүхдийн асрамжийн “Энэрэл” төвд томуугийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хувийн хэвшлийн үүдэн эмнэлгүүдтэй хамтран зохион байгууллаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>6. Хувийн хэвшлийн ортой эмнэлэг байгуулах санал, санаачлагыг дэмжин ажиллах.</p>	<p>Нүд, эмэгтэйчүүдийн ортой эмнэлэг нээн ажиллуулах талаар санал боловсруулан, мөн 2010 онд аймагт ажиллах орны тоог 25-аар нэмэх саналыг дэмжин ЭМЯ-нд хүргүүлээд байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>7. Жил бүр 2 өрхийн эмнэлгийг II зэрэглэлийн шаардлага хангасан өрхийн эмнэлэг болох ажлыг дэмжих.</p>	<p>2009 онд “Мэндбулаг”, “Ачлалт нар”, “Мөнх сүндрэл” өрхийн эмнэлгүүд хоёрдугаар зэрэглэлийн өрхийн эмнэлэг болох шалгуур хангалаа.</p>

			Биелсэн 100%
		8. Эрүүл мэндийн салбарууд “Лавлагаат тусламж”, “Дуугүй хөтөч” үйлчилгээний аргуудыг нэвтрүүлэх.	Эрүүл мэндийн бүх салбаруудад лавлагаат тусламж, дуугүй хөтөч үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, Нэгдсэн эмнэлэгт урьдчилан дугаар авах, захиалга авах үйлчилгээг нэвтрүүлэн утсаар захиалга авдаг болсон. Сум, өрхийн эмнэлгүүдэд сувилагчийн пост тогтмол ажиллуулан, иргэдэд лавлагаа тусламжийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгааны гарын авлагаар үйлчилж байна. Биелсэн 100%
		9. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн “Эрдэнэт сувилал”-ыг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг болгож өргөжүүлэх.	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Эрдэнэт” сувилал бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд нийт давхардсан тоогоор 34463 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 10435 буюу 30 хувьтай байна. Мөн 2184 хүн 20495 ор хоног сувилуулж, дундаж ор хоног 9.5 байна. Нөхөн сэргээх эмчилгээний тасагт 38 нэр төрлийн эмчилгээг 4500 хүнд давхардсан тоогоор 28647 удаа хийж эмчилснээс 99.8 хувь нь эдгэрсэн байна. Хэрэгжиж байна 50%
1.2.3.	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ.	1. Жил бүр 40-өөс доошгүй эмч, эмнэлгийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхэд нийгмийн дэмжлэгийн сангаас дэмжлэг үзүүлэх.	Тайлангийн хугацаанд 20 эмч, эмнэлгийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхэд нийгмийн дэмжлэгийн сангаас 1.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Хэрэгжиж байна 50%
		2. Жил бүр эмч, эмнэлгийн ажилтнуудын 20-23 хувийг ажлын байран дахь болон зайны сургалтад хамруулах.	Ажлын байран дээрх “Харшилд эмзэгшилтэй хүүхдийн сувилгаа”, “Зүрхний шигдээс өвчин”, “Зүрхний шигдээс өвчнөөс урьдчилан сэргийлэх” зэрэг 11 сэдвээр 3 удаагийн зайны сургалтанд 154, ЭМЯ-тай хамтран “Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сургалтанд 450 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан нь эмнэлгийн ажилтнуудын 25.6 хувь нь байна. Биелсэн 100%

		<p>3. Эрүүл мэндийн байгууллагуудыг дотоод сүлжээнд холбож, мэдээлэл солилцох боломжоор хангах.</p>	<p>ЭМГ, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Сувилал” зэрэг 3 байгууллага дотоод сүлжээнд, “Хос чагнуур”, “Мэндбулаг”, “Анхны оч”, “Гэрэлт мандах” өрхийн эмнэлгүүд интернетэд холбогдон үйл ажиллагаандаа хэрэглэж, мэдээлэл солилцох боломжоор хангагдаж байна. Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Эмч, эмнэлгийн мэргэжилтүүдээс жил бүр 5-аас доошгүй хүнийг нарийн мэргэжлийн, 15-аас доошгүй хүнийг мэргэжлийн зэрэг ахиулах сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Төрийн сангийн дэмжлэгээр нарийн мэргэжлийн мэргэжил олгох сургалтанд 10 сувилагч, 11 их эмч хамрагдаж байна. Мэргэжлийн зэрэг хамгаалсан 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зэргийн үнэмлэх олгов. Биелсэн 100%</p>
<p>1.2.4.</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын ажлын байрны нөхцлийг сайжруулж, материаллаг баазыг бэхжүүлнэ.</p>	<p>1. Аймгийн Эрүүл мэндийн газрыг өөрийн байртай болгох асуудлыг холбогдох байгууллагатай хамтарч шийдвэрлэх.</p>	<p>Аймгийн Эрүүл мэндийн газрыг орон нутгийн өмчийн захиргааны II байранд шилжүүлэн, бие даасан байртай болгох асуудлыг бүрэн шийдвэрлэж, ажиллах нөхцлөөр хангалаа. Биелсэн 100%</p>
		<p>2. Нэгдсэн эмнэлгийн өргөтгөл барих асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх.</p>	<p>Бүсийн эмчилгээ оношлогооны төв болсонтой холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн зураг төсвийг боловсруулан хөрөнгийн асуудлыг ЭМЯ-нд шийдвэрлүүлэхээр тавиад байна. Хэрэгжиж байна 10%</p>
		<p>3. Аймгийн өрхийн эмнэлгүүдийг стандартын шаардлага хангасан байртай болгох.</p>	<p>2009 онд нийт 12 өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулан ажиллаж байна. “Гэрэлт мандах” өрхийн эмнэлгийн барилгын зураг, төслийг хийж, орон нутгийн төсвийн төсөлд санал оруулсан боловч санхүүгийн бэрхшээлтэй байдлаас шалтгаалан хасагдсан, “Мөнхийн гэгээ”, “Учралт баяр” өрхийн эмнэлгийн халаалтыг сайжруулах арга хэмжээ авч байна. Их залуу багт баригдах өрхийн эмнэлгийн зураг, төслийг хийж, хөрөнгийн асуудлыг холбогдох газарт санал тавиад байна. Хэрэгжиж байна 30%</p>
		<p>4. Өрхийн эмнэлгүүдийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	<p>Аймгийн өрхийн эмнэлгүүдийг 2009-2012 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган</p>

			ажиллаж байна. Биелсэн 100%
1.2.5.	Хүн амыг чанарын баталгаатай эмээр хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	1. Чанарын баталгаатай үндэсний зайлшгүй шаардлагат /даатгалд хамрагдсан/ эм, био бэлдмэлийн хангалтыг 85 хувьд хүргэж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	Эм хангамжийн стандарт, үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 88.2 хувьд хүрсэн. 13 эмийн сан даатгалын хөнгөлөлттэй жороор үйлчлэхээр гэрээ байгуулан, 23043 хүнд 54.9 сая төгрөгийн даатгалтай эмийн хөнгөлөлт үзүүлэв. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, үйлчлүүлэгчдэд эмийг эмчийн заавраар хэрэглэх, эмийн сангаас жороор эм авах ажлыг өрнүүлэх зорилгоор эмийн жорыг шинээр хэвлүүлэн олгосон бөгөөд жорын ард үйлчлүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харьцах зөвлөмжийг оруулж өгөв. Биелсэн 100%
		2. Дэнж, Эрдэнэ, Говил, Баянцагаан зэрэг шаардлагатай багууд, Вокзалын хэсэгт эрүүл мэндийн даатгалтай эмийн сан байгуулахыг дэмжиж ажиллах.	Эрүүл мэндийн даатгалаар эмийн хөнгөлөлт үзүүлэх эмийн санг дэмжин Уурхайчин багт “Яргуужин”, “Лидер” эмийн сангуудад даатгалаар үйлчлэх эрх олголоо. Дэнж, Говил багуудад 4 дүгээр сараас эхлэн даатгалтай эмээр үйлчлэх эмийн сангийн салбар нээн ажиллуулж байна. Хэрэгжиж байна 50%
1.2.6.	Хүүхэд, өсвөр үеийн болон үндэсний спортын төрлийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлнэ.	1. Аймгийн өсвөрийн шигшээ багийг 4-5 төрөлд хүргэн, материаллаг баазыг сайжруулахад орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх.	Аймгийн өсвөрийн шигшээ багийг Биеийн тамир, спортын тухай хуульд заасны дагуу аймгийн Засаг даргын шийдвэрээр спортын 7 төрлөөр 7 багш, 35 хүүхэдтэйгээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэв. Биелсэн 100%
		2. Спортын гүнзгийрүүлсэн сургалттай ангийг жил бүр 25-30 хүүхдээр нэмэгдүүлж, хичээллэх төрлийг олшруулснаар бие даасан спорт сургуулийн үндэс суурийг бий болгох.	“Орхон” цогцолбор сургуулийн дэргэд спортын мэргэжлийн сургалттай анги хичээллэж байсныг түшиглэн Биеийн тамир, спортын мэргэжлийн сургалттай “Ирээдүйн одод” дунд сургуулийг байгуулж, тус сургуульд 7-10-р ангийн 120 хүүхэд суралцаж байна. Биелсэн 100%
		3. Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн спортын тодорхой төрлийн танхимуудыг байгуулж, ажиллуулах.	Үндэсний спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгүүд “Үндэсний спортын булан, танхим”-ыг байгуулах хөдөлгөөн өрнүүлж, “Эрдэнэт”, “Баян-Өндөр”

			цогцолбор сургууль, 1, 2-р цэцэрлэгүүд танхим, кабинет байгуулав. Хэрэгжиж байна 50%
		4. Нийтийн биеийн тамирын төрлүүдээр аймаг, сум, байгууллагын хэмжээнд хөдөлгөөн өрнүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн биеийн тамир-Эрүүл мэнд” уриатай нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн жилийн аян аймгийн хэмжээнд өрнөж, сар бүрээр тодорхой салбар, байгууллага нийтийг хамарсан арга хэмжээ, хамт олны уралдаан, тэмцээн, сорил авах ажил зохион байгуулж, улсын хэмжээнд тэргүүн байр эзэллээ. Бага насны хүүхэд багачуудад хөдөлгөөний эвсэл, зөв дадал олгох цаашид биеийн тамир, спортоор хичээллэх үндэс суурь тавих зорилгоор уран хөдөлгөөнт гимнастикийн хөдөлгөөн өрнүүлж, энэ төрлөөр тэмцээн, уралдаанд бүх сургуулиудыг идэвхитэй хамруулж байна. Биелсэн 100%
		5. Наадмын талбайн цэнгэлдэх хүрээлэнг үргэлжлүүлэн барьж, талбайн орчин тойрныг тохижуулах.	Наадмын талбай, Өвлийн спортын төвийг тойрсон Амралт чөлөөт цагийн цогцолборын зураг төслийн сонгон шалгаруулалт зарлагдлаа. Хэрэгжиж байна 30%
		6. Тив дэлхийд амжилт гаргасан тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	Тайлант онд улс, тив, дэлхийд амжилт гаргасан 60 тамирчдад 6.9 сая төгрөгийн мөнгөн шагнал олгов. Биелсэн 100%
1.2.7.	Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлтийн ажлын үр дүнг сайжруулан, хамрах хүрээг өргөтгөж, иргэд, хүүхэд багачууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.	1. Бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилыг аймгийн ИТХ-ын нэрэмжит болгож, жил бүр явуулах.	7-64 насны иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг шинэчлэгдсэн бие бялдрын сорилын зааврын дагуу хавар, намар авч, дүгнэлт гарган ажиллаж, хангалтгүй дүн үзүүлсэн хүмүүст насны онцлогт тохирсон дасгал хөдөлгөөнийг заан зөвлөгөө өгч ажиллаж байна. Энэ онд сорилд 7-65 насны нийт хүн амын 1/4 буюу 21468 хүн хамрагдсанаас 3556 нь А, 7120 нь В, 6540 нь С, 3857 нь D, 395 нь F гэсэн үнэлгээ авсан байна. Хэрэгжиж байна 90%
		2. Нийтийн биеийн тамир,	Аж ахуйн нэгж байгууллага, сум багуудын дэргэд

		<p>чийрэгжүүлэлтийн клуб, хамтлаг байгуулахыг дэмжиж, хэрэгсэл материал, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>биеийн тамирийн баг, хамтлаг байгуулах орон тооны бус арга зүйч ажиллуулах талаар удирдамж заавар хүргүүлээд байна.</p> <p>Азийн бадминтоны холбооноос зохион байгуулсан сургалт семинарын үеэр тоглолтын цохиур, бөмбөг нийт 600.0 мянган төгрөгийн хэрэгсэл бэлэглэлээ.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		<p>3. Хотын болон гэр хорооллын гудамж талбайд чийрэгжүүлэлтийн хэрэгсэл суурилуулах</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр 4, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 6 багт нийт 60.0 сая төгрөгийн өртөг бүхий биеийн тамир чийрэгжүүлэлтийн хэрэгслийг 2008-2009 онуудад суурилууллаа. 2009 онд шинээр биеийн тамир чийрэгжүүлэлтийн хэрэгсэлд зориулж хөрөнгө батлагдаагүй болно.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>4. Өвлийн спортын ордон, цогцолборыг барьж байгуулах</p>	<p>Өвлийн спортын ордон барих асуудал эдийн засгийн хямралаас шалтгаалан хойшлогдож байна. Эрдэнэт үйлдвэрийн амралтын бааз дээр улсын шигшээ болон өөрийн баг тамирчдын бэлтгэл хийх, амжилт гаргах нөхцөл бололцоог бүрдүүлж бөхийн дэвжээ, сагсан бөмбөгийн иж бүрдэл хэрэгслээр хангасаны зэрэгцээ “Сархиа” цанын баазын орчныг тохижуулж хашаатай болголоо. Эдгээрт Эрдэнэт үйлдвэрээс 260.0 сая төгрөг зарцуулаад байна. 2010 оноос Сархиа уулыг ойжуулах ажлыг эхлүүлэхээр хөрөнгийн асуудлыг шийдвэрлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>5. Үндэсний, хүүхдийн, оюутны спортын наадмуудад оролцогсдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Манай аймагт үйл ажиллагаа явуулдаг МУИС, Технологийн сургууль, ХААИС-ийн салбар сургуулиуд анхан шатны тэмцээнийг спортын 5 төрлөөр явуулж, 300 гаруй оюутан оролцсон.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
3. Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалт			
1.3.1.	<p>Ажилгүй иргэдийг бүртгэх, ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлж, жилд 2500-аас доошгүй ажлын байр бий болгоно.</p>	<p>1. Жил бүр бүртгэлтэй ажилгүйчүүдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангах.</p>	<p>2009 онд нийт 620 гаруй аж ахуй нэгж байгууллагад 3155 ажлын байр бий болсноос 1840 нь шинээр бий болсон ажлын байр байна. Эдгээр ажлын байранд 1903 иргэнийг зуучлан байнгын ажлын байраар хангав. Оны эхэнд Хөдөлмөр халамжийн үйчилгээний хэлтэст 1755 иргэн бүртгэлтэй байсан бөгөөд 2009 оны жилийн эцэст</p>

			1804 иргэн бүртгэлтэй байна. Бүртгэлтэй иргэдийн 51.0 хувийг нь ажилд зуучилж, ажлын байраар хангалаа. Биелсэн 100%
		2. Дэд бүтэц, байгаль хамгаалал, экологийн чиглэлээр нийтийг хамарсан ажил зохион байгуулж 60-аас доошгүй хувьд нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулах.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд байгууллагын гадна орчны цэвэрлэгээ, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх, мод бут, цэцэг зүлэг тарих, авто замын өргөтгөл хийх, хадлан тэжээл бэлтгэх, намрын ургац хураалт зэрэг ажлыг 31 аж ахуй нэгж байгууллагатай хамтран явуулж 846 иргэнийг оролцуулж ажлын хөлсөнд 100.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа. Нийтийг хамарсан ажилд хамрагдагсдын 93.0 хувь нийгмийн эмзэг бүлгийн иргэд байна. Хэрэгжиж байна 90%
		3. Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэд, аж ахуй нэгжид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан жижиг зээл олгож, жилд 300-аас доошгүй ажлын байр бий болгох.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 78 аж ахуйн нэгж, иргэнд 294.5 сая төгрөгийн зээлийг “ХААН”, “Капитал”, “Монгол шуудан” банкаар дамжуулан олгож, үүний үр дүнд 350 ажлын байр бий боллоо. Биелсэн 100%
		4. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг тогтвортой ажиллуулж, үйлдвэрлэл дээрхи сургалтанд хамруулж буй ажил олгогчдыг дэмжих.	Ажил олгогчийг дэмжих зорилгоор бүртгэлтэй ажилгүй иргэдээс авч ажиллуулж байгаа “Алтан-өргөө” ХХК, “Баялаг ундрага” ХХК, Тагнуулын газар, “Монголиан катеринг” ХХК, Дулааны цахилгаан станц, Дөлгөөн жогол, “Тэнгэр тулга” ХХК, Эрдэнэт шанд, Капитрон банк, “ТОДГ” ХХК, “НИТИУ” ХХК, Худалдаа хөгжлийн банк, “Гэгээ” сургууль, НИК, Зээгоо, Тод өнгө, Таван талын булаг, Си-Би зэрэг 19 аж ахуйн нэгж, байгууллагад 47 иргэнийг авч ажиллуулсаны цалингийн нөхөн олговорт 43.4 сая төгрөгийг ажил олгогчийг дэмжих зардлаас олголоо. Биелсэн 100%
		5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс жил бүр дэмжлэг үзүүлж, хөрөнгө хуваарилах.	Энэ онд хөрөнгө хуваарилагдаагүй. Тасарсан.
1.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй	1. Жилд 30-аас доошгүй хөдөлмөрийн	Ногоо тариалах, зүймэл даавуун эдлэлийн урлал,

	иргэдэд эзэмшүүлэх, эрхлэлтийг нийгмийн хангахад үзүүлнэ.	мэргэжил хөдөлмөр нэмэгдүүлэх, баталгааг дэмжлэг	насны хөдөлмөрлөх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил эзэмшүүлэх.	шүрэн урлал, тоног төхөөрөмжийн засварчин, нарийн боов хийх, ногоо даршлах, бизнесийн эрхлэх зэрэг сургалтуудад 20 иргэнийг хамруулж сургалтын зардалд 780.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа. Хэрэгжиж байна 90%
			2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах, ажлын байранд зуучлах замаар байнгын болон түр ажлын байранд жил бүр 25-аас доошгүй иргэдийг хамруулах.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ДЦС-д 3, “Монголион катеринг” ХХК-д нийтийн хоолны туслах ажилтнаар 2, 14-р сургуулийн гадна талбайн үйлчлэгчээр 1, түр ажлын байранд 6, хувиараа аж ахуй эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэгт 8, “Эрдэнэт оёдол” хоршоонд 4, мужааны цехэд 2 иргэнийг ажилд зуучлан оруулж нийт 26 иргэн ажлын байраар хангагдаад байна. “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд жижиг аж ахуй эрхэлдэг 115 иргэнд 25.1 сая төгрөгийн зээл олголоо. НХХЯ-наас аймаг дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй 70,0 ба түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан ажилгүй иргэдийн төслийг сонгон шалгаруулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ба манай аймгаас 2 иргэн, 3 бүлэг, 1 иргэний нийгмийн байгууллага төсөл сонгон шалгаруулалтад тэнцэж 28.7 сая төгрөгийн санхүүжилт авч 18 ажлын байр бий болголоо. Биелсэн 100%
			3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих асуудлыг шийдвэрлэх.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль болон автотээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ахмадын тээврийн автобусаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт зорчуулахаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна. Энэ хөнгөлөлтөд давхардсан тоогоор 3400 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан байна. Биелсэн 100%
1.3.3.	Ахмад настанд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Байгууллага бүр ахмадын сантай болох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.	Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Ахмадын сан” байгуулж ажиллах журмын дагуу байгууллага бүр ахмадын сан байгуулж ажиллах шийдвэр гарч үүрэг өгөгдсөн.Төсөвт байгууллагуудын хувьд сан	

			байгуулахад хүндрэлтэй байгаа талаар НХХЯ-д асуудлыг тавихад тус сангийн хөрөнгийг арилжааны банкинд байршуулж холбогдох журмын дагуу зарцуулж болох талаар хариу ирүүлснийг байгууллагуудад хүргүүлэв. Байгууллагууд нийгмийн халамжийн хуулийн дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудынхаа нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал “Эрдэнэт үйлдвэр” ХХК 628 ахмадад 637,7 сая, ерөнхий боловсролын 9 сургууль 9,2 сая, 13 цэцэрлэг 4,2 сая, Эрүүл мэндийн салбар 172 ахмадад 5.0 сая, Цэргийн анги 120 ахмадад 850,0 мянга, Цагдаагийн газар 76 ахмадад 1.0 сая, Баян-Өндөр сумын ЗДТГ 10 ахмадад 1.0 сая, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс 3 ахмадад 90,0 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлж нийт 659,5 сая төгрөгийг зарцууллаа. Хэрэгжиж байна 70%
		2. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дэргэдэх болон зуны саам сувилалд нийт ахмадуудын 15-аас доошгүй хувийг жил бүр амраах.	Ахмадын хороо, “Баян-Уулс” амралт сувиллын газар хамтран 100 ахмадыг зуны саам сувилалд амрааж, орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөг, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс зуны саам сувилалд 72 ахмад настанг амрааж 3.5 сая төгрөгийг зарцуулав. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дэргэдэх ахмадын сувилалд 304 ахмад настанг амрааж 15.1 сая төгрөг зарцууллаа. Биелсэн 100%
		3. Ахмад настныг урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах.	2009 онд урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 47901 ахмадыг хамруулж, урьдчилан сэргийлэх үзлэг 100 хувьтай байна. Гэрийн эмчилгээ сувилгааг 2610 хүнд хийж, 1600 хүнийг онош тодруулах эмчилгээ хийлгэх зорилгоор 2-р шатны эмнэлэгт шилжүүлэв. Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт 3 ор ажиллуулж, 139 ахмад эмчиллээ. Эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 5608 ахмадыг хамрууллаа. Биелсэн 100%
		4. Ахмад настан болон ахмад дайчдад	Хаврын тэргүүн сар–Цагаан сарын баярыг угтан 70-

		<p>тэмдэглэлт өдрүүдээр хүндэтгэл, тусламж үзүүлэх.</p>	<p>аас дээш насны 2160 ахмадад 11.7 сая төгрөгийн хүндэтгэлийг орон нутгийн төсвөөс үзүүллээ. Мөн 95 ба түүнээс дээш насны 9 ахмадад Монгол улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ, гарын бэлгийг хүргэлээ.</p> <p>Харъяалалгүй 3450 ахмадад улсын төсвөөс 17.3 сая төгрөгийн хөрөнгөөр хүндэтгэлийг үзүүлсэнээс гадна багуудын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй 60 гаруй аж ахуй нэгж байгууллага, иргэд 1230 ахмадад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа. Ахмад дайчдад сар бүрийн хоолны хөнгөлөлтөд орон нутгийн төсвөөс 1.6 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Ялалтын баяраар ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнүүд зохиогдож, 3 ахмад дайчинд орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлж тус бүр 35.0 сая төгрөг, 2 ахмад дайчинд орон сууц олголоо. Ахмадын баяраар сум, баг, аж ахуй нэгж байгууллагууд ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг ажлуудыг хийлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
		<p>5. Ахмадын сувиллын барилгыг ашиглалтанд оруулж, ажиллуулах.</p>	<p>2008 онд улсын төсвөөс 250.0 сая төгрөг батлагдсаны дагуу тус барилгын ажлын 70 хувийг хийж гүйцэтгэсэн ба тайлант онд цаашид үргэлжлүүлэн дуусгах хөрөнгийн эх үүсвэргүйгээс уг барилгын ажил үргэлжлээгүй.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
		<p>6. Ахмадын нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулж, Жаргалант суманд долоо хоногт 2-оос доошгүй удаа явуулах арга хэмжээ авах.</p>	<p>Гэр хорооллын бүх чиглэл, Говил, Дэнж, Жаргалант сумын чиглэлүүдэд ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өдөрт 3 удаа тээвэрлэж, давхардсан тоогоор 95.0 мянган хүн тээвэрлэн, 760.0 мянган хүн/км-ын ачаа гүйцэтгэн, 20.1 сая төгрөг зарцууллаа. Жаргалантын чиглэлд батлагдсан төсвийн хүрээнд 7 хоногт нэг удаа явж байгаа бөгөөд төсвийн хүндрэлтэй нөхцөлд 2 удаа явах боломжгүй байгаа тул төсвийг нэмэх саналыг холбогдох газруудад хүргүүлээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>

1.3.4.	<p>Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хөгжүүлнэ.</p>	<p>1. Иргэдийг сонирхлоор нь бүлэг болгон амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг олон нийтийн оролцоог түшиглэн явуулах ажлыг хэрэгжүүлж эхлэх.</p>	<p>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зөвлөгөө өгөх сургалтыг 2 удаа явуулж, 4.1 сая төгрөг, нийгмийн ажилтнуудад “Хүүхдэд үзүүлж буй асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад тавих нийтлэг шаардлага” сэдвээр сургалт явуулан 43 хүнийг хамруулж, 1.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо 10 багшид сэргээн засах эмчилгээний сургалт явуулж, 106.1 мянган төгрөг, Жаргалант суманд 15 иргэнд дээрхи чиглэлээр сургалт явуулан 1.0 сая төгрөгийг тус тус зарцууллаа.</p> <p>Малчин багийн Тоочингийн өвөрт 10, Арбулагт 10 өрхөд мал аж ахуй, фермерийн чиглэлээр, Наран багт бүлэг болон ажиллаж байгаа 80 өрхөд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр сургалт явууллаа. “Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг”-тэй хамтран Өсвөр үеийн 350 охидыг хамруулж “Хүн худалдаалах гэмт хэргээс сэргийлэх нь” сэдэвт сургалт, “Гал голомт” хөдөлгөөнтэй хамтран шийдвэр гаргах түвшний 20 эмэгтэйд жендерийн сургалт тус тус зохион байгуулж 700.0 мянган төгрөг зарцууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд хамруулан зуучлах үйлчилгээ үзүүлэх.</p>	<p>Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 966 иргэнийг судалгаанд хамруулан нэг иргэнд сар бүр 14.0 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний талон олгогдохоор бэлтгэл хангагдаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд сургалт, жижиг төсөл хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх эцэг зэрэг 108 иргэнийг хамруулж 5.3 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Оёдлын цех ажиллуулж байгаа 1 иргэн, Эсгий урлал, гоёлын зүүлт чимэглэлийн үйлдвэрлэл худалдаа эрхэлдэг Золбоо бүлэг, хөнжил матрас хийдэг 1 иргэн, шүрэн урлал хийдэг 1 иргэн, Орхон аймгийн Хараагүйчүүдийн холбоонд массажистын сургалт явуулах зэрэг төслүүдийг НХХЯ-аас дэмжиж 28.7 сая</p>

			<p>төгрөгийн санхүүжилт олголоо.</p> <p>Орон гэргүй тэнэмэл иргэд, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлтэй гэр бүл зэргийг нийгэмшүүлэх олон төрлийн үйл ажиллагаануудыг явуулж байна. Орон нутгийн төсвөөс эмчилгээ сувилгаанд явах зайлшгүй шаардлагатай, нийгмийн эмзэг бүлгийн нэн ядуу 107 өрх, иргэнд 2750.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
1.3.5.	Иргэдийн нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалд хамрагдах хариуцлагыг дээшлүүлнэ.	<p>1. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй гадаадын иргэдийг даатгалд бүрэн хамруулж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах.</p> <p>2. Нийгмийн даатгалд хамрагдах ажил олгогч, даатгуулагчдын тоог жил тутам 10 хувиар нэмэгдүүлэх.</p> <p>3. Эрүүл мэндийн даатгалд нийт хүн амыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Орхон аймагт гадаадын иргэдийг гэрээгээр ажиллуулж буй 7 аж ахуйн нэгжийн 16 иргэнийг нийгмийн даатгалд хамруулаад байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p> <p>2008 оны жилийн эцэст нийгмийн даатгалд 73941 иргэн хамрагдаж байсан бол 2009 оны жилийн эцэст 81338 иргэн хамрагдаж байна. Тайлангийн хугацаанд нийгмийн даатгалд даатгуулагчийн тоо өнгөрсөн оноос 10,1 хувиар өссөн байна. Заавал даатгалд 538 иргэн, сайн дурын даатгалд 739 иргэн шинээр хамрагдлаа.</p> <p>Оны эхэнд 882 аж ахуйн нэгж нийгмийн даатгалд бүртгэлтэй байсан бөгөөд энэ онд шинээр 90 аж ахуйн нэгж хамрагдаад байна.</p> <p>Биелсэн 100%</p> <p>Аймгийн суурин хүн амын тоо 89575 байгаагаас 2009 онд 81338 иргэнийг нийгмийн даатгалд хамруулав. Энэ нь нийт хүн амын 91,0 хувь байна. Иргэдийг даатгалд бүрэн хамруулахын тулд нэг сарын аян зохион байгуулан төрөөс даатгалыг нь хариуцдаг иргэдийн судалгааг холбогдох байгууллагуудаас авч бүрэн хамруулах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
1.3.6.	Хүний хөгжил, гэр бүлийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр төрийн бус болон олон улсын байгууллага, орон нутгийн байгууллагуудтай хамтран	1. Гэр бүлийн ордны үйл ажиллагааг сайжруулж, ордонг түшиглэн гэр бүлд зөвлөгөө өгөх төв байгуулах.	Гэрлэх ёслолын ордон дээр Хөдөлгөөн-эрүүл мэнд, насанд хүрэгчдийн клуб, хүүхдэд зориулсан галбир засах болон жүжгийн ёс суртахууны хичээл дугуйланг тогтмол хичээллэж байна. Аймгийн гэр бүлийн баяр, “Буянтай аав” алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, “Манлай гэр бүл”-ээр 4 гэр бүлийг

ажиллана.		шалгаруулан, телевизийн нэвтрүүлэг бэлтгэн нийтэд түгээлээ. 2009 онд 60 гаруй хосын гэрлэх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, гэр бүлүүдэд зөвлөгөөг өгч, холбогдох байгууллагуудтай хамтран залуу гэр бүлүүдэд гэр бүлийн хуулийн талаар, гэр бүлийн эрх үүрэг хариуцлага, гэр бүл төлөвлөлт зэрэг сэдвүүдээр сургалтуудыг явууллаа. Гэр бүлд зөвлөгөө өгөх төв байгуулж ажиллуулах талаар холбогдох газруудад саналыг хүргүүлээд байна. Хэрэгжиж байна 50%
	2. Гэр хорооллын өрхүүдийн дунд бий болж байгаа хуримтлалын бүлгүүдийг чадавхижуулж, хүрээг өргөжүүлэн, өрх бүлгүүдийн хоршин ажиллаж, амьдрах, өрхийн үйлдвэрлэл хөгжүүлж орлогоо нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэх.	Япон улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа “Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төсөл нь тодорхой багуудыг сонгон төсөл хэрэгжүүлж, 6 багт 15 хуримтлалын бүлэг үүсч, 145 гишүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг “Золбоо” бүлэгт тоног төхөөрөмж авахад нь зориулж 1500.0 мянган төгрөг, эсгий урлалын үйл ажиллагаа явуулдаг бүлэгт тоног төхөөрөмж түүхий эд худалдан авахад нь 3000.0 мянган төгрөг, шүрэн урлал хийдэг бүлэгт 2000.0 мянган төгрөгийн төслийг дэмжин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Наран багт нийгмийн түншлэлийн сүлжээг бэхжүүлэх төслөөс жижиг бизнес эрхлэх, өрхийг үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 40 бүлэгт 24.0 сая төгрөгийн зээлийг олголоо. Хэрэгжиж байна 50%
	3. Шилжин ирэгсэдийг бүртгэлд бүрэн хамруулж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх.	Тайлант онд нийт 2148 хүн манай аймагт шилжин ирж бүртгүүлсэн бол бусад аймаг хот руу 2688 хүн шилжин явсан байна. Шилжин ирэгсдийг бүртгэлд бүрэн хамруулах зорилгоор Баян-Өндөр сум, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран нээлттэй хаалганы өдрийг 7 удаа зохион байгуулж, 235 иргэний хувийн хэрэг материалыг өмнөх харъяаллын аймаг орон нутгуудаас нь нэхэмжиллээ. Иргэний бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд иргэдийн шилжих хөдөлгөөний бүртгэлийг бүртгэх ажил хийгдэх бэлтгэл хангагдаж байна. Өрхийн эмнэлгүүдээр дамжуулан

			<p>шилжин ирсэн 1559 хүнийг бүртгэлд хамруулж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүллээ.</p> <p>Бусад аймаг, орон нутгаас шилжиж ирсэн 45 иргэн бүртгүүлсэн байна. Талх, нарийн боов, барилгын засал чимэглэл, тогоочийн дамжаанд 12 иргэн суралцаж, 27 иргэнийг нийтийг хамтарсан түр ажлын байранд зуучлан ногоон байгууламжийг сэргээх ажилд оролцууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
<p>Хоёр: Эдийн засгийн хөгжлийн бодлого</p> <p>Эдийн засгийн салбар дахь бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлж бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ.</p> <p>1. Үйлдвэржилт, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдсэн бодлого, зохицуулалт</p>			
2.1.1.	Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.	1. Орхон аймгийн хөгжлийн урт хугацааны стратегийг шинээр боловсруулан, Эрдэнэт хотын 2020 он хүртэлхи хөгжлийн стратегийн үр дүнг тооцон шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг хангах.	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөөгөө гарган ажиллаж холбогдох судалгаа, тооцоог хийж Орхон аймгийн хөгжлийн цогц бодлогыг батлуулав.</p> <p>Эрдэнэт хотын 2020 он хүртэлхи стратегид 33 зорилт хэрэгжүүлэхээс нэн тэргүүнд 13 зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөгдөв. Үүнээс одоогоор 15 зорилт, төсөл нь тодорхой хэмжээнд хэрэгжиж, 10 зорилтын хүрээнд 6 төсөл үр дүнтэй хэрэгжиж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		2. Баян-Өндөр сумын хөгжлийн стратеги, Жаргалант сумын богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах.	<p>Сумдууд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгээ байгуулсан бөгөөд Жаргалант сум дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан гаргаж сумын ИТХ-аар батлуулаад байна. Жаргалант сумын Хөгжлийн стратеги төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 35 ажил, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 13 төрлийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Баян-Өндөр сумын ажлын хэсэг төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		3. Гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах өндөр ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэх.	<p>Тайлант хугацаанд гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх МОН 9106 төслийг хэрэгжүүлэх 16 бүлэг шинээр байгуулагдан 25 дэд төсөл хэрэгжиж, 3402 өрхөд мэдээлэл хүргэн, 1296 хүн сургалтанд</p>

			<p>хамрагдав. Үүнд орлого нэмэгдүүлэх, бохирын асуудал, жорлон сайжруулах, орчноо сайжруулах, гэрэлтүүлэг, гүүр зам гарц сайжруулах дэд төслүүд хамрагдаж байна. Цаашид дэд төслүүдийг нэмэгдүүлэх хүрээнд утаагүй түлш, дулаацуулга зэрэг дэд төслийг хэрэгжүүлэх судалгаа, иргэдийн санаачлагыг бий болгохоор судалж байна.</p> <p>Гэр хорооллын иргэдийн дунд байгуулагдсан бүлэгт 2009 онд 78,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр судалгаа хийгдэж төслөөс 54,0 сая төгрөг, иргэдээс 29,5 сая төгрөгийг санхүүжүүлж 25 дэд төсөл хэрэгжүүлсэн. АССА хөтөлбөрийн хүрээнд өрхийн орлого нэмэгдүүлэх, жорлон сайжруулах, гудамж хашаа тохижуулах төсөл хэрэгжүүлж Шанд багийн Ирээдүйн хотхон бүлэгт 2,3 сая төгрөг, Арвижих бүлэгт 1,1 сая төгрөг, Дэнж багийн Валентина бүлэгт 2,5 сая төгрөг, Эрдэнэ бүлэгт 2,5 сая төгрөг, Их залуу багийн Хөршийн нөхөрлөл бүлэгт 2,5 сая төгрөгийн санхүүжилт олгон хэрэгжилт 98-100 хувь байна. Шинэ тосгон хөдөлгөөн ТББ-тай хамтран Шанд багт гудамжны тохижилт амралт чөлөөт цагийн талбай тохижилт, Эрдэнэ багт Автобусны буудал барих, амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Наран багт орчин тохижуулах чиглэлээр нийт 56 гишүүнтэй 6 бүлэг байгуулагдан хуримтлалын санд 540,0 мянган төгрөг төвлөрүүлэн 30,0 сая төгрөгийн санхүүжилтээр төслийг хэрэгжүүлэв.</p> <p>Ажилгүйдлийг бууруулахаар ажлын байрны төслүүд нь гэр хорооллын иргэдэд болон эмзэг, ядуу гэр бүлд чиглэгдсэн байгаагийн зэрэгцээ давхардалгүй байлгах зорилгоор багуудтай хамтран судалж олгож байна. Мөн бага орлоготой иргэдийг орон сууцаар хангах зорилтын хүрээнд “ХАБИТАТ” төсөл нь Их залуу баг, уртын голд 2009 онд 156,0 сая төгрөгийн санхүүжилт авч 15 байшин, хуучирсан байшинг сэргээн засварлах зорилгоор 15 өрхөд бичил зээл хэлбэрээр олгосон.</p> <p>Гэр хорооллын усан хангамжийг сайжруулах Хот байгуулалтын салбарын МОН2301 төсөл хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт төслийн нэгж байгуулагдан</p>
--	--	--	--

			<p>ажиллаж байна. Төсөл нь Чингэлийн голын усны эх үүсвэрээс 3 гүний худаг гарган 10 км төв болон 24 км салбар цэвэр усны шугамаар дамжуулан гэр хорооллын Эрдэнэ, Их залуу, Шанд, Рашаант багуудын одоо байгаа 20 ус түгээх цэгүүд болон шинээр баригдах 30 ус түгээх цэгүүдийг, 2*1000 м³ усан сантай холбоно. Мөн бохир усны шугамын 5 км урт холболт хийгдэнэ.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Олон улсын шугамаар хэрэгжиж байгаа нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн төслүүдийн үр ашгийг тооцон, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.</p>	<p>2009 оны 3 дугаар сард “Үйлдвэржүүлэлтийн нээлт 2009” жижиг дунд бизнес эрхлэгч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон зөвлөгөөний үеэр Аймагт хэрэгжиж буй Германы техникийн хамтын ажиллагааны Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр, Хоршоодын холбооноос өөрсдийн үйл ажиллагааны талаар, Арилжааны банкууд өөрсдийн олон улсын шугамаар хэрэгжиж буй төслийн зээл санхүүжилтийн тухай товч мэдээлэл хийж, сурталчиллаа. Орхон аймагт олон улс болон гадаадын тусламжаар 15 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа юм. Үүнээс нийгэм эдийн засагт үр ашигтай хэрэгжиж буй Германы техник хамтын ажиллагааны Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрөөс бичил санхүүгийн сургалтаас гадна банкны зээлийн баталгаа гаргах, орон нутгийн удирдлагыг оновчтой хүргэх төсөл, бодлого боловсруулахад хамтран оролцож байна.</p> <p>Мөн МОН 2301, МОН 9106 төслүүд гэр хорооллын хөгжлийг сайжруулах, Хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл цэвэрлэх байгууламжийг өргөтгөхөөр тус тус төслийн хороо байгуулан эрчимтэй үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>2009 оны байдлаар Бага орлоготой иргэдийг орон сууцжуулах “Хабитат” төсөл, Тогтвортой амьжиргаа II хөтөлбөр, Мянганы сорилын сангийн “Хот орчмын бэлчээрийн төсөл”, гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх МОН 9106 төсөл, Дэлхийн зөн ОУБ-н төсөл хөтөлбөрүүд нь нийтдээ 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийж, 239,0 сая төгрөгийн зээлд 86,4 сая төгрөгийн баталгаа гаргалаа.</p>

			Хэрэгжиж байна 70%
2.1.2.	Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж Хангайн бүсийн хөгжлийг тэргүүлнэ.	1. “Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах.	<p>Ерөнхийлөгчийн ивээл дор Хангайн бүсийн Аялал жуулчлалын хөгжил өнөө ба ирээдүй сэдэвт зөвлөгөөн Өвөрхангай аймгийн Хархорин хотод болж, “Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган бүсийн аймгуудтай эдийн засаг, нийгэм, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллах бодлогын хүрээнд хамтарч ажиллах, хоршин хөгжих үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор зөвлөмж гаргав. Орхон аймагт зохион байгуулсан “Хангайн бүсийн түншлэл-2009” үзэсгэлэн яармагийн үеэр ээлжит III хурлаа хийж Хангайн бүсийн ажлын тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэлэлцэхийн зэрэгцээ Хангайн бүсийн дэргэд Хөдөлмөрийн зах зээлийг зохицуулах дэд зөвлөл байгууллаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		2. Бүсийн аймгуудтай хамтран эдийн засаг, нийгэм, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.	<p>2009 оны 02 сарын 4-5 нд Ерөнхийлөгчийн ивээл дор Хангайн бүсийн Аялал жуулчлалын хөгжил өнөө ба ирээдүй сэдэвт зөвлөгөөн Өвөрхангай аймгийн Хархорин хотод болж, “Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, бүсийн аймгуудын эдийн засаг, нийгэм бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бодлогын хүрээнд хамтарч ажиллах, хоршин хөгжих үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор зөвлөмж гаргав.</p> <p>Энэ зөвлөгөөний үеэр Бүсийн хөгжлийн хөтөлбөрт туссан Эрдэнэт үйлдвэр технологийн паркын тухай хууль батлуулах, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний бирж байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэн, хууль батлахад дэмжлэг үзүүлэх саналыг УИХ-ын гишүүд, Засгийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
2.1.3.	Санхүүгийн салбарын хөгжлийг эдийн засгийн бодит өсөлтийг тэтгэхэд чиглүүлнэ.	1. Банк болон банк бус санхүүгийн байгууллагын тогтолцоо үйлчилгээний найдвартай ажиллагааг хангаж мөнгө зээлийн бодлогыг хөрөнгө оруулалт, бизнесийн салбарт оновчтой чиглүүлэх.	<p>2009 онд 8 арилжааны банкууд зөвхөн давтан зээлдэгч жижиг бизнес эрхлэгчдэд зориулан 1349,7 сая төгрөгийн зээл олгов. Капитал, Зоос, ХААН, ХАС, Шуудан банкууд 582 сая төгрөгийн төслийн зээл олгосон. Эдийн засгийн хямрал банкны салбарт нөлөөлж хөрөнгө оруулалтын зээл одоогоор</p>

			<p>олгогдоогүй байна. ХААН ХАС Голомт, ХХБанкууд нь урт хугацааны /120 сар хүртэлх хугацаатай/ 12-30 хувийн хүүтэй, орон сууц худалдан авах, шинээр барих, сэргээн засварлахад зориулан зээл олгож байна. Зээл олголтын үйл ажиллагаа хязгаартай байгаагаас бусад банкны бүх төрлийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		2. Тооцооны бэлэн бус хэлбэрийг худалдаа, үйлчилгээний салбарт нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх.	<p>ХАС, Зоос, Голомт, Худалдаа хөгжлийн банк, ХААН банкны картаар нийт 53 газарт бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээг хүргэж байна. Мөн аймагт 16 бэлэн мөнгөний машин /АТМ/ ажиллаж байна. Шинэ төрлийн Интернет банк, Мо-байл банкны үйлчилгээ нэвтэрч идэвхижүүлж байна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		3. Санхүүгийн түрээс, зуучлал, даатгалын үйлчилгээний хүрээг өргөтгөж үр нөлөөг сайжруулах.	<p>Аймгийн хэмжээнд 8 даатгалын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 даатгалын компани нь өөрийн байр, хаягт оршдог. Бусад нь байр, хаяг холбоо барих утас байхгүй идэвхигүй үйл ажиллагаа явуулж байгааг сайжруулах талаар үүрэг даалгавар хүргэлээ.</p> <p>Мөн шинээр Орхон Ард даатгалын байгууллага үйл ажиллагаа явуулж эхэллээ. Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 16 ХЗХ, 3 ББСБайгууллагад хяналт шалгалт хийж зөвлөмж зөвлөгөө хүргүүлээ.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		4. Лизингийн үйлчилгээнд үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хамрах хүрээг нэмэгдүүлэх.	<p>Лизингийн үйлчилгээнд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хамрах хүрээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг 12 аж ахуйн нэгжээс нийт 22 тоног төхөөрөмжийн захиалга авч Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээл төсөлд хүргүүлээд байна. Мөн Төгс бурзай ХХК-д 5.4 сая төгрөгийн өртөг бүхий сүү боловсруулах тоног төхөөрөмжийг 3 жилийн хугацаатай лизингээр нийлүүлээ. Өрхийн тариалан эрхлэгчдэд техникийн үйлчилгээ үзүүлэх цэгт Белорусс1522, ХТ3-3510 маркын тракторыг лизингээр олгож иргэдэд түрээсээр үйлчилж байна.Тайлант онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч Алтан тошлой, Сүмийн нуга, ББ-Од ХХК-уудад</p>

			<p>дунд оврын дугуйт тракторыг хөнгөлөлттэй нөхцлөөр, Бүтлийн ундрага ХХК-д үр тарианы комбайныг 30 хувийн урьдчилгаатайгаар, мөн Орхон тариа, Бүтлийн ундрага ХХК-нд үр тарианы ангилагч машиныг хөнгөлөлттэй нөхцлөөр олголоо.</p> <p>Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг лизингээр олгох талаар ХАС лизинг судалгаа явуулж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		<p>5. Гол нэрийн бүтээгдэхүүний /Мах, гурил/ үнийн хөөрөгдлөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>	<p>Засгийн газрын 2006 оны 178 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд махны нөөц бүрдүүлэх, үнийг хязгаарлах зорилгоор 2009 оны хаврын хэрэгцээнд зориулан “Эрдэнэт прогресс” ХХК 270, Монгема ХХК 230 тн махыг бэлтгэн 2009 оны 04-р сарын 01-нээс эхлэн хүнсний захуудаар 1 кг хонины махыг 2400, 1 кг үхрийн махыг 2550 төгрөгөөр хэрэглэгчдэд нийт 6 цэгээр худалдаалав. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг махны хадгалалт, борлуулалтын чанар, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдалд байнгын хяналт тавьж ажиллалаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
<p>2.1.4.</p>	<p>Өрсөлдөх чадвартай боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлнэ.</p>	<p>1. Аймаг, суманд “Үйлдвэржилтийн хөтөлбөр” боловсруулан, хэрэгжүүлэх.</p>	<p>Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийн жил” болгон зарласантай холбогдуулан жилийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж Үйлдвэржүүлэлтийн жилийн нээлт, Эрдэнэт хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын нээлтийг хийлээ. Мөн орон нутгийн Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил өнөөгийн байдал, ямар үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар 700-аад иргэдээс санал асуулга авч нэгтгэн дүгнэлт гаргаж судалгааны үр дүнгээс “Үйлдвэрлэл, үйлчилгээг 2009-2013 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Ү хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.</p>

			Хэрэгжиж байна 50%
		2. Орон нутагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг тогтоон батлуулж, дэмжин ажиллах.	Орон нутагт хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын чиглэлийг аймгийн Засаг даргын 2009 оны 159 дүгээр захирамжаар баталлаа. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэмжин хөгжүүлэх үйлдвэрүүдийн судалгаа, хэрэгжүүлэх төслүүдийг ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Хэрэгжиж байна 90%
		3. Жил бүр аймгийн хэмжээнд 4-5 байгууллагад “Бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх.	Жилийн турш 7 байгууллага дээр бүтээмжийн сургалт явуулж байгууллага бүр хөтөлбөр боловсруулах ба одоогийн байдлаар Нийгмийн даатгалын хэлтэс, 10 жилийн 7-р сургууль, Мэндбулаг өрхийн эмнэлэг дээр бүтээмжийн сургалтуудыг хийв. Мөн “Эрдэнэт Хивс” ХК-д бүтээмжийн сургалт, зөвлөгөөг хүргүүлсэн ба компаний хувьд бүтээмжийн хөтөлбөр боловсруулагдсан байлаа. Хэрэгжиж байна 70%
		4. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санг нэмэгдүүлж “Хөгжлийн сан” болгон, өргөжүүлэх.	Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд 2009 онд ХХААХҮЯ-аас 530.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 30.0 сая.төгрөгийг, Монгол Шуудан банк 220.0 сая төгрөг нийт 780.0 сая төгрөг байршуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олголоо. Аймгийн дэд комисс нийт 4750.4 сая төгрөгийн 160 -аад иргэн аж ахуйн нэгжийн төсөл хүлээн авч хэлэлцэн 2042.0 сая төгрөгийн 91 төслийг дэмжин банканд хүргүүлсэн ба үүнээс 43 төсөлд 780.0 сая төгрөгийн зээл олголоо. Мөн барьцаа хөрөнгө шаардлага хангахгүй байсан жижиг , дунд үйлдвэр эрхлэгчдэд Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн зээлийн баталгааны сангаас дэмжлэг үзүүлж 8 иргэн, аж ахуйн нэгжийн төслийг жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас, 4 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд арилжааны банкаас зээл олгууллаа. Хэрэгжиж байна 90%
		5. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийг байгуулан шинээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөгөө өгөх “Бизнес ширээ”-г ажиллуулах.	Аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний дэргэд бизнес ширээг нээн иргэдэд мэдээлэл өгөх үйлчилгээг явуулж байна. Бизнес ширээний үйлчилгээний шат дамжлагын зураглалыг гаргаж

			<p>бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид Бизнес ширээгээр дамжуулан зөвлөгөө өгөх гарын авлага материалыг бэлтгэн гаргав. Биелсэн 100%</p>
		<p>6. Бизнес инкубаторын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж бойжигч бичил болон жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх.</p>	<p>“Эрдэнэт бизнес инкубатор төв” нь 2009 онд фермер, тогооч, барилгын засал чимэглэлийн чиглэлээр сургалт явуулж нийт 68 иргэн хамрууллаа. Мөн “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” олон улсын хөтөлбөрөөр 2 сургагч багш бэлтгэн, сургалтыг 4 удаа зохион байгуулж 110 бизнес эрхлэх сонирхолтой иргэдэд эрхлэхэд онол арга зүйн сургалт явууллаа. Төсөл хөтөлбөр боловсруулах чиглэлээр 54 иргэнд зөвлөгөө өглөө. Маргад дээд сургуулийн дэргэд “Бизнесийн хөгжлийг дэмжих төв” ур чадварын болон бизнес төсөл боловсруулах сургалтыг зохион байгуулж 18 иргэн хамрагдлаа. Хэрэгжиж байна 90%</p>
		<p>7. “Нэг баг- нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн”-ий хүрээнд “Бренд” бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин урамшуулах тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөтөлбөрийн чиглэлээр багуудын брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, 18 баг бүрээр нийт 68 аж ахуйн нэгжийн брэнд бүтээгдэхүүнийг шалгарууллаа. “Хангайн бүс түншлэл Орхон-2009” үзэсгэлэн яармаг 10-р сарын 22-оос 24-нд Эрдэнэт хотод зохион байгуулагдаж Архангай, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл зэрэг бүсийн аймгуудаас гадна Улаанбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг аймгууд хамрагдав. Уг арга хэмжээний хүрээнд нийт 90 гаруй бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүд оролцож шилдэг бүтээгдэхүүнийг 7 номинацаар шалгарууллаа. 1. “Хангайн бүсийн 6 аймаг тус бүрийн шилдэг бүтээгдэхүүн: - Баянхонгор аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр “Хот мандал ундрага” хоршооны “Цагаан бурам” - Хөвсгөл аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр “Дүүрэн мишээл” ХХК-ийн “Цагаан гутал” - Орхон аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр “Эрд сүлжээ” ХХК-ийн “Ажлын хувцас” - Архангай аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр</p>

			<p>Хайрхан сумын Могой багийн иргэний айраг</p> <ul style="list-style-type: none"> - Өвөрхангай аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр “Мөнгөн өргөө” ХХК-ийн “Уянга” хийцийн эрээн гэр - Булган аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр Сэлэнгэ сумын “Бог будаа” бүлийн бог будаа <p>2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Баянхонгор аймгийн “Хонгорын сор” хоршооны эсгий эдлэл, - Өвөрхангай аймгийн “Сүүн далай трейд” ХХК-ийн цагаан идээ, сүүн хурууд - Архангай аймгийн иргэний цагаан идээгээр зассан тавгийн идээ - Хөвсгөл аймгийн “Хөвсгөл хүнс” ХХК-ийн чацарганы шүүс <p>3. Шинэлэг сав баглаа боодолтой бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Орхон аймгийн “Жүр үр” ХХК-ийн бялуун бүтээгдэхүүн <p>4. Импортыг орлох бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Хөвсгөл аймгийн “Цагаан загас” ХХК-ийн лаазалсан бүтээгдэхүүн <p>5. Гар урлалын шилдэг бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Өвөрхангай аймгийн “Зөөлөн сувд” хоршооны эсгий эдлэл - Баянхонгор аймгийн МСҮТ-ийн бичиг хэргийн бүтээгдэхүүнүүд <p>6. Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Баянхонгор аймгийн “Их халбаганат” ХХК-ийн ингэний хоормог <p>7. Шилдэгийн шилдэг бүтээгдэхүүн “Гран при” шагналыг</p> <p>Орхон аймгийн “Натурал альфа” ХХК-ийн сарлагийн хөөврөн сүлжмэл бүтээгдэхүүн хүртлээ. Хэрэгжиж байна 50%</p>
2.1.5.	Үйлдвэр технологийн паркыг байгуулж эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгоно.	<p>1.Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг, технологийн материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх.</p> <p>2. Хөдөө аж ахуйн түүхий эд, мах, махан</p>	<p>“Эрдэнэт” үйлдвэрлэл технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, холбогдох тооцоо судалгааг бүрэн хийгдлээ. “Эрдэнэт” ҮТП-ийн ашиглалтын өмнөх захиргааг байгуулан ажиллуулж</p>

		<p>бүтээгдэхүүн боловсруулах, экспортлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх.</p> <p>3. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх.</p> <p>4. Оёдол сүлжмэл, ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх.</p> <p>5. Агро паркийг хөгжүүлэх.</p> <p>6. “Эрдэнэт Үйлдвэрлэл-технологийн парк”-ын үйл ажиллагааг жигдрүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах.</p>	<p>байгаа бөгөөд 2009 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран ажиллах ажиллах гэрээ байгуулаад байна. Гэрээний хүрээнд Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хуулийн төсөл дээр санал боловсруулах, судалгаа шинжилгээ хийх чиглэлээр хамтран ажиллаж ирсэн.</p> <p>Паркийн хил хязгаарт байгаа аж ахуйн нэгжүүдийн байршил, кординатуудыг тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд газрын төлбөрийн тухай саналаа УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлээд байна.</p> <p>Паркийн үйл ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг, технологийн материалын үйлдвэрлэл - Экспортын мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл - Хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл - Мод, модон бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл - Оёдол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
2.1.6.	Худалдаа үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхийг сайжруулна.	<p>1. Салбарын ажиллагсдын мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлэх сургалтууд болон мэргэжлийн уралдаануудыг тогтмол зохион байгуулах.</p>	<p>2009 оны 03-р сарын 9-11-ний хооронд Улаанбаатар хотод нэмүү өртгийн сүлжээ таниулах “Сургалтын хөтөлбөр боловсруулах ба үнэ тогтоох арга” сэдэвт сургалтанд бизнесийн хөгжилд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажилтныг хамруулж, сургалтанд хамрагдсан ажилтнуудаараа дамжуулан “Нэмүү өртгийн сүлжээ таниулах” сургалтыг жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд явууллаа. Сургалтын үр дүнд тухайн салбаруудын нэмүү өртгийн сүлжээний оролцогчдыг өөрсдөд нь таниулан ойлгуулах, салбар болгоны НӨС-ний урьдчилсан зураглалыг гаргаж авсан. 2009-07-27-нд “Мэдээллийн технологийн хэрэглээ” сургалтыг зохион байгуулж 18 байгууллага оролцлоо.</p> <p>Булган аймагт 6-р сарын 10-11-ны өдрүүдэд бүсийн аймгуудийн тогоочдын дунд “Үдийн цай” сэдэвт ур чадварын уралдаан тэмцээн болж 8 тогооч оролцож</p>

			<p>шагналт байранд шалгарлаа. “Ахуйн үйлчилгээний жишиг төв” сэдэвт Төвийн бүсийн үзүүлэх сургалт, үзэсгэлэнг 6-р сарын 19-ны өдөр Эрдэнэт хотод зохион байгуулж сургалтанд Булган, Дархан, Сэлэнгэ, Төв, Орхон аймгийн 60-аад төлөөлөл оролцон туршлага солилцов.</p> <p>Худалдаа үйлчилгээний салбарын байгууллагуудад ажлын байрны аттестатчлалыг явууллаа. Аттестатчлалд худалдааны 378, зочид буудал амралтын 57, үсчин гоо сайхны 54 газар хамрагдлаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Өрхийн болон гар үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах худалдааны танхим бүхий цогцолборыг байгуулах.</p>	<p>“Эрдэнэт түншлэл-2009” үзэсгэлэн худалдааг 6-р сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд өрхийн болон гар үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.</p> <p>Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, борлуулах төвийг байгуулах саналыг дэмжин судалж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>3. Техникийн болон сэлбэгийн төрөлжсөн үйлчилгээний төв байгуулах санаачлагыг дэмжин ажиллах.</p>	<p>2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг явуулах ажлын төлөвлөгөөний дагуу Эрдэнэ, Их залуу багийн нутагт худалдаа үйлчилгээ, орон сууц, эмийн сан, ШТС, авто засвар, үйлчилгээний зориулалтаар нийт 0.76 га газарт 2 удаа дуудлага худалдаа зарласан боловч санал ирүүлээгүй. 2009 онд Орхон автоплаза, Форвардмоторс, Хурд авто сервис зэрэг үйлчилгээний салбарууд үйл ажиллагаагаа эхлэн явуулж байна.</p> <p>Авто засвар, үйлчилгээний чиглэлээр 2009 онд 0.45 га газрыг Согоот багт дуудлага худалдаагаар, нэгдсэн гарааш, үйлдвэрийн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтаар газрыг олгохоор боллоо.</p> <p>Техникийн болон сэлбэгийн төрөлжсөн зах байгуулах хүсэлт ирсэн боловч хүсэлт гаргасан газарт нь шийдвэрлэх боломжгүй тул хойшлогдсон</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>

		<p>4. Үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байрны нөхцлийг сайжруулж, стандартын шаардлагыг хангуулан, шинээр баригдах орон сууцны барилгын 1-р давхрыг үйлчилгээний зориулалтаар барихыг бодлогоор дэмжин, захын хорооллуудын иргэдийн хэрэгцээ шаардлагыг ханган худалдаа, үйлчилгээний төв байгуулах.</p>	<p>“Ахуйн үйлчилгээний жишиг төв” сэдэвт Төвийн бүсийн үзүүлэх сургалт, үзэсгэлэнг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон аймгийн 60-аад төлөөлөл оролцон туршлага солилцлоо.</p> <p>Захын хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор байгуулах зорилгоор Говил, Их залуу, Эрдэнэ багуудад худалдаа үйлчилгээний зориулалтаар 1.8 га газрыг дуудлага худалдаанд орууллаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
2.1.7.	<p>Бараа бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний чанарын хяналт стандартыг мөрдүүлнэ.</p>	<p>1. Зах зээлд нийлүүлэгдэж байгаа бараа, бүтээгдэхүүн ажил үйлчилгээнд тохирлын баталгаа олгох ажлын цар хүрээг нэмэгдүүлэх.</p>	<p>“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” болон Засгийн газрын тогтоолын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ, гадаад дотоод худалдааны үйл ажиллагааг эрхэлж байгаа өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд тохирлын баталгаанд заавал хамрагдах, бүтээгдэхүүн ажил үйлчилгээг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд чанар аюулгүй байдлын тохирлын баталгаажуулалтад хамруулан тайлант онд дотоодын үйлдвэрлэлийн 24 аж ахуйн нэгжийн 15 нэрийн бүтээгдэхүүнийг, үйлчилгээний 150 аж ахуйн нэгжийн 6 нэр төрлийн үйлчилгээг баталгаажуулж, бүтээгдэхүүний чанар стандартын шаардлагыг хангуулав.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		<p>2. Бүтээгдэхүүний сав, баглаа боодол, хаяг шошгонд стандартын шаардлага хангуулах.</p>	<p>2009 онд сав, баглаа боодол, шошгоны стандартыг мөрдүүлэх ажлыг улам эрчимжүүлэн, шаардлага хангахгүй сав, баглаа боодол, шошгыг шинэчлүүлэх ажлыг зохион байгуулав. Хүнсний сав, баглаа боодол, шошгоны 15 стандартаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг хангаж ажиллалаа. Талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний шошгыг уутны гадна талд наадаг байдлаар хэрэглэх шаардлага тавьсны үндсэн дээр одоогийн байдлаар 20 аж ахуйн нэгж шошгоо шинэчлээд байна.</p>

			<p>Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний шошгыг чиглэл чиглэлээр нь хавтасжуулж, нийт 50-иад аж ахуйн нэгж хамрагдлаа.</p> <p>Үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодолд олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж буй барааны тэмдэг кодыг хэрэглэж, коджуулах ажлыг аймгийн ХАҮТ-тай хамтарч хийхээр гэрээ байгуулан хамтарч ажиллан, 14 аж ахуйн нэгжийн 134 бүтээгдэхүүнд зураасан код олгож, сав баглаа боодлын шошгыг шошгоны стандартын дагуу баталгаажууллаа. 18 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний шошгыг шинэчлүүлж, зураасан кодтой болгох шаардлагыг тавин ажиллаж байна. Хүнсний сав баглаа боодлын шошгоны стандарт MNS CAC-1:2007 стандартаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн технологич, менежерүүдэд сургалт зохион байгуулж, сургалтанд 20 аж ахуйн нэгжийн 30 гаруй хүн хамрагдав.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		<p>3. Олон улсын Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг биелүүлсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх.</p>	<p>Чанарын удирдлагын ISO-9001, Байгаль орчны менежментийн ISO-14000 бүлэг стандартыг нэвтрүүлж ажиллахад үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжин, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, Байгаль орчны удирдлагын ISO-14000 стандартыг аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх ажлыг сурталчилж, сургалт зохион байгуулан, заавар зөвлөгөө өгч байна. Одоогийн байдлаар ISO-14000 стандартыг “Эрдэнэт-Үйлдвэр” ХХК хэрэгжүүлэх ажлыг эхлэн хийж, шат дараалсан сургалтуудыг 3 удаа хийлээ.</p> <p>2009 оны байдлаар Чанарын удирдлагын тогтолцоо ISO9000 багц стандартыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Эрдмин”, “Эрдэнэт хивс” ХХК-иуд, аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс нэвтрүүлж, сертификатаа аваад байгаа юм.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор холбогдох бэлтгэлийг хангаж байна.</p>

			<p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p> <p>Орхон аймагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургуулиуд, иргэдэд сонирхсон стандартын талаархи мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажилласны зэрэгцээ аливаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байран дээр аттестатчиллын үед стандартын сурталчилгааг хийж байна.</p> <p>Стандартыг сурталчлах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллага болон сургууль, цэцэрлэгийн эмч нарыг оролцуулсан сургалтыг 2 удаа, зочид буудлын үйлчилгээний стандарт шинэчлэгдсэнтэй холбогдуулан зочид буудлын үйлчилгээ эрхлэгчид болон дэн буудлын үйлчилгээ эрхлэгчдэд 2 удаа зохион байгуулж, холбогдох стандартын талаар болон “Байгаль орчны удирдлагын тогтолцоо”-ны ISO 14001 стандарт бусад мэдээ мэдээллээр хангалаа.</p> <p>Нийт 94 аж ахуйн нэгж 118 стандартын хангалтыг хийж, 265 хэрэглэгчид стандартын үйлчилгээг хүргээд байна.</p> <p>Аймгийн хэмжээнд заавал мөрдүүлэхээр шинэ болон шинэчлэгдэн батлагдсан стандартуудын мэдээллийг www.erdenet.mn сайтад байршууллаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p> <p>Сорилт калибровкийн лабораторид ашиглаж байгаа багаж тоног төхөөрөмжийн анги нарийвчлалыг дээшлүүлж, орчин үеийн дэвшилттэй техник технологи бүхий багаж, хэмжих хэрэгслээр хангах зорилгоор лабораторид нэн тэргүүнд шаардлагатай байсан электрон жин, усан банн, бутлагч, ком шигшүүр, эталон туухай, эталон жин, невльер, нефтьденсиметр, туузанметр зэрэг 9,3 сая төгрөгийн үнэ бүхий хэмжих хэрэгслийг олгов.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Аж ахуйн нэг байгууллага, иргэдэд Үндэсний болон олон улсын стандартыг сурталчлан таниулах ба нээлттэй хүртээмжтэй болгох.</p>	
		<p>5. Лабораториудыг өндөр нарийвчлал бүхий орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий багаж хэмжих хэрэгслээр хангаж, хүчин чадлыг сайжруулах.</p>	
2.1.8.	“Албан ёсны статистикийг хөгжүүлэх” дунд хугацааны хөтөлбөрийн	1. Албан ёсны Статистикийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх.	Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөрийг үндэслэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг 9 зорилт бүхий 28 арга хэмжээтэй

хэрэгжилтийг ажиллана.	хангаж		боловсруулан батлаад байна. Хэрэгжиж байна 50%
		2. Мянганы хөгжлийн зорилтын зарим шалгуур үзүүлэлтийг орон нутагт тооцож мэдээллийн сан байгуулах.	Мянганы хөгжлийн зорилтын 9 зорилгод тусгагдсан ядуурлын түвшин, 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдлийн түвшин, тураалтай хүүхдийн хувийн жин, эхийн эндэгдлийн түвшин, сүрьеэ өвчний тархалт, ажиллах хүчний оролцооны түвшин, бага боловсролын хамран сургалт, ойт нутгийн хэмжээ, суурин утасны цэгийн тоо, хүний хөгжлийн индекс зэрэг 38 үзүүлэлтээс орон нутагт тооцох боломжтой 35 үзүүлэлтийг тооцож статистик хөгжлийн мэдээллийн санг байгууллаа. Хэрэгжиж байна 70%
		3. “Хүн ам, орон сууцны тооллого”-ын бэлтгэлийг ханган, зохион байгуулах.	Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг графикийн дагуу хийж байна. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг сумдын захиалгаар дахин хэвлүүлж сум, багуудад хүртээмжтэйгээр хуваарилан олгов. Мөн тооллогын комиссыг 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн тооллогын түр товчоог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, сумд тооллогын комиссыг байгуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд Хүн амын орон сууцны тооллого явуулах зөвлөмжийн дагуу аймгийн сургагч багшаар 2 албан тушаалтныг бэлтгэж, багуудад ажиллах тоологч, шалгагч нарын тоог нормативт үндэслэн тооцож улсын товчоонд хүргүүлээд байна. Хэрэгжиж байна 50%
		4. Хүн ам, өрхийн бүртгэл мэдээллийн ажлыг чанаржуулан, хүн амын өрхийн бүртгэлийн санг баг, сумын түвшинд бий болгон, үйл ажиллагааг сайжруулах.	Өрх, хүн амын бүртгэлийн мэдээллийг тусгай программд бүрэн оруулах ажлыг Үндэсний статистикийн газартай хамтран 1 дүгээр сард зохион байгуулж бүртгэлжүүлэн үр дүнгийн үзүүлэлтийг баг бүрээр гарган баг, сум, аймгийн түвшинд бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болголоо. Хэрэгжиж байна 50%

2. Төсвийн бодлого, зохицуулалт

2.2.1.	Төсвийн бодит үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1. Төсвийн төлөвлөлтийг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод уялдуулан төлөвлөх	<p>Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ангилал батлагдсантай холбогдуулан 2010-2012 оны орон нутгийн орлого зарлага, хөрөнгө оруулалтын төсвийн батлагдсан хязгаарт багтаан төсвийн төслөө боловсруулах, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд боловсруулж ирүүлэх талаар төсвийн ерөнхий менежерүүдэд мэдэгдэж, 7-р сарын 15-ний дотор хүлээн авч нэгтгэн, Сангийн яаманд 8-р сарын 15-нд багтаан хянууллаа. Үүнээс:</p> <p>Орон нутгийн төсвийн орлогыг 32499.2 сая, зарлагыг 2760.2 сая, хөрөнгө оруулалтыг 500.0 сая төгрөгөөр тус тус хянагдаж, хөрөнгө оруулалтын 2010 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг 28.8 тэрбум төгрөгөөр боловсруулж холбогдох яамдуудад хүргүүллээ. Төсвийн төслийг боловсруулахдаа аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад хөтөлбөр, төслүүдэд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх, урьд онд хөрөнгө төсвийн боломжгүйгээс хэрэгжиж чадаагүй ажлуудаас хамруулав.</p> <p align="right">Биелсэн 100%</p>
		2. Төсөвт байгууллагуудын төсвийн зарлага, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулан, Төрийн сангийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллах.	<p>Төсөвт байгууллагуудын төсвийн зарлага, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулан, Төрийн сангийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор 2008 онд төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдтэй аймгийн Засаг даргын хийсэн үр дүнгийн гэрээг дүгнэж төсвийн хөрөнгийн зарцуулалт, өр авлагын барагдуулалт, тайлан мэдээ гаргалтын байдал, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн төлбөр зөрчлийн барагдуулалт, аудитын дүгнэлтүүд зэрэгт үнэлгээ өгч нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүллээ.</p> <p>Аудитын болон МХГ-аас хийсэн шалгалтын үр дүн, тайлант онд төсвийн хэтрэлт гаргасан, өр төлбөр нэмэгдүүлсэн үр дүнгээр зөрчилтэй гарсан зарим нэг төсвийн ерөнхий менежер, ня-бо нарт анхааруулга</p>

			<p>өгөөд байна. Төрийн сангийн шуурхай байдал, төсвийн хөрөнгийн зарцуулалтад төсвийн байгууллагын өдөр тутмын гүйлгээнд хяналт тавьж, зардлын зүйл бүрээр сар бүр эрхийг нээж төсвийн өр авлагыг бууруулах, өргүй ажиллах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, баримтын бүрдүүлэлтэд байнгын хяналттай ажилласны үр дүнд орон нутгийн байгууллагууд төсвийн өргүй ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		3. Удирдлагын зардлыг бууруулан, төсвийн бүтээмжит зардлын хэсгийг нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллах.	<p>2009 онд орон нутгийн төсвийн байгууллагууд төсвийн удирдлагын зардлыг бууруулах, үүний дотроос тээвэр шатахуун, албан томилолт, ном хэвлэл, эд хогшил худалдан авах зардал, урсгал засварын зардлыг 2008 оны гүйцэтгэлээс 2009 онд 59.5 сая, 2010 оны төсвийн төсөлд 39.0 сая төгрөгөөр бууруулан төлөвлөөд байна.</p> <p>Орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос буурсан хэдий ч орон нутгийн төсвийн боломжинд тулгуурлан хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвөөс 323.9 сая, урьд оны төсвийн шилжих үлдэгдлээс 381.1 сая, Замын сангаас 308.0 сая, Эрдэнэт сангаас 208.5 сая нийт 1254.5 сая төгрөгөөр, Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хотын доторхи авто замын шинэчлэлд 1.0 тэрбум, ДЦС-ын уурын зуухны шинэчлэлийн зардалд 1.2 тэрбум, 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга 450.5 сая, ЕБС, МСҮТ, Их дээд сургуулийн засварт 335.0 сая, Нэгдсэн эмнэлгийн гүний худгийн холболт 170.0 сая, 40 ортой эмнэлгийн барилга, Хүүхдийн ордны барилга нийт 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
2.2.2.	Аймгийн эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж хөрөнгө оруулалтын бодлогын нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллана.	1. Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний худалдан авах үйл ажиллагааг нээлттэй, шударга, ил тод, хуулийн хүрээнд явуулж, хяналтыг сайжруулах.	<p>Орон нутгийн төсөв, авто замын сан, Эрдэнэт сангаас санхүүжигдэх нийт ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог тухай бүрд байгуулж тендерийн бичиг баримтыг боловсруулан Сангийн яамны веб сайт, төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан</p>

			<p>мэдээлж, нээлттэй ил тод зохион явууллаа. Нийт сонгон шалгаруулалтын ажлын үр дүнгээр Ногоон байгууламжийн хайсны батлагдсан зардлаас 12.1 сая, дээврийн засварын ажлаас 6.5 сая, Сүхбаатарын өргөн чөлөөний авто замын гэрэлтүүлгийн ажлаас 4.5 сая, нийтдээ 24.5 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллалаа.</p> <p>Урьд оны дутуу хийгдсэн ажлын гэрээг дүгнэж хугацаа хэтэрсэн гүйцэтгэгч байгууллагад 6.5-36.5 сая төгрөгийн хүү торгууль ногдуулж барагдууллаа, Хөрөнгө оруулалтын ажлыг үр ашигтай, чанартай хийлгэх зорилгоор Сангийн сайдын 58 дугаар тушаалын дагуу урьдчилгааг 30 хүртэл хувиар олгож ажил дууссан үед техникийн болон улсын комисс ажлыг бүрэн хүлээн авсан актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг журмын дагуу эрх нээн олгож, явцын талаар тогтмол мэдээлж ирлээ. Нийт 11 тендерийн үнэлгээний хороо байгуулагдан ажиллалаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
		<p>2. Улс, Орон нутгийн төсөв, болон бусад эх үүсвэрээр хийгдэх их засвар, хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлэх.</p>	<p>2008 онд ажил нь дууссан боловч техникийн болон улсын комисс ажиллаж хүлээж аваагүй ажлын үлдэгдэл хөрөнгийг Эрдэнэт санд төвлөрүүлсэн бөгөөд 2009 онд Янзага зуслангийн амралтын байр, Говил багийн халуун усны барилга, БОЭТ-ийн болон 9 давхар байрны лифт, Аймгийн ЗДТГ-ын шатны засвар, МХГ-ын засвар, Жаргалант сумын 4 хүний халуун усны барилга, Сүхбаатарын өргөн чөлөөний гэрлэн чимэглэл, Бэлчээрийн зориулалттай 8 худгийн ажилд улсын комисс ажиллуулж, үлдэгдэл санхүүжилт нийт 279.4 сая төгрөгийг олголоо. Мөн өнгөрсөн оны дутуу хийгдсэн гэрээг дүгнэж, гэрээний тусгай нөхцөлийн 15 дахь заалтыг үндэслэн гэрээнд заасан хоногийн хэтрэлт тутамд 0,03-0,05 хувиар торгууль ногдуулан үлдэгдэл санхүүжилтээс нь суутган тооцож нийтдээ 6 байгууллагад 6.5-36.5 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдууллаа.</p> <p>Тайлант онд Тогтвортой амьжиргаа-II төслийн хүрээнд 14 нэгж бүхий 139.8 сая, ДЗОУБайгууллагаас 11 Боловсрол, Эрүүл мэндийн чиглэлээр тоног</p>

			<p>төхөөрөмж, сургалтанд зориулж 756.0 сая төгрөгийн ажил хийгдсэнээс 210.1 сая төгрөг нь тоног төхөөрөмжинд зарцуулсан байна. Мөн Баян-Өндөр сумын гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаанжуулалтын зардалд зориулан ЭБЦТС ТӨХК-наас 2 дэд өртөө, Япон улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр “Гэр хорооллын олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төслийн хүрээнд Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн 44-47-р гудамжны айл өрхүүдэд ашиглагдах цахилгааны шугамын нийт зардлын 80,0 хувь болох 16.48 сая төгрөг, мөн Говил багийн ТК-24-61-н хоорондох дулаан цэвэр усны шугамын зардлын 80 хувь болох 18.5 сая төгрөгийг дээрхи төсөл хөтөлбөрүүдээс хөрөнгийг нь гаргалаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3. Нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг үргэлжлүүлэн, нэмэгдүүлэх.</p>	<p>Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгосонтой холбоотой жилийн ажлыг зохион байгуулах комиссыг аймгийн Засаг даргын 2009 оны 10 дугаар захирамжаар томилж, комисс нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн хүрээнд хийгдэх төлөвлөгөө, хөрөнгийн тооцоог боловсруулан аймгийн иргэдийн хурлаар батлуулж, шийдвэрийг салбар комиссуудад хүргүүлэн, ажлыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>2009 оны 05 дугаар сарыг СӨХ-дын хүрээнд “Цэцэгжүүлэлтийн аян” нэртэй уралдаан зарлаж үндсэн 4 үзүүлэлтээр дүгнэж дүнгээ гаргалаа. Үүнд: Хайс хашлага, мод бут тарилт, цэцэгжүүлэлт, зүлэгжүүлэлт гэсэн үзүүлэлтээр дүгнэж, дүнгээ гаргалаа. Үүнд: Хайс хашлага, мод бут тарилт, цэцэгжүүлэлт, зүлэгжүүлэлт гэсэн үзүүлэлтээр дүгнэлээ. Энэ ажлын хүрээнд СӨХ-д 4-8 төрлийн мод бут тарьж ургуулсан бөгөөд хийсэн ажлыг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Хайс хашлага -2012.6 м - Мод бут тарилт -822 ш - Цэцгийн мандал -140 ш - Зүлэгжүүлэлт -9488 м²-ыг тус тус хийж гүйцэтгээд

			<p>байна.</p> <p>2009 онд Тогтвортой амьжиргаа-II төслийн хүрээнд 14 нэгж бүхий 139.8 сая, “Дэлхийн зөн” ОУБайгууллагаас 11 нэгж бүхий Боловсрол, Эрүүл мэндийн чиглэлээр тоног төхөөрөмж, сургалтанд зориулж 756.0 сая төгрөгийн ажил хийгдэж 210.1 сая төгрөг нь тоног төхөөрөмжид зарцуулагдлаа. Мөн Баян-Өндөр сумын гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаанжуулалтын зардалд зориулан ЭБЦТС ТӨХК-аас 2 дэд өртөө, Япон улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр “Гэр хорооллын олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төслийн хүрээнд Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн 44-47-р гудамжны айл өрхүүдэд ашиглагдах цахилгааны шугамын нийт зардлын 80 хувь болох 16.5 сая төгрөг, мөн Говил багийн цэвэр усны шугамын зардлын 80 хувь болох 18.5 сая төгрөгийг дээрхи төсөл хөтөлбөрүүдээс хөрөнгийг нь шийдвэрлэлээ.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		4. Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр бэлтгэгдэж байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн чанар, бүртгэлийн ажлыг сайжруулах	<p>Улсын болон орон нутгийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгийн данс бүртгэл, жилийн эцсийн тайлан балансад бүрэн гүйцэд тусгагдсан талаар Засаг даргын дэргэдэх агентлагууд болон Жаргалант суманд шалгалт явууллаа. 2009 онд орон нутгийн хөрөнгөөр Онцгой байдлын газрын тусгай зориулалтын авто машин, “Эрдэнэт-Ус” ДТС ОНӨ байгууллагад лабораторийн тоног төхөөрөмж, Цагдаагийн газарт хөдөлгөөнт эргүүлийн авто машин, Татварын хэлтэст 5 компьютер, Жаргалант сумын Соёлын төвд халаалтын тоног төхөөрөмжийг бэлтгэлээ.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
2.2.3.	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрэлтийг сайжруулж, татвар төлөгчдийн хүрээг өргөтгөн, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	1. Нийт төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлэх.	<p>Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг Төсөвт байгууллагуудад 100 хувь, аж ахуйн нэгж байгууллагуудын 98,0 хувьд бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		2. Татвар төлөгчдийн хүрээг өргөтгөж,	2009 оны эхэнд 30027 татвар төлөгч, иргэд аж

		<p>төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх.</p>	<p>ахуйн нэгж байгууллага байснаас оны эцэст 32349 татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгж байгууллага болж 7.7 хувиар өслөө. Дээрхи баазаас идэвхитэй татвар төлөгчид 15762 байна. Татварт хамрагдаагүй тээврийн хэрэгсэл, татвар төлөгчдийг илрүүлсний үр дүнд, тээврийн хэрэгслийн албан татвараар 35.0 сая, ҮХЭХөрөнгийн албан татвараар 5.0 сая төгрөгийн нэмэлт эх үүсвэр бий болж төсөвт төвлөрүүллээ. Хэрэгжиж байна 90%</p>
		<p>3. Татвар ногдуулалт, төлөлтөнд тавих хяналтыг сайжруулж, татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх.</p>	<p>Татварын өр 2009 оны эхэнд 3.5 тэрбум төгрөг байснаас 2.9 тэрбум төгрөгийн өр барагдаж 82.8 хувиар буурлаа. Тайлант хугацаанд 10.8 тэрбум төгрөгийн татварын ногдуулалт гарч 10.1 тэрбум төгрөгийн татвар хураан барагдуулж тайлант хугацааны татварын ногдуулалтын 93.5 хувь улс орон нутгийн төсөвт төвлөрүүллээ. Хяналт шалгалтын актаар тавигдсан татварын оны эхний өр 436.1 сая төгрөг байснаас 227.7 сая төгрөгийн өр барагдуулж 52.2 хувиар, тайлангийн хугацаанд 599.9 сая төгрөгийн хяналт шалгалтын өр гарснаас 149.0 сая өрийг барагдуулж 24.8 хувиар тус тус буурлаа.</p> <p>2009 онд 341 татвар төлөгчийн татварын ногдуулалт төлөлтөнд татварын хяналт шалгалт хийж 4.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 330.6 сая төгрөгийн нөхөн татвар, 204.2 сая төгрөгийн хүү торгууль ногдууллаа. Өөрчлөлтгүй тайлан гаргасан 17 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулж 59.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж 12.2 сая төгрөгийн ногдуулалт хийлээ. Алдагдалтай тайлан гаргасан 23 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулж 1294.9 сая төгрөгийн татварын ногдуулалт хийж 68.5 сая төгрөгийн нөхөн татвар ногдууллаа.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар татварын өр барагдуулах байнгын комиссыг байгуулан ажиллаж байна. Хугацаандаа төлөгдөөгүй татварын өртэй 70 аж ахуйн нэгж, байгууллагад татварын өр барагдуулах талаар мэдэгдэх хуудас гардуулан 52 аж ахуйн нэгж</p>

			байгууллагын банкин дахь харилцах дансыг татварын өрөө барагдуулж дуустал хаах арга хэмжээ авав. Хэрэгжиж байна 50%
2.2.4.	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгоно.	1. Орон нутгийн өмчийн хөрөнгийн дахин үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх.	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1, Засгийн газрын 2007 оны 167 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачилал”-ын дагуу Орон нутгийн өмчийн тооллого, дахин үнэлгээ хийх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан явууллаа.</p> <p>2009 оны 7-р сард Аймгийн Засаг даргын 1857 тоот албан бичгээр Орон нутгийн өмчийн тооллого, дахин үнэлгээг зохион байгуулах бэлтгэлийг хангах, зайлшгүй бүрдүүлсэн байх шаардлагатай баримт бичгийн талаар болон анхаарах асуудлуудын тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг байгууллага бүрт хүргүүлэн, 2009 оны 8, 9–р сард төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагын нягтлан бодогч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан.</p> <p>Тооллого, дахин үнэлгээний ажлыг орон нутагт зохион байгуулах комиссыг 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр Аймгийн Засаг даргын 2009 оны 317 дугаар захирамжаар томилон ажиллууллаа.</p> <p>Тооллого, дахин үнэлгээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө болон аймгийн комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан гаргаж Аймгийн Засаг даргаар батлуулан мөрдөж ажиллалаа.</p> <p>Тооллого, дахин үнэлгээнд орон нутгийн өмчит 82 байгууллага хамрагдсан. Тооллого, дахин үнэлгээний ажлыг орон нутгийн хэмжээнд амжилттай зохион байгуулж төлөвлөсөн хугацаандаа дуусгав.</p> <p>Орон нутгийн өмчийн Үл хөдлөх хөрөнгийг Эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулахтай холбогдсон бэлтгэл ажлыг 2009 онд бүрэн хангаад байна. Хууль батлагдмагц бүртгүүлж, гэрчилгээ авах ажлыг зохион байгуулна.</p>

			Хэрэгжиж байна 50%
		2. Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжиж, өмчийн нэгдсэн “Мэдээллийн сан” бий болгох.	<p>2008 оны жилийн эцсийн Орон нутгийн өмчийн тооллогын дүнгээр 83 байгууллагын 34,3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг Орон нутгийн өмчийн бүртгэлийн программд байгууллага тус бүрээр, хөрөнгийн ангилалаар нь нэг бүрчлэн шивж орууллаа. Ингэснээр орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн нэгдсэн “Мэдээллийн сан”-г бүрдүүллээ.</p> <p>2009 оны дахин үнэлгээний дүнг “Мэдээллийн сан”-д нэмж оруулахад бэлэн болоод байна. Цаашид жил бүрийн эцэст тооллогын дүнг үндэслэн Мэдээллийн санд үндсэн хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлтийг хийж ажиллана. Төлөвлөснөөс урьдчилж хийгдсэн.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
3. Хөдөө аж ахуйн бодлого, зохицуулалт			
2.3.1.	Хүн амын хүнсний хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.	1. Аймгийн хүн амын мах, махан бүтээгдэхүүн худалдан авах хэрэгцээг бүрэн хангах, махыг ангилан савлаж хөргүүлтэй лангуугаар худалдаалах хэлбэрт шилжих.	<p>Аймгийн нийт хүн амын махны хангамжийг зохистой түвшинд байлгахад сэрүүний улиралд хоногт 16.2 тн, зуны улиралд хоногт 12.2 тн, жилдээ 5431.5 тн мах, махан бүтээгдэхүүн шаардлагатай байдаг. Үүнээс өнөөгийн байдлаар хүн амын өдөр тутмын хэрэглээнд хоногт 6-8 тн махыг хүнсний зах, дэлгүүрүүдээр хэрэглэгчдэд нийлүүлж байгаа нь хэрэгцээт махны 57.4 хувийг эзэлж байна. Мөн үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хангалт 25.7 хувь ба хүн амын нийт хэрэгцээт махны хангалт 83.1 хувьтай байна.</p> <p>Манай аймгийн хэмжээнд мах боловсруулах 2, хиамны 3 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 14 худалдааны цэг салбар дээр мах, махан бүтээгдэхүүнийг бөөнөөр болон жижиглэнгээр худалдаалж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж байна. Дөмөг зах мал нядалгааны цэгийнхээ үйл ажиллагааг өргөжүүлж, мах сэврээх зориулалтын өрөө, шулалгааны цех, лабораторийн тоног төхөөрөмж, мал хүлээж авах, хашаа барих зэрэг 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгээд байна. Мөн “Монгема” махны үйлдвэр нь богийн шугам шинээр</p>

			<p>суурилуулахаар бэлтгэж байгаа ба “Эрдэнэт прогресс” махны үйлдвэр нь Герман улсын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хоногт 500 кг хиам үйлдвэрлэх хүчин чадал бүхий хиамны цех ашиглалтанд оруулаад ажиллаж байгаа нь мах, махан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгч байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		2. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг жилд 13-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	<p>Аймгийн хэмжээнд Эрдэнэт хаан сүү, Эрдэнэт шанд ХХК-иуд үнээний цэвэр сүүгээр үйлдвэрийн аргаар боловсруулсан ариутгасан сүү, сүүн ундаа, тараг, зайрмаг, цөцгий үйлдвэрлэн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд болон хүн амын хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан амин дэмээр баялаг чанартай, бүтээгдэхүүнээр хангаж байна. “Хаан сүү” үйлдвэр хоногт 500 литр сүү ариутган савлаж худалдаанд нийлүүлж байна. Мөн “Төгс бурзай” ХХК “Сүү төслийн нэгж”-ээс гэрээний дагуу хоногт 500 литр сүүг савлан ариутгадаг бага оврын сүү боловсруулах тоног төхөөрөмж татан авчирч суурилууллаа. Үүний үр дүнд аймгийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний 13,8 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна.</p> <p>ХХААХҮЯ-аас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар Эрдэнэт хаан сүү ХХК-д 35.0 сая төгрөг, Эрдэнэт-Оргил ХХК-д 15.0 сая төгрөгийн удаан хугацаатай, хүүгүй зээл олгосон ба зээлийн ашиглалт, үр ашгийн байдалд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		3. “Зоорь” төсөл хэрэгжүүлж, хүн амыг орон нутагт тариалсан төмс, хүнсний ногоогоор жилийн турш тогтвортой хангах	<p>Зоорь, хүлэмжийн аж ахуйг дэмжих журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд зоорь барих хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжид зураг төслийг гаргах, арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлагаар хангах зэргээр дэмжин ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар “Эрчимжсэн мал аж ахуй, зоорь, хүлэмжийн аж ахуйг дэмжих журам” батлан хэрэгжүүлж байна. Уг журмыг хэрэгжүүлж ажилласнаар иргэн, аж ахуйн нэгжүүд 450 тн багтаамж бүхий төмс, хүнсний ногоо хадгалах зоорь 6, 1000 м² шилэн хүлэмж, 480 м² нийлэг хальсан хүлэмжийг</p>

			шинээр барьж ашиглалтанд орууллаа. Хэрэгжиж байна 50%
		4. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжих	ХААНТөвийг түшиглэн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах цехийг ашиглалтанд оруулах, тогтвортой ажиллуулах бүхий л нөхцөл боломжийг судлан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Төмс, хүнсний ногоо боловсруулах үйлдвэр байгуулах, төсөл бичих, зээл тусламжинд хамруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажиллаж байна. Хэрэгжиж байна 30%
		5. Мал аж ахуй, газар тариалангийн дагнасан болон хосолсон эрчимжсэн аж ахуй 100-аас доошгүйг байгуулахад дэмжлэг үзүүлэх	Саалийн үнээ, гахай, тахианы зэрэг эрчимжсэн мал аж ахуйн фермер байгуулахаар эхлэл тавьсан, санал санаачлага гаргасан 15 иргэнд малын арчилгаа, маллагаа, тэжээллэг, байрны технологийн сургалт явуулж, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, 5 иргэний төсөлд хяналт хийж, аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас нэг фермерт 5.0 сая төгрөгийн зээл олголоо. Хөгжлийн шийдэл Төрийн бус байгууллага, Гэр санаачлага төслийн “Өртгийн гинжин холбоо” хөтөлбөртэй хамтран 16 иргэнийг тахиа, гахайны аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалт явуулж танилцах дадлагад хамрууллаа. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр ЖДҮ-ийг дэмжих сангаас сүүний үнээний фермер байгуулах, өргөтгөх 9 нэгжид 175.0 сая, махны үхрийн нэг аж ахуйд 13 сая, гахайн нэг аж ахуйд 6 сая, тахианы нэг аж ахуйд 35 сая, бүгд 12 аж ахуйн нэгжид 229 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй дунд хугацааны зээл олгож туслалцаа үзүүллээ. СНФ хөтөлбөрийн газартай хамтран гахайн аж ахуйн эдийн засгийн үр ашиг, мах боловсруулах технологийн талаар 2 удаа сургалт явуулж гахайн аж ахуй эрхлэгчид, сонирхогч 50 гаруй иргэдийг хамрууллаа. Хэрэгжиж байна 30%
		6. Эрчимжсэн аж ахуйг эдийн засгийн бодлогоор дэмжих журам боловсруулж,	Эрчимжсэн мал аж ахуйд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, журам боловсруулан баталж, санхүүжилтийг

		хэрэгжүүлэх	2010 оны төсөвт тусгаад байна. Хэрэгжиж байна 50%
		7. Шилмэл, өндөр ашиг шимт малын сүрэгт эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх зорилгоор мал эмнэлэг, үржлийн пункт байгуулах.	“Тогтвортой амьжиргаа-2” төслийн санхүүжилтээр Увс аймгаас баяд омгийн үржлийн 44 хуцыг Баян-Өндөр сумын малчдад, цэвэр үүлдрийн алатау, симменталь, хар тарлан бух 5-ыг Жаргалант сумын малчдын бүлэгт захиалгаар олгож үржилд ашиглаж байна. Малчид, фермерүүдийн санал хүсэлт захиалгаар цэвэр үүлдрийн болон эрлийз үржлийн үнээ, гунж, бух 40-ыг олгож зуучилсан бөгөөд үржлийн пункт байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. Хэрэгжиж байна 30%
2.3.2.	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалж, байгалийн эрсдлийг бууруулна.	1. Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийг шинэчлэн тоног төхөөрөмжөөр хангах	Аймгийн мал эмнэлэг, ариун цэвэр, оношлогооны лабораторийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд лабораторийн эмч мэргэжилтнүүдийг орон тоогоор ажиллуулах, мэргэшүүлэх, зориулалтын байраар хангах арга хэмжээнүүдийг авсны үр дүнд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Шувууны томуу, хүний цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслөөс 98.0 мянган долларын тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, лабораторийн хүчин чадал нэмэгдлээ. Биелсэн 100%
		2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулж, халдварт өвчин гарах нөхцлийг хязгаарлах	Аймгийн мал сүрэгт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг графикт хугацаанд нь бүрэн хамруулж, халдварт өвчин гарах эрсдлийг бууруулах, хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах арга хэмжээний хүрээнд хувийн хэвшлийн 8 мал эмнэлэгтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 16 нэр төрлийн вакцинд 310.3 мянган толгой мал хамруулахаас 306.3 мянган толгой мал хамруулж 98.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Уг арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2009 оны 193 дугаар захирамжаар график төлөвлөгөөг батлан сумдад хүргүүлэн зохион байгуулалтыг хангаж байна.

			Хэрэгжиж байна 50%
		3. Адууны ям, халдварт цус багадалт, үхэр, хонь, ямаа, тэмээний бруцеллэз зэрэг архаг халдварт өвчнүүдээс мал сүргийг эрүүлжүүлэх	Улсын мал эмнэлэг, үржлийн газрын даргын баталсан удирдамж, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу архаг халдварт бруцеллэз өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг 2009 оны 06-р сарын 01-ний өдрөөс 09-р сарын 02-ны өдөр явуулав. Уг арга хэмжээнд 240.3 мянган толгой мал хамруулахаас 240849 мал хамруулж гүйцэтгэл 100.2 хувьтай хэрэгжлээ. Шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн малын оношийг баталгаажуулах, ялган нядлах ажил хийгдэж байна. Төлөвлөгөөний дагуу үхрийн сүрьеэгийн танадах шинжилгээг 3.0 мянга, адууны ямын танадах шинжилгээг 6.0 мянган толгой бодод хийж гүйцэтгэл 100.0 хувь байна. Тухайн өвчнүүд манай аймагт оношлогдоогүй байна. Адууны халдварт цус багадах шинжилгээг 11572 адуунд хийх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 69.1 хувьтай байна.
		4. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, гүн өрмийн худгийн тоог 40-өөс доошгүйгээр нэмэгдүүлэх	Хэрэгжиж байна 70%
		5. Жил бүр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх.	Бэлчээрийн усан хангамжийн хүрээнд 12 худаг засварлахаар судалгаа гаргаж, сумдын нөөц бололцоонд түшиглэн 2 худагт урсгал засвар хийж ашиглалтанд орууллаа. Баян-Өндөр сумын 4 худагт “Бүрхаш” нөхөрлөл 4.3 сая төгрөгийн, Жаргалант сумын 2 худагт “Ус-Ундрах” ХХК 2.0 сая төгрөгийн засвар хийж, малчдад хүлээлгэн өглөө.
		6. Бэлчээрийн талхлалтаас хамгаалах зорилгоор тууврын замын маршрутыг	Хэрэгжиж байна 30%
			Биелсэн 100%
			Аймгийн хэмжээнд 9000 тн хадлан, 15 тн гар тэжээл бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Баян-Өндөр суманд 6060 тн хадлан, Жаргалант суманд 2940 тн хадлан бэлтгэх, 300 тн хадланг нөөцөд төвлөрүүлэх даалгавар өгч, бэлтгэл ажлыг хангуулснаар Баян-Өндөр сум 5652 тн, Жаргалант сум 2710 тн хадлан авч аймаг, сумын нөөцөд 311 тн хадлан, 40 тн гар тэжээл нөөцөллөө.
			Хөрш зэргэлдээ Булган аймаг, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумдын удирдлагыг оролцуулсан

		<p>өөрчлөн тогтоож, бэлчээр, хадлангийн талбайн асуудлаар хөрш зэргэлдээ аймаг, сумдын удирдлагуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах.</p>	<p>хамтарсан уулзалт, ярилцлагыг Эрдэнэт хотод зохион байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, түүнд бэлчээрийг зөв зохистой ашиглах чиглэлээр тодорхой асуудал тусган хэрэгжүүлж байна. Тууврын малын өнгөрөх чиглэлийг тогтоох зорилгоор тууврын замыг тогтоох, хотын ногоон бүсийг хамгаалах арга хэмжээний захирамж гарган Баян-Өндөр, Жаргалант сумд, мах боловсруулах Эрдэнэт прогресс, Монгема, УБҮ-ийн мах боловсруулах үйлдвэрүүдэд хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Аймгуудтай хийсэн хамтарсан уулзалтын хүрээнд 700 гаруй хадланчид зэргэлдээ сумдаас хадлангийн талбай ашиглан нийт хадлангийн 80 гаруй хувийг бэлтгэж авсан болно.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>7. Мянган сорилтын сангийн “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийг хэрэгжүүлэх.</p>	<p>Монголын мянганы сорилтын сангийн хот орчмын бэлчээрийн төслийн багтай 2-3 удаа хамтарсан уулзалт сургалт, ярилцлага зохион байгуулав. Аймаг, сумдын удирдах ажилтан, хөдөө аж ахуйн мэргэжилтэн зэрэг 20 гаруй хүнийг хамруулж, сум бүрт 6-7 хүний бүрэлдэхүүнтэй, малчдын бүлэг фермерүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж, шалгуур үзүүлэлтийг гаргалаа. Уг төслийн багтай хамтран малчдын 31 бүлгээс өргөдөл хүлээн авч эцсийн шалгаруулалт хийхээр бэлтгэж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
<p>2.3.3.</p>	<p>Атрын III аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж техник, технологийг шинэчилнэ.</p>	<p>1. Газар тариалангийн техник шинэчлэлтийг 40-өөс доошгүй хувьд хүргэх</p>	<p>Жаргалант сумын “Бүтлийн ундарга” ХХК, “Орхон тариа” ХХК, “Алтан тошлой” ХХК, Атрын III аяны хөнгөлөлттэй зээлүүдэд хамрагдаж 60 хувийн техник шинэчлэл хийлээ.</p> <p>Атрын III аяны хүрээнд нийт 1 746,2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авснаас 514,4 сая төгрөгөөр 40 га-гийн услалтын систем барьж, үр тарианы том оврын трактор 2, бага оврын трактор 2, үтрэмийн ЗИС-60 1, хавагч 1, үрлэгч 1-ийг авлаа.</p> <p>“Бүтлийн ундрага” ХХК 140 га-ийн услалтын систем 620,0 сая төгрөгөөр, Т-150 трактор 49,0 сая, хор цацагч 8,0 сая, 2 ш комбайн 56,6 сая, үрлэгч 34,2 сая, үтрэмийн</p>

			<p>техник 20,0 сая төгрөгөөр, “Алтан тошлой” ХХК 50 га-гийн усалгааны систем 444,0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгээд байна.</p> <p>“Сүмийн нуга” хоршоо, “ББ-ОД” ХХК-иудад Шон Деере трактороор техник шинэчлэл хийлээ.</p> <p>Биелсэн 100%</p>
		<p>2. Тариалангийн талбайд жил бүр 2-оос доошгүй гүн өрмийн худаг гаргаж, инженерийн хийцтэй услалтын систем байгуулан, усалгаатай талбайн хэмжээг 500 га-д хүргэх.</p>	<p>Орхон тариа, Бүтлийн ундарга компаниуд 218 га талбайг усалгаажуулах хүчин чадал бүхий 2 услалтын системийн барилгын ажил хийгдэж, Бүтлийн-Ундрага ХХК услалтын системийн барилгын ажил дуусгаж 139 га талбайн услалтын системийг бүрэн хэмжээгээр ашиглалтанд орууллаа. Ингэснээр 139 га усалгаатай талбай нэмэгдлээ. Алтан тошлой ХХК ХХААХҮЯ-аас зарласан услалтын системийн тендерт 148.8 га талбайг усалгаажуулах төсөл боловсруулан оролцож байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3. Хүлэмжийн болон хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлж хүнсний ногооны нэр төрлийг олшруулах.</p>	<p>Зоорь, хүлэмжийн аж ахуйг дэмжих журам боловсруулан Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засаг даргын захирамж гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна. Зоорь, хүлэмжийг дэмжих зорилгоор иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, гарын авлага материалаар хангалаа.</p> <p>Баян-Өндөр сумын агропарк 120м² нийлэг хальсан хүлэмж, иргэн, аж ахуйн нэгж 360м² нийлэг хальсан хүлэмж, мөн 1000м² шилэн хүлэмжийг, нийт 1480м² хүлэмжийг шинээр барьж ашиглалтанд оруулж өргөст хэмх, улаан лооль тариалж хэрэглэгчдийн хүнсний хэрэгцээнд нийлүүллээ.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Тариалангийн талбайд агрохимийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөрсний бүтэц, үржил шимийг тодорхойлох</p>	<p>Аймгийн хэмжээнд нийт тариалангийн талбайд агрохимийн шинжилгээг хийх ажлыг зохион байгуулж, 6-р сард Дархан-Уул аймгийн УГТСЭШХүрээлэнгийн Хөрс судлалын сектортой хамтран, хөрсний дээж авах талаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд сургалт явуулах хөрсний шинжилгээний дээжийг авах ажлыг зохион</p>

			байгуулж тариалангийн талбайн хөрсний үржил шимийг тогтоолгохоор дээжүүдийг хүргүүлээд байна. Хэрэгжиж байна 30%
4. Байгаль орчин, газрын харилцааны бодлого, зохицуулалт			
2.4.1.	Байгалийн нөөц баялгийг хамгаалан, зүй зохистой нөхөн сэргээж, ашиглуулна.	1. Ойг нөхөн сэргээж, гэрээгээр эзэмшүүлэх хэмжээг нэмэгдүүлэн, үр дүн, чанарыг дээшлүүлэх.	<p>БОАЖЯ-аас 2009 оны 4-р сарын 5, 6-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулсан “Байгаль хамгаалагчдын чадавхийг сайжруулъя” сэдэвт 2 өдрийн сургалтад иргэдийн нөхөрлөлийн ахлагчдыг хамруулж, шаардлагатай гарын авлага материалаар хангалаа.</p> <p>Ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 5 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд шалгалт хийж, ололт дутагдлыг газар дээр нь ажиллаж, зөвлөмж өгөв. Шалгалтын нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2009 оны 246 дугаар захирамжаар “Ойн хүрээ”ХХК, Баян-Өндөр сумын Засаг даргын 2009 оны 369 дугаар захирамжаар “Сархиа”, Жаргалант сумын Засаг даргын 2009 оны 94 дугаар захирамжаар “Амин төгөл” нөхөрлөлүүдийн гэрээг цуцалж үйл ажиллагааг зогсоолоо. 2009 онд шинээр Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт “Унаган байгаль” иргэдийн нөхөрлөлд 422 га талбай бүхий ойн санг гэрээгээр эзэмшүүлээд байна.</p> <p>Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмыг 2009 оны Засгийн газрын 227 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан тул урьд жилүүдэд ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа иргэдийн нөхөрлөлүүдийн гэрээг шинэчилж дахин хийхээр төлөвлөж, Баян-Өндөр уулын ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмыг өөрчлөн аймгийн ИТХТ-ийн хурлаар батлуулахаар өргөн бариад байна.</p> <p>Шинээр гарсан “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг ойн сан бүхий нутаг дэвсгэрт нутагладаг малчдад сурталчлан таниулах, малчдын санал бодлыг судлах зорилгоор БОАЖГ-аас томилогдсон ажлын хэсэг Жаргалант сумын 46 өрхийн 90 гаруй иргэдийг</p>

			<p>хамруулан сургалт сурталчилгаа хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.</p> <p>Аймгийн болон сумдын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулахаар Ойн газар, БОАЖЯ-д тус тус хүргүүлснээс гадна ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа 3 иргэдийн нөхөрлөл, гэрээгээр эзэмших хүсэлт гаргаад байгаа 1 аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөг хянан баталгаажуулаад байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Булаг шандын эхийг хамгаалж, гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлэн, усны зүй зохистой хэрэглээг бий болгох.</p>	<p>2009 онд улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Шувуутын амны булгийн эхийг хамгаалж, тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог “Сов” ХХК-аар ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан БОАЖЯамаар батлуулж, Шувуутын булгийн эхийг тохижуулах, хамгаалах ажлыг эхлүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласны зэрэгцээ гүйцэтгэлийг БОАЖГазрын даргын 2009 оны 15 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг 2009 оны 09 сарын 13-ны өдөр хүлээн авч холбогдох материалыг бүрдүүлэн БОАЖЯаманд хүргүүллээ.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>3. Газрын хэвлий, ашигт малтмалын ашиглалтанд тавих хяналтыг сайжруулж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх</p>	<p>Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 8 аж ахуй нэгжээс 3 аж ахуй нэгжийн 2009 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянаж, БОАЖЯамаар баталгаажуулж хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн замыг шинэчлэх, өргөтгөх асфальтаар хучих зориулалтаар аймгийн Засаг даргын 2009 оны 227 дугаар захирамжаар “Очир төв” ХХК, “Орхон-А33А” ТӨХК-нд түр хугацаагаар ердийн ашигт малтмал ашиглуулахаар 1.5 га газрыг олгосоны дагуу “Очир төв” ХХК 0,8 га-д, “Орхон-А33А” ТӨХК 0,7га-д, “Сид-Со” ХХК 1,6га-д, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2,5 га-д нийтдээ 5,6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг, “Зунрун” ХХК 2.1 га талбайд 8 кг олон настын үр, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2,5 га-д 131 улиас, 1000 шинэсний тарьц суулгаснаар</p>

			<p>нийт 4,6 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгэв.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
2.4.2.	<p>Байгаль орчны бохирдолтыг бууруулж, хүний амьдрах эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.</p>	<p>1. “Цагаан тоос” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2015 он хүртэлх ажлын төлөвлөгөөг үргэлжлүүлэн, байгальд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах.</p>	<p>Байгаль орчны сайдын баталсан “Цагаан тоос” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2008-2015 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Хангал гол дагуу хорио цээрийн бүс тогтоох ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, Эко натур ХХК-ний хооронд байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байна. -Цагаан тоосыг бууруулах ажлын хүрээнд хаягдлын аж ахуйн хиймэл нуурын дагуу ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэж байгаа “Ойн хүрээ” ХХК, Монголын ахмадын чөлөөт холбооны Орхон аймаг дахь салбарын “Эх дэлбээ-3” төсөл зэрэг газруудад БОАЖГазрын даргын 2009 оны 13 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь шалгалт, тооллогыг явууллаа. <p>Шалгалт, тооллогоор 2007-2009 онуудад “Ойн хүрээ” ХХК нь 4.9 км урттай, 28 м өргөнтэй ойн зурвас байгуулж 5 нэр төрлийн 50.0 мянга гаруй ширхэг мод бутыг тарьж бойжуулж байна, “Эх дэлбээ-3” төсөл 6 га газарт 27.0 мянган гаруй тарьц суулгасанаас 300 гаруй ширхэг мод ургуулсан байгаа нь хангалтгүй гэж дүгнэв.</p> <p>-Эрдэнэт үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг шинэчлэн тодорхойлох ажлыг “ЭКОС” ХХК гүйцэтгэж байна.</p> <p>-Цагаан тоос хөтөлбөрийн биелэлтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан аймгийн ЗДТГ, Технологийн сургууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон АНУ-ын өмнөд Дакодагийн их сургууль хамтран онол практикийн бага хурал зохион байгуулсан.</p> <p>“Номин” телевизтэй иргэдийн төлөөлөл, аймгийн МХГ, БОАЖГ-аас хамтран 90 минутын нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.</p> <p>- Цагаан тоостой бүсэд амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндэд хяналт тавих ажлын хүрээнд үндсэн бүлгийн 30 хүнээс 25 иргэнийг (Баянцагаан баг-15, Говил баг-5, Жаргалант сум-5) эрүүл мэндийн иж бүрэн</p>

			<p>үзлэг шинжилгээнд хамруулж эмч нарын зөвлөлгөөнөөр хэлэлцэж дүгнэлт гаргууллаа. Үзлэгийн дүнгээр эрүүл 3, ямар нэгэн өвчлөлтэй 22 хүн байгаагаас 27 хувь нь Цагаан мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэлтэй болох нь тогтоогдлоо.</p> <p>- Цагаан тоос хөтөлбөрийн биелэлтийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-аас аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэн цаашид авах арга хэмжээний талаар санал зөвлөмжүүдийг гаргав.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах зорилгоор нөлөөлөх байдлын үнэлгээнд бүрэн хамруулах.</p>	<p>Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудын дагуу Тогтвортой амьжиргаа-2 төслийн шинээр хэрэгжих 11 төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг, 10 аж ахуйн нэгж, иргэдийн төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг тус тус хийж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн 11 аж ахуйн нэгж, байгууллагын байгаль хамгаалах 2009 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулсан “Байгаль орчинд ээлтэй цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” уралдаанд нийт 23 төсөл хамрагдсанаас 19-д нь байгаль орчинд нөлөөлөх байдлын дүгнэлт гаргаж, уралдааныг хамтран дүгнэлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдийн тоог бууруулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх, гэр хорооллын ахуйн хэрэглээний цахилгааны шөнийн хөнгөлөлттэй тарифт тоолуурт шилжүүлэх.</p>	<p>Нам даралтын уурын зуухны хэрэглээг багасгах бодлого баримталж, шинээр нам даралтын уурын зуух ашиглалтанд оруулахыг хориглоод байна.</p> <p>“Эрдэнэт-Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК, холбогдох удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, гэр хорооллын айл өрхийн цахилгаан хэрэглээний үнийг шөнийн цагаар хямдруулах, эрчим хүчний ачааллын тооцоо судалгааг Цагаанчулуут багийн АТП-203 дэд</p>

			<p>станц, Эрдэнэ багийн АТП-207 дэд станцуудын баруун, зүүн гаргалаа дээр хийлээ. Тооцоонд 1 гаргалаа дээр 50 өрх, нийт 200 өрхийн цахилгаан халаагуур тавих тооцоо хийж үзэхэд 1 гаргалаанд 190А-264А шаардагдах бөгөөд одоогийн шугамын гүйдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 175 А байгаа нь ачаалал даахгүйд хүрч цаашид шугам, дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргаж байна. Эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагчдын зөвлөлийн 2008 оны 94-р тогтоолоор баталсан үнэ тарифийг мөрдөж, 2008 оны 176-р тогтоолоор батлагдсан журмын дагуу хөнгөлөлттэй тарифаар үйлчилж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Утаа багатай хатуу, шингэн түлшний үйлдвэрлэлийг дэмжиж хэрэглээг нэмэгдүүлэх, түлшний захын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах, утаагүй халаалтын системийг гэр хороололд нэвтрүүлэх.</p>	<p>“Шингэрүүлсэн шатдаг хий” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2003 оны 208 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2003 оны 423 дугаар захирамжаар баталсан шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “Гор газ” ХХК-ний Орхон аймаг дахь гэрээт борлуулагчтай хамтарч хэрэгжүүлсэнээр 2009 онд 150 аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд 34500 кг, иргэдийн хэрэгцээнд 10500 кг тус тус нийлүүлж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад хэрэглээ нэмэгдэж байна.</p> <p>“Шингэрүүсэн шатдаг хийн хэрэглээ, аюулгүй ажиллагааг хангах нь” сэдэвт сургалтыг хийн түлш ашигладаг иргэд, аж ахуйн нэгжийн 54 төлөөлөгчдөд аюулгүй ажиллагааны сургалтыг явуулан 4 төрлийн 264 ширхэг гарын авлагыг тарааж, хийн түлшийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллалаа.</p> <p>Булган аймгийн Бугат, Орхон сумууд 2009 оны 9, 10 –р саруудад Баян-Өндөр сумын Дэнж, Шанд багийн нутаг дэвгэрт түлээ борлуулах цэгүүдийг байгуулан манай иргэдийн түлшний хэрэгцээг хангаж эхлээд байна.</p> <p>Баян-Өндөр сумын нэг иргэний үйлдвэрлэлийг дэмжсэнээр түүхий эдийн нөөцөд тулгуурлан Бугат суманд шахмал түлшний үйлдвэрлэлийг байгуулан</p>

			<p>өөрийн бүтээгдэхүүнээ гэр хорооллын иргэдэд 10-40 кг-аар савлан борлуулалт хийж байна.</p> <p>Утаа багатай шингэн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх талаар сурталчилгааны ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийж байгаагийн зэрэгцээ түлээний захын үйл ажиллагааг иргэдэд ойртуулан хямд үнээр борлуулахад нь дэмжлэг үзүүлж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 30%</p>
		<p>5. Удаан задардаг органик бохирдуулагчаар үйлдвэрлэсэн баглаа боодлоос татгалзаж цаас, даавуун сав баглаа боодлын хэрэглээнд шилжих.</p>	<p>ЕБС-иудын сурагчдын дунд “Нэг сурагч-Нэг уут” хөдөлгөөнийг 14 хоногийн хугацаатай, 2 үе шаттай зохион байгуулж 4854 сурагч тус бүр 1 тор хийж оролцон хэрэглээнд шилжүүлсэнээс 32 сурагчийн торыг шалгаруулж бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргав.</p> <p>Цаашид ЕБС-иуд технологийн хичээлээр хүүхэд бүр уут оёж, ахуйн хэрэглээндээ ашиглах зорилго тавьж ажиллаж байна. Мөн аймгийн жижиг дунд үйлдвэрлэл дэмжих сангийн иргэд, аж ахуйн нэгжийн зээл авахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгээс цаас, давуун сав баглаа боодол үйлдвэрлэх “Төгс төгөлдөр урлан” ХХК /цаасан уут/, Албан бус сургалтын төв /даавуун уут/, иргэн Б.Амаржаргалын “сайн санаа төсөл” /даавуун уут/ зэрэг төслүүдийг хэлэлцэж дэмжин холбогдох материалыг Монгол шуудан банкинд хүргүүлээд байна.</p> <p>“Саран Үйлс” ХХК нь 40 х 48 см хэмжээтэй төрөл бүрийн давуун уутыг үйлдвэрлэж “Даниста”, “Тэргүүн-хүнс”, “Төгөл” зэрэг худалдаа үйлчилгээний газруудад 13.0 мянган ширхэг даавуун уутыг нийлүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран даавуун болон цаасан уутыг үйлдэрлэгч иргэд, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих өдөрлөгийг 2009 оны 7 сарын 9-ний өдөр найрамдал талбайд зохион байгууллаа.</p> <p>Иргэдэд явуулсан сурталчилгааны үр дүнд томоохон супермаркетууд /Номин супермаркет, Эрдэнэт Их дэлгүүр, Төгөл групп-Миний дэлгүүр/ нь даавуун баглаа боодолд шилжиж, сард дунджаар 1800-2000ш тор борлуулахын зэрэгцээ 9 иргэн тогтмол даавуун тор</p>

			<p>үйлдвэрлэж хүнсний захууд дээр сард дунджаар 150-200 уутыг борлуулж хэрэглээнд шилжүүлж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>6. Химийн хорт бодисын хэрэглээг бууруулах бодлого баримталж, химийн бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах.</p>	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар химийн бодисын ашиглалт, хадгалалтанд зөвлөгөө өгөх орон нутгийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, химийн бодисын 6 дахь удаагийн улсын үзлэг тооллогыг 9-р сарын 7-ноос эхлэн 14 хоногийн хугацаанд явууллаа. Тооллогод аймгийн хэмжээнд 174 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хамрагдлаа. Тооллогоор нийт 3162707.253 кг бодис бүртгэгдсэнээс онцгой хортой 636,953 кг, хортой 1123921,2 кг, бага хортой 2035294,35 кг, азон задалдаг 2854,75 кг бодис тоологдсон.</p> <p>Тооллогын хугацаанд илэрсэн зөрчил дутагдалд комиссын зүгээс 2 албан тушаалтан, 3 иргэн, 1 аж ахуйн нэгжийг нийтдээ 175.0 мянган төгрөгөөр торгож, 15 газарт албан шаардлага өгч, 1 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоогоод байна.</p> <p>2009 оны химийн бодисын Улсын үзлэг тооллогын дүнг нэгтгэсэн тайланг гаргаж мэдээллийн санд бүртгэж авлаа.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>7. Шингэрүүлсэн шатдаг хийн станц байгуулах ажлыг дэмжих.</p>	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар “Чес” ХХК-нд шингэрүүлсэн шатдаг хийн станц байгуулах зориулалтаар VII хорооллын төв замын урд талд 1 га газрыг эзэмшүүлсэн. “Чес” ХХК нь олгогдсон газартаа эрчим хүчний шугамыг татах, газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх, хөрөнгө оруулалт хийх асуудлыг “Гор газ”ХХК, “Юни газ”ХХК зэрэг газруудад саналаа хүргүүлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
2.4.3.	Бүх нийтийн оролцоотойгоор хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж “Эрүүл ногоон” хотыг бий	1 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд иргэд, нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх.	Аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 төрийн бус байгууллага байдаг бөгөөд байгаль хамгаалах үйлсэд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хэлбэрээр хамтран ажиллаж байна.

	болгоно.		<p>2009 онд МБОХХ-ны Баян-Өндөр сумын салбар зөвлөл, Баян-Өндөр сум, БОАЖГ-ын хамтран ажиллах гурвалсан төлөвлөгөө боловсруулаад хяналт шалгалтын чиглэлүүдээр хамтран ажиллаж байна.</p> <p>Энэхүү төлөвлөгөөний дагуу хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор тарьц суулгац, үр, бордооны үзэсгэлэн худалдааг хамтран 2 удаа ажил хэргийн уулзалт 2 удаа тус тус зохион байгуулаад байна.</p> <p>Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж 2009 онд “Унаган байгаль” иргэдийн нөхөрлөлд 422 га ойн санг Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт гэрээгээр эзэмшүүлэн тус нутгийг эзэнтэй болгосноор хамгаалалт сайжирч байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		2 Иргэд, аж ахуйн нэгжийн санаачилгаар мод үржүүлгийн газрын нэгдсэн парк байгуулах.	<p>Мод үржүүлгийн ажил эрхлэх хүсэлтэй иргэдийн дунд төсөл сонгон шалгаруулах зарыг орон нутгийн хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр нийтэд зарлаж, мод үржүүлгийн ажил эрхлэхээр ирүүлсэн 3 төслөөс “Ан дел” ХХК-ны төслийг шалгаруулж, хуучин тээврийн товчооны зүүн хойт талд 3 га талбайг эзэмшүүлэх шийдвэрийг Баян-Өндөр сумын Засаг даргын 2009 оны 287 дугаар захирамжаар гаргав.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		3 Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн өрнүүлж хотын болон гэр хорооллын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гэр хорооллын иргэдийн хашаанд мод тарих төсөл хэрэгжүүлэх.	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2008 оны 02 дугаар тогтоолоор 2009 оныг “Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласнаар уг ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2009 оны 10 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж төлөвлөгөөг 3 зорилт 27 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулан хэрэгжүүллээ.</p> <p>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хаврын ажлын хүрээнд “нэг иргэн–нэг мод”, “нэг өрх–нэг мод” уриан дор хөдөлгөөнийг өрнүүлж тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгууллаа.</p> <p>Хаврын ногоон байгууламжинд шаардлагатай хар шороо 670 м.кв, элс 180 м.кв татаж бүх нийтээр мод</p>

			<p>тарих өдрийг 4 дүгээр сарын 25,26–ны өдөр болгон зарлаж хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 3 нэр төрлийн 618 мод, 8 нэр төрлийн 1357 бут, сөөг, 2 нэр төрлийн /шар хуайс, хайлаас/ 8100 бутаар ургамлын хашлага хийж, 11400 м² талбайд 550 кг согооврийн үр зарцуулан зүлэгжүүлж, 6 нэр төрлийн 4130 цэцгийн үрсэлгээгээр 68 м² талбайд цэцэг тарьсан.</p> <p>265 аж ахуйн нэгж 4 нэр төрлийн 1081 мод, 6 нэр төрлийн 948 бут сөөг орчиндоо тарьж арчилгаа усалгаа хийж байна.</p> <p>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх намрын ажлын хүрээнд нийтийн эзэмшил газар 3 нэр төрлийн 465 мод, 4 нэр төрлийн 1927 бут, сөөг, 2 нэр төрлийн 6740 бут, сөөгөөр ургамлын хашлага хийж усалгааг технологийн дагуу гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрхүүд өөрийн хашаандаа 16542 мод, 921 бут, сөөг тарьж ургууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4 Байгаль орчныг хамгаалахад идэвхитэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Байгаль хамгаалах, орчноо тохижуулахад идэвхитэй оролцож байгаа иргэдийг урамшуулах болзол бүхий журам боловсруулж, түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлахаас гадна ногоон байгууламж байгуулах үйлсэд идэвхи зүтгэл үр бүтээлтэй оролцсон 6 аж ахуйн нэгж, байгууллага, 20 иргэнийг аймгийн Засаг даргын нэрэмжит “Ногоон гэрчилгээ”, дурсамж, мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг ногоон байгууламжийн төв комисс гаргаад байна.</p> <p>“Байгаль орчинд ээлтэй цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” уралдааны хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг бууруулахгүйгээр байгалийн нөөц баялагийн ашиглалт, зарцуулалтыг багасгах, технологийн шат дамжлагаас гарах хог хаягдлыг эргүүлэн ашиглуулах зорилт тавин ажиллаж, нийтдээ 23 иргэн, байгууллага хамрагдсанаас 6 байр шалгаруулан шагнаж урамшууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
2.4.4.	Газрын нөөц чадавхид	1. Сумдын газар зохион байгуулалтын	Баян-Өндөр болон Жаргалант сумдын газар

	<p>тулгуурласан төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>тухайн жилийн төлөвлөгөөг хот байгуулалтын бодлого шийдвэртэй уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>зохион байгуулалтын тухай жилийн төлөвлөгөөг боловсруулахын тулд төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-өөр иргэдэд төслийн анхны хувилбарыг танилцуулж, санал авах ажил зохион байгууллаа. Мөн эдгээр сумдын Засаг дарга болон багуудтай хамтран ажиллан газар дээр нь иргэдийн дунд түүвэр судалгаа явуулж, ирсэн саналуудыг хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан Газар зохион байгуулалтын 2009 оны төлөвлөгөөнд тусгаж, 5 зорилт, 36 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймаг, сумдын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Хэрэгжиж байна 90%</p>
		<p>2. Аймгийн хилийн цэсийн асуудлыг шинэчлэн тогтоолгох замаар хотын эдэлбэр газрын нөөцийг нэмэгдүүлж, иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхон аймгийн Жаргалант сумын хилийн цэсийн маргааны талаар ГХГЗЗГ-т хүсэлт гаргаж, аймаг сумын хилийг тогтооход ашигладаг 1:100000 масштабтай 1969, 1984 оны байрзүйн зургуудыг хуулбарлан авч зурагт тэмдэглэсэн хилийн шугамын эргэлтийн солбицолыг газар дээр нь электрон тахеометр, гар GPS багажаар хэмжилт хийж, аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллуулав. Булган аймгийн ГХБХБГ-тай хамтран Баян-Өндөр, Орхон сумдын хилийн цэсийн тэмдэгтүүдэд тодотголын ажил хийж, Орхон сумын нутагт Баян-Өндөр сумын 800 гаруй өрх хашаа барьж ашиглаж байгааг тогтоож, уг асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлэж өгөх хүсэлтийг Орхон сумын ИТХ-д хүргүүлээд байна. Хэрэгжиж байна 10%</p>
		<p>3. Аж ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх ажлын мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах.</p>	<p>Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан газрын бодлого, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө зэргийг үндэслэн Баян-Өндөр, Жаргалант сумдын 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг явуулах ажлын төлөвлөгөөний дагуу Согоот, Эрдэнэ, Их залуу багийн нутагт худалдаа үйлчилгээ, орон сууц, эмийн сан, ШТС, авто засвар, үйлчилгээний зориулалтаар нийт 0.76 га</p>

			<p>газрыг аймгийн Засаг даргын 2009 оны 320 дугаар захирамжийн дагуу дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж Согоот багийн нутагт авто засварын зориулалтаар 0.045 га газрыг 3.0 сая төгрөгөөр 1 иргэнд эзэмшүүлж, эзэмших гэрээ байгууллаа. Бусад байршил дээрх газруудад 2 удаа дуудлага худалдааг зарласан боловч санал ирээгүй болно.</p> <p>Нэгдсэн давхар гарааш, ус цэвэршүүлэн савлах үйлдвэрийн зориулалтаар төсөл сонгон шалгаруулах ажлыг аймгийн Засаг даргын 2009 оны 217 дугаар захирамжаар томилогдсон төсөл сонгон шалгаруулах комисс зохион байгууллаа. Нэгдсэн гараашийн зориулалтаар 2 төсөл ирснээс иргэн Ч.Хулбаатар, ус цэвэршүүлэн савлах үйлдвэрийн зориулалтаар 1 төсөл ирж “Бурхаш”ХХК тус тус шалгарлаа.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
2.4.5.	Аймгийн газрын мэдээллийн санг баяжуулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нээлттэй ил тод үйлчилнэ.	<p>1. Азийн хөгжлийн банкны төслөөр хийгдэж байгаа кадастрын зураглалын ажлыг бүрэн хийлгэн хүлээн авах ажлыг зохион байгуулах</p>	<p>“Газрын бүртгэл ба кадастрын зураглал” төслөөс Баян-Өндөр, Жаргалант сумын кадастрын зураглал, түүний бүртгэл, байрзүйн дэвсгэр зураг /1:1000 масштабтай/, газрын кадастрын мэдээллийн бааз суурь, программ хангамжийг иж бүрнээр хүлээн авч, иргэдэд зураглал, бүртгэлийн мэдээллээр үйлчилж байна.</p> <p>2009 онд өссөн дүнгээр 3353 иргэн, 480 аж ахуйн нэгж, байгууллагын кадастрын зураглалыг шинэчлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Газрын харилцаатай холбоотой зөрчил, маргааны шалтгааныг тогтоон бууруулах арга хэмжээ авах</p>	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар Хотын төв зам дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн газар ашиглалтын байдал болон хотын төвд дураараа барьсан хашаа, барилга байгууламжид үзлэг хийх, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан төв зам дагуу байрлаж буй Уурхайчин багийн 3-17 дугаар байрны ард байрлах 1, Худалдаа хөгжлийн банкны барилгын урд байрлах павилонууд, Хүрэнбулаг ХХК-ний зүүн талын Голомт банкны хашаа, Зэст баг 1-16 дугаар байрны хийцийг өөрчилж өргөтгөл хийсэн “Квартал”, “Арт”, Метёор, иргэн Д.Мягмарсүрэнгийн кафе, Уртбулаг</p>

			<p>баг 5-23-ны байрны буланд иргэн Г.Ганболд, Хүрэнбулаг баг 4-1-р байрны буланд н.Энхбулаг нарын газруудын өргөтгөлийг буулган газрыг нь чөлөөлөөд байна. Мөн 3-17 дугаар байрны хойд талд автобусны буудал дээр баригдсан үйлчилгээний зориулалттай павьлион, 5-17 дугаар байрны урд талд баригдсан хашаа, ОХУ-ын консулын хашааны ард зөвшөөрөлгүй баригдсан хашааг тус тус албадан буулгаж, газрыг чөлөөллөө.</p> <p>Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Баян-Өндөр сумын Засаг даргын захирамжийн дагуу гэр хороололд зөвшөөрөлгүй, дураараа газар эзэмшиж байсан Рашаант багийн Уртын голын хэсгийн 30 айлын хашааг албадан буулгаж, 6 иргэний хашааг багасгуулан татууллаа. Мөн Их залуу, Эрдэнэ багийн нутагт зөвшөөрөлгүй хатгасан хашааны шонгуудыг албадан буулгалаа. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын асуудлыг Баян-Өндөр сумын Засаг дарга хариуцан шийдвэрлэж байна.</p> <p>Булган аймгийн Орхон сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Орхон сумын нутагт зөвшөөрөлгүй хатгасан хашааны шонгуудыг албадан буулгаж, газрыг нь чөлөөлөв.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3. Газрыг “Газрын төлөв байдал, чанар”-ын улсын хянан баталгаанд бүрэн хамруулах.</p>	<p>Газрын төлөв байдал чанарын хянан баталгаанд хамрагдаагүй байсан Баян-Өндөр сумын нутаг дахь 700 га, Жаргалант сумын нутаг дахь 500 га, нийт 1200 га талбайд хянан баталгаа хийлгэх ажлыг ГХБГЗЗГ-аас зарласан төсөл сонгон шалгаруулалтанд шалгарсан мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий "Глобус"ХХК-аар гүйцэтгүүлж, хянан баталгаанд хамрууллаа.</p> <p style="text-align: center;">Биелсэн 100%</p>
		<p>4. Жижүүрийн зураглалын чанарыг сайжруулж, мэдээллийн санг тогтмол баяжуулах.</p>	<p>Кадастрын нэгдсэн зураглал, газрын бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүр кадастрын нэгдсэн зураглалд шинэчлэлт хийж, холбогдох бүртгэл мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>

		5. Газрын кадастрын системийг бүрэн автоматжуулах	<p>Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжигдэж байгаа “Газрын бүртгэл ба кадастрын нэгдсэн зураглал” төслийн хүрээнд газрын кадастрын нэгдсэн мэдээллийн санг бүрэн автоматжуулав. Мөн “Мянганы сорилтын сан”-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд манай аймагт хөдөлгөөнт GPS-ийн станц байгуулах, сансрын зураглалаар хангах талбайн хил хязгаарын судалгааны ажил хийгдэж байна.</p> <p>Мэдээллийн сангийн нэгдсэн сүлжээнд холбогдох бэлтгэл ажлын хүрээнд уг мэдээллийн санд интернет ашиглан холбогдох туршилтын ажил хийгдэж эхэлж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>
2.4.6.	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаа үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.	1. Гол горхи, булаг шандны усны урсац химийн найрлага бохирдолтын түвшинд мониторинг хийх	<p>2009 оны аймгийн гадаргын усны тооллогын хүрээнд одоо урсаж байгаа болон ундаргатай байгаа хүн малын унданд газар тариалангийн усалгаанд ашиглаж байгаа 18 гол горхи тойрмын уснаас дээж авч химийн найрлага, бохирдлын түвшин тогтоох шинжилгээ хийлээ. Үүнд Гол 4, горхи булаг 12, тойром рашаан тус бүр 1 байна. Хангал голд 18 удаа, Чингэл, Уртбулаг голуудад 5 удаа, горхи, булаг, рашаан, тойромд тус бүр 1 удаа шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний дүнгээр Хангал гол, Бүрэн бүстийн тойром бохирдолтой, Чингэл, Уртбулаг, Борт, Модот зэрэг булгууд бага бохирдолтой Бусад нь цэвэр буюу маш цэвэр зэрэглэлд хамаарч байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
		2 Агаарын чанарт нөлөөлж буй утаа, цагаан тоосны тархалтын судалгааны цэгийг шинээр нээн ажиллуулах	<p>Агаарын чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа цагаан тоосны судалгааны явуул цэгүүдийг тогтоон хэрэгцээт багаж төхөөрөмжөө аваад байна. Гэр хороололд өвлийн улиралд ихсэж байгаа угаарын хийн хэмжээг тогтоох зорилгоор 24 цагийн ажиллагаатай тусгай багажийг 1-4-р саруудад хорооллын гал унтраах байранд шинээр байрлуулж ажиллууллаа.</p> <p>2009 онд Гэр хорооллын цэгээс 181 удаа агаарын сорьц аван шинжлэхэд хүхэрлэг хийн дундаж агууламж нь 0.010 мг/м³, азотын давхар исэл 0.061 мг/м³ байна.</p>

			<p>Үүнээс хүхэрлэг хийн хамгийн их агууламж нь 0.032 мг/м³ энэ нь 1 дүгээр сарын 29-ны 23 цагийн сорьц, азотын давхар ислийн хамгийн их агууламж нь 0.116 мг/м³ буюу 2 дугаар сарын 5-нд өглөөний 8 цагийн сорьцыг тодорхойлоход ийм байв. Угаарын хийн хэмжилтийг 2009 оны 1 дүгээр сарын 8-наас 1 дүгээр сарын 27-н хүртэл 30 минутын давталттайгаар хэмжилтийг хийхэд дундаж агууламж нь 18.4 мг/м³, хамгийн их агууламж нь 140.3 мг/м³ байгаа нь стандартаас 2.3 дахин давсан байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		<p>3 Хур тунадас нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх газрын төхөөрөмжийг шинээр суурилуулах</p>	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газраас үүлэнд зориудаар нөлөөлөх борооны пуужин харвах газрын төхөөрөмжийг олголоо. Уг төхөөрөмжийг орон нутагт ажиллуулах, ашиглах зардлыг тухайн аймаг нь хариуцдаг тул 2010 оны ажлын зардалд шаардагдах 871.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс хариуцна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		<p>4 Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны бохирдуулалтын хяналт шинжилгээний ажлыг үргэлжлүүлэх</p>	<p>Үйлдвэр аж ахуйн нэгжүүдэд хийгдсэн БОНБНҮнэлгээнд заагдсан хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн тусгай хуваарь гарган ажиллаж байна. Тухайлбал, Монгол-Америкийн хамтарсан зэсийн Эрдмин үйлдвэрт 15 хоног тутамд хөрсний усны хяналтын 9 цооногоос усны сорьц, 4 цэгээс агаарын сорьц, улиралд нэг удаа 6 цэгээс хөрсний сорьц авч бохирдлын шинжилгээ хийж хянаж байна. Мөн хотын бохир ус цэвэрлэх байгууламж, ДЦС, Шим технологжи ХХК-ийн үйл ажиллагаанд хуваарийн дагуу орчны бохирдлын хяналт шинжилгээг хийж байна. “Шим технологжи” ХХК-аас агаарын 2 сорьцыг үйлдвэрийн гадна ба дотор гэсэн 2 цэгээс авлаа. Хүхэрлэг хий үйлдвэрийн гадна 0.005 мг/м³ байхад үйлдвэрийн дотор 0.007 мг/м³ байна. Азотын давхар ислийн хувьд үйлдвэрийн гадна 0.028 мг/м³ байхад үйлдвэрийн дотор 2.409 мг/м³ байгаа нь стандартаас 28 дахин давсан байна.</p> <p>“Эрдмин” ХХК-аас 33 удаа агаарын сорьц аван</p>

			<p>шинжилгээ хийхэд хүхэрлэг хийн дундаж агууламж нь 0.007 мг/м³, азотын давхар исэл 0.048 мг/м³ байна. Зэс утасны үйлдвэрт хийсэн угаарын хийн 8 удаагийн хэмжилтээр дундаж агууламж нь 1.11 мг/м³, байв. Тоосны агууламжийг мөн 10 удаа авахад Эрдмин үйлдвэрт дундаж нь 5.6 мг/м³, зэс утасны үйлдвэрийнх 13.7 мг/м³ байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		5 Цаг агаарын сар, улирлын урьдчилсан мэдээ, мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэх.	<p>Хавар, намрын улиралд тохиолдох цаг агаарын аюултай үзэгдлээс учирч болох хохирлоос иргэд аж ахуйн нэгжийг урьдчилан сэргийлэх зорилгоор 6 удаа сэрэмжлүүлэх мэдээ, 21 удаа анхааруулах мэдээ, хоногийн ба хагас хоногийн тус бүр 365 урьдчилсан мэдээг зохион орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр болон бичгээр холбогдох газруудад хүргэсэн байна. Мөн 9-р сарын 18-21-ний өдрүүдэд болсон цаг агаарын онц аюултай үзэгдлийн үеэр иргэд аж ахуйн нэгжид учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай өдрүүдэд цаг тутамд Онцгой байдлын албанд шуурхай мэдээлж ажиллалаа.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
2.4.7.	Байгаль хамгаалах сурталчилгааны эрчимжүүлнэ.	орчныг сургалт ажлыг	<p>1 Байгаль орчны хамгаалах сарын ажлыг жил бүр зохион байгуулж бүх нийтийг хамруулах.</p> <p>Байгаль хамгаалах хаврын сарын ажлыг “ГЯЛГАР УУТНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ТАТГАЛЗЪЯ” уриан дор 9 үндсэн зорилтын хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ.</p> <p>Байгаль хамгаалах намрын сарын ажлыг БОАЖ-ын сайдын 2009 оны 259 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу 09 сарын 15-аас 10 сарын 15-ны хооронд “Бид-байгаль дэлхийн үрс” уриан дор 12 ажил төлөвлөн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Үүнд:</p> <p>Орон нутгийн “Номин” телевизтэй хамтран “Уур амьсгалын өөрчлөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйл”, “Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар”, “Амьдрах орчин”, “Байгаль хамгаалах уламжлал” гэсэн сэдвүүдээр нээлттэй теле хэлэлцүүлэг зохион байгуулж, байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд, үүссэн шалтгаан, үр дагаврыг нийтэд</p>

			<p>мэдээллээ.</p> <ul style="list-style-type: none"> - Агаарын бохирдолтыг буруулах зорилгоор шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг сурталчлах сургалтыг 36 аж ахуйн нэгжийн 54 төлөөлөгчдийг хамруулан зохион байгуулж, гарын авлага материалаар хангав. - Намрын хуурайшлын үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх явган болон хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж, түймрээс сэргийлэх санамж бичиг 3000-ийг хэвлүүлэн олон нийтэд хүргэв. - Боловсрол соёлын газартай хамтран тусгай удирдамжийн дагуу “Бид байгаль дэлхийн үрс” сэдвийн агуулгын хүрээнд байгаль орчныг бохирдуулагч эх үүсвэрүүдийн талаар ЕБС-н сурагчдад хичээл заах арга зүйн зөвлөмж өгч сургалт зохион байгуулж, 12 сургуулийн 40 багшийг хамрууллаа. - “Цэвэр орчинг бүрдүүлье” уриан дор бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулав. Үүнд: 357 аж ахуйн нэгжийн 4573 хүн хамрагдаж 19869 м² талбайг цэвэрлэн, 362 м³ хогийг тээвэрлэн хогийн цэгт төвлөрүүллээ. <p style="text-align: right;">Биелсэн 100%</p>
		<p>2 Байгаль орчны хууль тогтоомжуудаар сургалт сурталчилгааг иргэдийн дунд тогтмол явуулах.</p>	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны хууль тогтоомжуудын хэрэгжилтийг шалгахын зэрэгцээ иргэд аж ахуйн нэгжүүдэд шинээр гарч буй хууль тогтоомж, дүрэм журмыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилж байна. - БОАЖЯ-ны багтай хамтран аймгийн хэмжээнд ажилладаг байгаль орчны байгууллагуудын ажилтнуудын нэг өдрийн зөвлөгөөн, иргэдийн нөхөрлөлийн ахлагчид болон байгаль хамгаалагчдад зориулсан 2 өдрийн сургалтыг, цагдаагийн ажилтнуудад Ойн тухай хууль, Мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын талаар 90 минутын сургалт зохион байгуулав. - Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа болон цаашид гэрээгээр эзэмших сонирхолтой Жаргалант сумын иргэдийн нөхөрлөлүүдийн ахлагч нар болон иргэдэд Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолоор

			<p>батлагдсан журам, Ойн тухай хуулийн холбогдох заалтуудаар нэг өдрийн сургалт зохион байгуулж мэргэжлийн зөвлөгөө өглөө.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		<p>3 Байгаль орчны мэдээллийн санг баяжуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй үйлчлэх.</p>	<p>Аймгийн байгаль орчны мэдээллийн санг жил бүр баяжуулан төрөлжүүлэхийн зэрэгцээ “Байгаль орчны төлөв байдлын тайлан”-г жил бүр гаргаж, гарч буй өөрчлөлтүүд, хийгдэж байгаа нөхөн сэргээлтийн ажлуудыг тусган иргэдэд нээлттэй үйлчилж байна. Мөн гадаргын усны тооллогын тайлан, байгаль хамгаалах сарын ажлын тайлан болон химийн бодисын улсын үзлэг тооллогын тайлан гаргаж, мэдээллийн санг баяжуулав.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
5.Тээвэр, харилцаа холбоо, аялал жуулчлалын бодлого, зохицуулалт			
2.5.1.	Тээврийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, менежментийг боловсронгуй болгоно.	<p>1. Хот хооронд орон нутгийн тээврийн үйлчилгээний “Автовокзал”-ыг орчин үеийн шаардлага стандартад нийцүүлэн барьж ашиглалтад оруулах.</p>	<p>Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймаг, хот хоорондын автовокзалын газрыг аймгийн Засаг даргын 2008 оны 05 сарын 08-ны өдрийн 160 дугаар захирамжаар Баянцагаан багийн нутагт олгов.</p> <p>Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
		<p>2.Тээврийн хэрэгсэлийн оношлогооны стандартад нийцсэн барилга барьж ашиглалтанд оруулах.</p>	<p>Авто тээврийн хэрэгслийн оношлогооны төвийн газрыг захирамжаар Автовокзалын газартай хамт нэг дор байхаар Баянцагаан багийн нутагт олгоод байна.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
		<p>3. Нийтийн тээврийн үйлчилгээний төв замын чиглэлд том, дунд оврын автобусаар үйлчлэх боломжийг бүрдүүлэх.</p>	<p>Судалгаа тооцоог үндэслэн “Орхон автобус” төсөл боловсруулж бэлэн болгов.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>4. Нийтийн тээврийн үйлчилгээний маршрутын дагуу автобусны буудлуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн барьж байгуулах.</p>	<p>Зорчигч урсгалын судалгаа, нийтийн хэрэгцээ шаардлага ихтэй албан байгууллагуудын байршилд үндэслэн хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг аймгийн Засаг даргын 99 дугаар захирамжаар шинэчлэн баталж 2009 оны 04 сарын 01 ний өдрөөс 12 маршрут, 26 такси зогсоолоос нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Баян-Өндөр сумын ЗДТГ-ын байр өөрчлөгдсөнтэй</p>

		<p>холбогдуулан шинэ байршилд ойр автобусны зогсоолуудыг байгуулж нийтийн тээврийн үйлчилгээгээр хангах нөхцлийг бүрдүүлсэн.</p> <p>- Нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг шинэчилж Нарангийн 71-р гудамж, Хотын их тойруу, Шанд-Хабитат хойгуур, урдуур, Баян-Өндөр сум, зэрэг маршрутыг шинээр нээж нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>- Тээврийн хэрэгслийн өнгө үзэмжийг сайжруулах, зорчигчдын тав тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцүүлэн 89 микро автобусыг насжилтаар үйлчилгээнээс хасаж 41 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийв.</p> <p>- НТҮ-ний тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, үйлчилгээний соёлтой цэвэр орчоор байнга үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор НТҮ-нд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийг стандартын дагуу техникийн оношлогоонд оруулж давхардсан тоогоор нийт 2080 тээврийн хэрэгсэл хамруулав.</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээний 6 компанийн жолооч кондукторуудад үйлчилгээний соёл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, стандарт сурталчлах сургалтыг зохион байгуулж нийт 312 хүнийг хамруулав.</p> <p>Дэнж, Уурхайчин багт автобусны зогсоол 3-ыг шинээр, Шанд багт 3 автобусны зогсоолыг сэргээн засварлаж тохижууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 30%</p>	
		<p>5. Такси үйлчилгээг тоолууржуулах, баталгаажуулах лаборатори байгуулах.</p>	<p>Такси үйлчилгээг тоолууржуулах "Эрдэнэт-такси" төсөл боловсруулж бэлэн болгов. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй тул хотын дотор нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй компаниудын нөөц бололцоонд тулгуурлан 200 такси симфоржуулах ажлыг зохион байгуулж эхлээд байна.</p> <p>2010 онд тоолуурын баталгаажуулах лаборатори байгуулах хөрөнгийг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд уг арга хэмжээ 2010 оноос хэрэгжихээр хөтөлбөрт тусгагдсан болно.</p>

			Хугацаа болоогүй.
		6. Автосервисийн үйлчилгээг стандартын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх	<p>2009 оны 4 сард нийт 21 авто засварын газарт МХГ-тай хамтарсан MNS5025-2001 стандартын шаардлагад нийцүүлэн шалгалт хийв. Уг шалгалтаар 4 аж ахуйн нэгж, байгууллага иргэнийг 60000 төгрөгөөр торгож 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоов. 9 аж ахуйн нэгжид зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлийг хангуулж ажиллалаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		7. Агаарын тээврийн үйлчилгээг сэргээн хөгжүүлэх.	<p>Зам тээвэр барилга хот байгуулалтын яаманд Аймгийн Засаг даргын 2009 оны 5 дугаар сарын 01-ний 1/651 тоот албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт асуудлыг тавьж, Изинис компаниас манайд тавьсан саналыг хамт хүргүүлэв. Тус газраас 2009 оны 05 сарын 26 ны өдрийн 11/883 тоот албан бичгээр манай аймгийн нисэх буудлыг сэргээн ашиглах саналыг дэмжиж байгаа хэдий ч нисэх буудлыг засварлах, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах зэрэгт тодорхой хөрөнгө шаардлагатай байгаа тухайгаа манайд мэдэгдээд байна.</p> <p>Асуудлыг Зам тээвэр барилга хот байгуулалтын яаманд тавьж тус яамны Зам тээврийн бодлогын газраас ажлын хэсгийг томилон ажиллуулж нисэх буудлыг ажиллуулж эхлэхэд 308,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн тооцоо гаргаад байна.</p> <p>Хэрэгжиж байна 10%</p>
		8. Авто замын хураамжийн байршлыг оновчтой тогтоож, орон нутгийн замын хураамжийн цэг байгуулан хяналтыг сайжруулах асуудлыг шийдвэрлэх.	<p>Зам тээвэр барилга хот байгуулалтын яаманд Аймгийн Засаг даргын 2009 оны 02 сарын 12 ны өдрийн тоот албан бичгээр асуудлыг тавьлаа. ЗТБХБЯамнаас хураамжийн цэгийг шилжүүлэх боломжгүй талаар хариу ирүүлсэн бөгөөд хотын суурьшлын бүс уг цэгээс гадагш тэлсэн талаар дурьдаж асуудлыг дахин тавиад байна.</p> <p>Хэрэгжих шатандаа 10%</p>
2.5.2.	Аялал жуулчлалын хөгжлийн маркетинг,	1. “Бурхан багшийн сэрэг дүр цогцолбор”-ыг ашиглалтанд оруулах.	“Бурхан багшийн сэрэг дүр” амралт чөлөөт цагийн цогцолборын барилгын ажил үргэлжлэн хийгдэж

	<p>менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p>		<p>байгаа бөгөөд суурь, үндсэн бурхан багшийн дүрийн бадны хэсгийг цутгаж дууссан. Уг цогцолборын шаардлагатай санхүүжилтээс “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хамтарсан зөвлөлийн хурлаараа 500,0 сая төгрөг шийдвэрлэж олгоод байна.</p> <p>Бурхан багшийн сэрэг дүрийн нийт 90 шахам тн-ын жинтэй 450 гаруй эд ангиас 30 тн-ын жинтэй 185 эд ангийг өнгөт металлээр цутгаж, эвлүүлж, гагнан цогцолборын байран дээр бадныг бүрэн угсарсан. Цогцолборын барилга угсралтын ажлын 90 орчим хувь болох сэрэг дүрийг “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн Засвар механикийн завод дээр өнгөт металлээр цутгах ажлын тал хувь хийгдэж сүншиг аравнайд орох бурхан багшийн зураг 10 сая, сүнгийн ном 10 сая, арц 12 тн зэрэг бэлтгэгдэж, сэрэг дүрийг алтдах хуудас алт 350000 ширхэг бэлэн болж, цогцолборын нийт ажлын гүйцэтгэл 75 гаруй хувьтай болоод байна.</p> <p>Уг цогцолбор 2010 оны эхний хагас жилд багтан бүрэн ашиглалтанд ороход 1,0 тэрбум төгрөг шаардлагатай байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
		<p>2. Зочид буудал, амралтын газруудын үйл ажиллагааны менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Аялал жуулчлалыг Хангайн бүсийн хөгжлийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилт”, “Өнөө ба ирээдүй” сэдэвт зөвлөлгөөнийг Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооноос 2009 оны 02 дугаар сарын 4-5-ны өдрүүд Өвөрхангай аймгийн Хархорим суманд зохион байгуулахад “Эрдэнэт хивс”, Эрдэнэт зочид буудал, аймгийн Музей зэрэг байгууллагуудын төлөөлөл бүхий 11 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн худалдаанд аймгийн бренд бүтээгдэхүүнээ танилцууллаа.</p> <p>Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлын ажилтнуудын дунд “Зочид буудлын менежмент” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг 2009 оны 9-р сард зохион байгууллаа.</p> <p>Тус сургалт зөвлөгөөнд 24 зочид буудлын захирал,</p>

			менеджерүүд хамрагдлаа. Уг сургалт зөвлөгөөнөөр зочид буудлын орон нутгийн салбар зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг оролцогчдоор батлуулж үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллуулж эхлээд байна. Хэрэгжиж байна 50%
		3. Зочид буудлуудын үйлчилгээний чанарыг сайжруулж, “Од”-ны зэрэглэлтэй зочид буудлын тоог нэмэгдүүлэх.	Аймгийн Засаг даргын 2009 оны 195 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг аттестатчлал явуулахын зэрэгцээ томоохон зочид буудлуудад одны зэрэглэлд хамруулах судалгааг давхар явуулж “Тамир”, “Эрдэнэт”, “Молор-Эрдэнэ” зэрэг зочид буудлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох материалыг бүрдүүлэх, саналаа боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхээр шийдвэрлэв. Хэрэгжиж байна 30%
		4. Жуулчдыг татах, нийтийн чөлөөт цагийг өнгөрүүлэх идэвхтэй амралтын газруудыг байгуулах.	“Баясгалант Хангай” ХХК аймгийн хүүхдийн паркийг байгуулан 2012 онд бүрэн ашиглалтанд оруулахаар үйл ажиллагаагаа эхлүүлж, энэ онд алсыг харагч, морин тойруулга, хөгжөөнт аялал тоглоомуудыг ашиглалтанд оруулж, хашаа хайс хийгээд байна. Ирэх жил шинээр тоглоом суурилуулах, зүлэгжүүлэлт, ногоон байгууламж зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна. Хэрэгжиж байна 50%
		5. Summer sun” оюутан залуучуудын их наадмыг 2 жил тутамд зохион байгуулж, аймгийн брэнд болгох.	Хугацаа болоогүй
2.5.3.	Мэдээлэл, харилцаа холбооны техник технологийг сайжруулж, хотын захын хорооллуудад харилцаа холбооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Их залуу, Эрдэнэ, Баянбулаг баг тус бүрт 50 хосын кабелийн өргөтгөл хийж, мэдээлэл харилцаа холбооны техникийн нөхцлийг бий болгох.	Төсөв тооцоо хийгдсэн. Аймгийн ИТХ-ын 2009 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоолоор аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс хасагдсан тул тодорхой ажил хийгдээгүй. Хэрэгжих шатандаа 10%
		2. “Цахим Эрдэнэт” мэдээллийн нэгдсэн сүлжээнд шинээр байгуулагдсан багуудыг холбох.	Төсөв тооцоо хийгдсэн. Аймгийн ИТХ-ын 2009 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоолоор аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх

			үндсэн чиглэлээс хасагдсан тул тодорхой ажил хийгдээгүй. Хэрэгжих шатандаа 10%
		3. “Цахим Эрдэнэт” сүлжээний программ хангамжийн ашиглалт, хэрэглээг сайжруулах, мэдээ мэдээллийг Online-аар дамжуулж хэвших.	Аймгийн төсвийн байгууллагуудын “Цахим Эрдэнэт” нэгдсэн сүлжээнд ажиллаж байгаа байгууллагууд компьютерийн дотоод сүлжээндээ болон интернэтэд холбогдон мэдээллийн технологийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хадгалах, хамгаалах журмыг 2009 оны 02 дугаар сарын 25 ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна. Багийн зохион байгуулагч нарын программ хангамж, сүлжээний сургалтыг зохион байгуулж цахим сүлжээнд ажиллах чадварыг дээшлүүлсэн. Хэрэгжиж байна 70%
		4. Шуудан тээврийн үйлчилгээг зорчигч тээврийн үйлчилгээтэй уялдуулж шуудангийн үйлчилгээг бүсийн хэмжээнд өргөжүүлэх.	Шуудангийн үйлчилгээний газар, Тээвэр автозамын газар хамтарсан гэрээ байгуулж шууданг нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслээр илгээдэг болгож аймгийн 2 сумаас гадна Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум, Булган аймгийн Хангал, Бугат, Сэлэнгэ сумууд болон Хялганат хорооны чиглэлд үйлчилж 7 хоногт 4-6 удаа шуудан хүргэж байна. Дархан хотоос 7 хоногийн 6 өдөрт шуудан тээвэрлэдэг болсон бөгөөд замын дагуу сумууд болох Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхон аймгийн Жаргалант сумуудад шуудан хүргэлтийн давтамж нэмэгдэж 7 хоногт 6 удаа шуудан солилцож байна. Хэрэгжиж байна 50%
		5. Шуудангийн ZIP коджуулах ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусгах.	“ЗИП” коджуулах аргачлал, нутаг дэвсгэрийн байршлын зураг дээр кодыг оноож өгсний дагуу Шуудан үйлчилгээний газраас Баян-өндөр, Жаргалант сумдад багуудын кодыг хүргүүлж мэдээллийн хэрэгслээр 2 удаа, Эрдэнэт таймс сонинд хэвлүүлж нийтэд сурталчилсан Биелсэн 100%
		6. Булган -Бугат- Эрдэнэтийн шилэн кабелийн мэдээлэл холбооны дамжуулах системийг байгуулж, ашиглалтанд	Шилэн кабелийг татаж, төгсгөлийн төхөөрөмжүүдийг суурилуулан 2009 оны 4 сарын 20 нд Булган-Бугат-Эрдэнэтийн шилэн кабелийн системийг

		оруулах.	ашиглалтанд авч мэдээлэл холбооны сувгийн багтаамж 37 дахин нэмэгдээд байна Биелсэн 100%
		7. Эрдэнэт- Дарханы чиглэлийн шилэн кабелийн мэдээлэл холбооны дамжуулах системийг ашиглалтанд оруулж төвийн бүсийн цагираг суурь сүлжээг бий болгох.	2010 оны үндсэн чиглэлд тусгагдаж байгаа Хугацаа болоогүй
		8. Говилын районд үйлдвэр технологийн парк байгуулахтай холбогдуулан мэдээлэл холбооны шилэн кабелийн сүлжээ болон салбар кабелийн сүлжээг байгуулах.	Хугацаа болоогүй
		9. Шинээр баригдах хорооллуудыг холбоожуулах асуудлыг шийдвэрлэх.	Хүлээгдэж байна. Хугацаа болоогүй
		10. Суурин холбооны шинэ үеийн NGN технологийг нэвтрүүлэх.	Хугацаа болоогүй
		11. F- zone буюу утасгүй телефоны BTS төхөөрөмжийн өргөтгөл хийх.	F-zone BTS төхөөрөмжийн өргөтгөлийг Говил баг, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны төв байранд хийж 1 дүгээр улиралд 571, 2 дугаар улиралд 394, 3 дугаар улиралд 74, 4 дүгээр улиралд 207 хэрэглэгчийг холбон нийт хэрэглэгчийн тоо жилийн дүнгээр 2008 хүрч нэмэгдүүлсэн байна. Биелсэн 100%
		12. Интернетийн ADSL үйлчилгээний урсгал болон портын хэмжээг нэмэгдүүлэх.	Интернетийн DSLAM-ын портыг 128 хэрэглэгчээр нэмэгдүүлэн хэрэглэгчдийг холбож байнгын интернет хэрэглэгчийн тоо 765-д хүрлээ. Хэрэгжиж байна 70%
Гурав: Хот байгуулалт, хот тохижилтын бодлого Хот байгуулалтын бодлогыг өмчийн олон хэлбэрийн оролцоонд тулгуурлан хотын Ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах эрүүл, цэвэр орчинг бүрдүүлнэ.			
3.1.1.	“Эрүүл хот” төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Барилга байгууламжийн орчны тохижилтыг бүрэн хийлгэн ашиглалтанд хүлээж авах	2009 он гарсаар “Төгөл”, “Их мандал”, “Молор-Эрдэнэ”, “Мөнх-Ачит”, “Сонорхайрхан”, худалдааны төвүүд, Дэлхийн зөн олон улсын байгууллагын захиргааны барилга, 17 дугаар сургуулийн спорт заал, Говил баг, Жаргалант сумын халуун усны барилга, Баянцагаан, Говил багийн ус түгээх цэг, Магнай трейд ХХК-ны ШТС барилгыг гадна тохижилтыг хийлгэж улсын комиссоор хүлээн авлаа.

			Хэрэгжиж байна 90%
		2. Хот тохижилтын ажилд олон нийтийн оролцоог идэвхжүүлэх	<p>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мод, бут, сөөг, зүлэг тарих гарын авлага, 251 нарс, 78 шинэс тарааж, 5 дугаар сарын 17, 18, 25, 26-ны өдрүүдэд мод, ургамал, үр бордооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, иргэд, байгууллагуудыг мод, ургамал тарихад уриалан ажиллалаа. 265 аж ахуйн нэгж, байгууллага 4 нэр төрлийн 1081 мод 6 нэр төрлийн 948 бут сөөг орчиндоо тарьж арчилгаа усалгаа хийв.</p> <p>Мөн гэр хорооллын иргэд хашаандаа 16500 мод, 921 бут сөөг тарьж ургуулав. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд мод бут зүлэг цэцгийн мандал тарьж ургуулсан орчноо тохижуулсан төсвийн 3 байгууллага, 3 аж ахуйн нэгж, 30 иргэнийг шалгаруулан аймгийн Засаг даргын нэрэмжит цом, ногоон гэрчилгээ, мөнгөн шагналаар урамшуулав.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
		3. Жилд 2-оос доошгүй гудамж, өргөн чөлөөг тохижуулах.	<p>Тюръяковын нэрэмжит гудамжинд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Нацагдорж, Залуучууд, Отгонбилэгийн гудамжуудад нийт 4871м хамгаалалтын хайс хийж, 3 нэр төрлийн 618 мод /шинэс, агч, нарс/, 8 нэр төрлийн 1357 бут сөөг ургамлан хашлагад 2 нэр төрлийн 81100 бут сөөг /шар хуайс, хайлаас/ мөн 11400м² талбайд 550 кг зүлэгний үр цацаж зүлэгжүүлж, 6 нэр төрөл 4130 цэцгийн үрслэгээг цэцэгийн мандал болгон суулгаж ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.</p> <p style="text-align: center;">Биелсэн 100%</p>
		4. Барилгын болон бусад газар шорооны ажлын төсөвт гадна тохижилт, нөхөн сэргээлтийн хөрөнгийг тусгуулан чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэх.	<p>Шинээр баригдаж байгаа барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн ажлын төсөвт гадна тохижилт, зам талбайн нөхөн сэргээлтийн зардлыг тусган дулааны улиралд хийж, гүйцэтгүүлж байна. Хотын зам талбай, гэрэлтүүлэг ногоон байгууламжийг үнэлэх, нөхөн сэргээх барьцаалах журмыг боловсруулав.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
		5. Гэрийн хорооллын 1-ээс доошгүй багийн цахилгаан, дулаан цэвэр, бохир усны асуудлыг цогц байдлаар	<p>Их залуу багт 140 хүүхдийн цэцэрлэгийн барилга баригдаж байгаа бөгөөд цаашид 640 хүүхдийн сургууль бусад үйлчилгээний барилга баригдахтай холбогдуулан</p>

		<p>шийдвэрлэн, инженерийн хангамж бүхий орчин үеийн загвар хороолол болгох.</p>	<p>орчин үеийн дэвшилтэт технологи бүхий халаалтын зуух, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төвлөрсөн цэвэр бохир усны шугамд холбохоор төлөвлөж байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>6. Хотын оршуулгын газрын менежментийг өөрчлөн, орчин үеийн шаардлагад нийцүүлэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p>	<p>Одоогийн байгаа оршуулгын газарт нэгдсэн комисс гарч үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргалаа. Оршуулгын газар нь талбайн хувьд хүрэлцэхгүй болсон, хотынхоо баруун хойд тал салхины дор байрласан гэр хорооллын айл өрхтэй хаяа зэрэгцэн байрлаж байгаа нь эрүүл ахуйн хувьд таарахгүй болсон байна. Иймд хуучин оршуулгын газрыг хааж, “Ястын” хөндийд байршуулж, одоо байгаа оршуулгын газрыг хүндэтгэлийн газар болгож, эргэн тойронд 40 шинэс, 200 хайлаас тарьж цэцэрлэгжүүлэн, оршуулгын газрыг тэлэх үйл ажиллагааг зогсоож, Бурхан шашны зан үйлд нийцүүлэн Шарил чандарлах орчин үеийн буяны сүм барьж ажиллуулахаар Булган аймагт газрын асуудлыг тавиад байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>7. Орон сууцны болон гэрийн хорооллуудын гэрэлтүүлгийг шинэчлэх</p>	<p>2009 онд орон сууцны 5,6-р хорооллуудын гэрэлтүүлгийг сэргээн засварлах болон гэр хорооллын 5 хэсэг харанхуй гудамжуудад одоо байгаа цахилгааны шонгуудыг ашиглан сэргээгдэх эрчим хүчээр тэжээгдэх гэрэлтүүлэг тавихаар төлөвлөсөн боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй. Уг асуудлын талаар ТИС-ын профессорын багтай хамтран судалгааны ажил хийгээд байна.</p> <p>Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх төслийн хүрээнд Шанд, Булаг, Баянцагаан, Говил багт харанхуй гудамжинд гэрэлтүүлэг тавих, цахилгааны хүчдэл сайжруулах чиглэлээр 6.5 сая төгрөгийн ажил хийгдлээ.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>8. Хотын гудамж, зам талбай, барилга байгууламжийг хаягжуулах</p>	<p>Аймагт 23 сууц өмчлөгчдийн холбооны нийт 109 байрны хаягийг сэргээн засварлалаа. Хотын нийтийн гудамж талбайд хаягжуулалт хийх хөрөнгө 2009 онд</p>

			<p>төлөвлөгдөөгүй.</p> <p>Хэрэгжих шатандаа 30%</p>
		<p>9. Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны фасаданд байрлуулсан иргэд, аж ахуйн нэгжийн зар, реклам сурталчилгааг хотын өнгө үзэмжид нийцүүлж, хяналт тавих.</p>	<p>Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны фасаданд байрлуулсан иргэд, аж ахуйн нэгжийн зар, реклам сурталчилгааг хотын өнгө үзэмж, хууль тогтоомжид нийцүүлэх, хотын төв гудамжинд зар сурталчилгааны самбар шинээр нэмж байрлуулахгүй байх бодлого баримтлан ажиллаж байна.</p> <p>2009 он гарсаар Unitel ХХК өөрийн үйл ажиллагааг сурталчилсан гэрэлтүүлэгтэй самбарыг холбогдох журмын дагуу байгуулсан бөгөөд хотын төв замын уулзварт байрлах 3 талт самбарыг буулгах шийдвэр гаргаад байна. Гудамж талбайд томоохон реклам самбар байрлуулсан 51 аж ахуйн нэгж байгаагаас 21 нь тогтоосон журмын дагуу төлбөрөө төлж байгаа бөгөөд зөрчилтэй байгууллагуудад төлбөрөө төлөх шаардлагыг Орон нутгийн өмчийн албанаас хүргүүлээд байна</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		<p>10. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны барилгуудын болон дээвэр, заадасын засвар үйлчилгээний чанарыг сайжруулахад хамтран ажиллах.</p>	<p>2009 онд орон нутгийн төсвөөс СӨХ-дод дэмжлэг үзүүлэх зорилгоор орон сууцны дээврийн засварт 100,0 сая төгрөгийг Аймгийн ИТХ-аар баталж 18 блокын засварыг хийх зураг төсвийг боловсруулж, 11 блокын дээврийг засварлаж ашиглалтанд орууллаа.</p> <p>Зарцуулсан хөрөнгийн 20,0 хувийг тухайн Сууц өмчлөгчдийн холбооноос графикайн дагуу төлж байна. Орон нутгийн хөрөнгийн тодотголоор 3 блокын хөрөнгө батлагдсан боловч цаг агаарын байдлаас шалтгаалан ажлыг зогсоож, 2010 оны хавар хийлгэхээр шийдвэрлээд байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>11. Сууц өмчлөгчдийн холбоодын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааг чанаржуулах.</p>	<p>Ажлаа хангалтгүй хийж буй СӨХ-н удирдах завлөлийн дарга нар болон гүйцэтгэх захирал нарт ажил сайжруулах талаар хугацаатай үүрэг өгч, Хүрэнбулаг багийн 5 СӨХ-ийн 2-г нь нэгтгэсэн, 2-СӨХ-г нэгтгэх шатандаа явж байна. Мөн хэт олон өрхтэй СӨХ буюу Тулгын-3 СӨХ-өөс 19-р байрыг Бадрал СӨХ-д нэгтгэсэн боловч захирлууд шүүхийн</p>

			<p>шийдвэр гарган цуцлуулж цаашид үргэлжлэх боломжгүй болоод байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		12. Орон сууцны хорооллуудад дээрээ тохижилт бүхий авто машины битүү зогсоолуудыг барьж байгуулах санал санаачлагыг дэмжих.	<p>Дээрээ тохижилт бүхий хүүхдийн тоглоомын талбайтай далд авто машины граж барих 5 байршлыг сонгож газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр эхний ээлжинд 1-р хорооллын 16-р байрны хойно, 6-р хорооллын 11-р байрны хойно барих шийдвэр гарч, төсөл сонгон шалгаруулалтаар Авзагатрейд ХХК болон “Ар Ти Эс” ХХК шалгарлаа. Газрын зөвшөөрлийг холбогдох газруудаас техникийн нөхцөл авч зураг төсвийг боловсрууллаа. Барилгын ажлыг 2010 оны хавар эхлэхээр төлөвлөөд байна.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
3.1.2.	Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн болон тодотгосон ерөнхий төлөвлөгөөнүүдийг боловсруулж, хэрэгжилтийг хангана.	1.Аймгийн сум болон багуудын хилийг нарийвчлан тогтоож, тодорхой болгох.	<p>Баян-Өндөр сумын 2009 оны 01 дүгээр сарын 23-ны ээлжит бус 3 дугаар хурлын 05 дугаар тогтоолоор сум, болон багуудын хилийн цэсийг тогтоож баталсан. Хилийн цэсийг тэмдэгжүүлэх ажлын талаар санал боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ирэх онд аймгийн хилийг тодотгон тэмдэгжүүлэхээр төлөвлөөд байна.</p> <p>Хэрэгжиж байна 70%</p>
		2.Баян-Өндөр сумын гэр хорооллын багууд, Баянцагаан баг, шинээр төлөвлөгдөж буй орон сууцны 8 ба 9-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах.	<p>Баян-Өндөр сумын гэр хорооллын ерөнхий төлөвлөгөөг “Ди энд Жийс” ХХК, Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Намуун ХХК тус тус гүйцэтгэж аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болголоо.</p> <p>Баянцагаан баг, шинээр төлөвлөгдөж буй орон сууцны 8 ба 9-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		3. Хот төлөвлөлтөнд иргэд, аж ахуйн нэгжиин оролцоог идэвхжүүлэх.	<p>Хот төлөвлөлт газар олголтын талаар иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн дагуу урьдчилан санал, дүгнэлт гарган хэлэлцэж байх зорилгоор хотын ус эрчим хүчний байгууллагууд, мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй техникийн зөвлөл байгуулан ажиллах,</p>

			техникийн нөхцлийг хамтран нэг газраас өгөх дүрэм журамд шилжээд байна. Хэрэгжиж байна 70%
		4. Хотын инженерийн шугам сүлжээний зураглалын тодотгол, хайгуулын зураглалыг хийх.	2009 онд хөрөнгө батлагдаагүй. Одоо байгаа орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээний тодотгосон зураглал, хайгуул хийлгэх хөрөнгө шийдэгдээгүй Тасарсан
		5. Хот байгуулалтын кадастр, бүртгэлийн нэгдсэн санг байгуулж, иргэдэд нээлттэй үнэн зөв мэдээллээр үйлчлэх.	Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр кадастр бүртгэл газрын нэгдсэн мэдээллийн сантай болох төслийн ажлыг Демимон Геокад зэрэг компаниудад 1700 га-д гүйцэтгэн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хүлээлгэн өглөө. Энэхүү мэдээллийн сангаар иргэдэд үйлчлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Хэрэгжиж байна 50%
		6. Аймгийн газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэл, бүсчилэл тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэх.	Нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэл бүсчлэл тогтоох ажлыг Улаанбаатар хотын Глобусс ХХК гүйцэтгэж, тайланг хүлээн авч байна. Хэрэгжиж байна 50%
3.1.3.	Инженерийн хангамж, дэд бүтцийг сайжруулан, найдвартай ажиллагааг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглана.	1. Хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, нэгдсэн аж ахуй байгуулах бодлого баримтлах.	Хотын нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, нэгдсэн аж ахуй байгуулах боломжийг судлан үндэслэл, санал боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, эхний ээлжинд 2010 оноос “Эрдэнэт-Ус” ДТСүлжээ ХК, “Эрдэнэт-Амьдрал” ХХК-г нэгтгэх, дараагийн ээлжинд хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, усны эх үүсвэрүүд, Эрдэнэт үйлдвэр ХХК-ны эрчим хүчний цехийг нэгтгэх ажлын хэсгийн санал дүгнэлтийг гарган аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, саналаа аймгийн ИТХ-д хүргүүлээд байна. Хэрэгжиж байна 50%
		2. Шаардлагатай гэр хорооллуудад эрчим хүчний шугам, дэд өртөө барих	2009 онд орон нутгийн төсвийн 60 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилтээр Их залуу багт шинээр буусан айл өрхүүдийг цахилгаанаар хангахад зориулж 63кв-гийн хүчин чадалтай дэд өртөө 1, 6кв-гийн агаарын шугам 0.9км, 0.4/0.22кв-н шугам 1.4км, Эрдэнэ багийн

			<p>шинэ Хабитатд 63кв-гийн хүчин чадалтай дэд өртөө 1, 6кв-гийн агаарын шугам 0.2км, 0.4/0.22кв-н шугам 6.5км-ийг тус тус ЭБЦТСүлжээ ХХК гүйцэтгэлээ.</p> <p>Мөн тус компани нь өөрийн 72.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянцагаан, Говил, Шанд, Их Залуу, Наран, Баянбулаг багт цахилгааны агаарын 0.4/0.22кв-н шугам 9км-г тус тус барьж, Шанд багт дэд өртөө 1-г өргөтгөж, шинээр буусан айл өрхийг цахилгаанжуулж, мөн хүчдэл хангалтгүй хэсгийн цахилгаан хангамжийн асуудлыг сайжрууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
		3. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээж авахдаа гадна инженерийн багууламжийн гүйцэтгэлийн зураглалыг тоон өгөгдлөөр хот байгуулалтын кадастрт хүлээн авах	<p>2009 онд Ачит, Төгөл, Сонорхайрхан Их мандал Молор-Эрдэнэ худалдааны төвүүд, “Дэлхийн Зөн” ОУБ-ын конторын барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж авахдаа инженерийн шугам сүлжээний зураглалыг гаргуулан файлаар авч кадастрын зурагт тусгаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 90%</p>
		4. ДЦС-ыг ПТ-30-3.4/10 маягийн турбин, генератораар өргөтгөх замаар хотын цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад тавьж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх	<p>Хотын ДЦСтанцыг ПТ-30-3,4 маркийн турбин генератороор өргөтгөх техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны ШУТЗөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн болно.</p> <p>2010 оноос хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөсөн.</p> <p style="text-align: right;">Хугацаа болоогүй</p>
		5. ДЦС-ын БКЗ-75-39 маркийн зуухны шаталтын технологийг 3 зууханд шинэчлэл хийх	<p>2009 онд Улсын төвлөрсөн төсвийн 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр ЭДЦСтанцын зуух 6, 7–д халах гадаргуу өрлөг дулаалгын эх засварын ажлыг гүйцэтгэлээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
		6. ДЦС-аас хотын төвийн “А” зангилаа хүртэл ф700 мм-ийн 3.5 км урт шугам барих	<p>ЭДЦСтанцаас хотын төвийн “А” зангилаа хүртэл ф700 мм-ийн 3.5 км урт шугам, өргөх насос станцын хамт барих зураг төслийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны зураг төслийн хэлтсээр хийлгэлээ.</p> <p>Хөтөлбөрт 2010 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p style="text-align: right;">Хугацаа болоогүй</p>

		7. Хотын цэвэр усны насос станцын ар талын дулааны “А” зангилаан дээр болон Говилын дулааны буцах шугам дээр өргөх насос станц барих	. ЭДЦСтанцаас хотын төвийн “А” зангилаан дээр барих өргөх насос станцыг барих зураг төслийг, Эрдэнэт үйлдвэр ХХК-ны зураг төслийн хэлтсээр хийлгэсэн. Хугацаа болоогүй
		8. Хотын дулааны шугам сүлжээнд техникийн аудит, технологийн горимын тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шинэчлэх ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэх	Хотын дулааны шугам сүлжээнд горимын тооцоо хийхэд 25 сая төгрөгийн хөрөнгө шаардлагатай боловч хөрөнгө батлагдаагүй. Хугацаа болоогүй
		9. Хотын дулаан дамжуулах төвүүдийн хурдны бойлерийг автомат тохируулга бүхий ялтсан бойлероор шинэчилж дуусгах	Хугацаа болоогүй
		10. Хотын цахилгааны дэд өртөө, кабель шугамд мэргэжлийн байгууллагаар техникийн аудит хийлгэж, шинэчлэх ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэх	Цахилгааны дэд өртөө, шугам шинэчлэх талаар Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гарсан. Хөтөлбөрт 2010 оноос хэрэгжихээр төлөвлөгдсөн болно. Хугацаа болоогүй
		11. Хотын орон сууцнуудын подвал, орц, төв болон давхар хоорондын сантехник, цахилгааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах	Хотын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд СӨХ-д орон сууцны байруудын подвалийн сантехникийн засварын төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн орон нутгийн төсвийн 26.7 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэт Амьдрал ХХК 5-14-р байрны подвалийн бохир усны шугамын шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 6-1-р байрны подвалд аж ахуйн нэгжийн 350 мянган төгрөгийн хөрөнгөөр бохир усны шугам дээр тос баригч суурилуулсан. Хэрэгжиж байна 70%
		12. Цахилгааны тоолуурт иргэд өөрсдөө хяналт тавих боломж, нөхцлийг бүрдүүлэх.	Эрчим хүчний хулгай буюу зүй бус алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны ерөнхий щитэнд тоолуурыг нэгтгэсэн. Цахилгааны байцаагчид сар бүр графикаар сууж хэрэглэгчид тоолуураа хянах боломжтой болсон. Хэрэгжиж байна 90%

		13. Цахилгаан эрчим хүчийг хэмнэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг хотын гэрэлтүүлэг болон ахуйн хэрэгцээнд ашиглах ажлыг зохион байгуулах.	2009 онд орон сууцны хорооллуудын доторхи гэрэлтүүлэг, хотын болон гэр хорооллын авто замын дагуух гэрэлтүүлэгт хэмжилт хийж стандартын нормыг хангаж байгаа эсэхийг тогтоон хэмнэлттэй эрчим хүч нэвтрүүлэх боломжийг судлан гэр хорооллын харанхуй гудамжнууд, авто замын дагуух гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүч ашиглах талаар ТИС-ын профессорын багтай хамтран судалгааны ажил хийгээд байна. Хэрэгжиж байна 10%
		14. Нийтийн эзэмшлийн явган хүний зам талбай, авто зогсоолын өргөтгөл, шинэчлэлтийг үргэлжлүүлэх.	2008 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууцны хорооллуудын доторхи автозамыг зогсоолыг 4167м ² өргөтгөх ажил эхэлснийг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. 2009 онд нийтийн зам талбайд хөрөнгө батлагдаагүй бөгөөд Худалдаа хөгжлийн банкны урд явган хүний замыг хийж, ашиглалтанд орууллаа. Хэрэгжиж байна 50%
3.1.4.	“Эрдэнэт зам” төсөл боловсруулан хэрэгжүүлж, хотын дотор болон захын хорооллуудад авто замын сүлжээг өргөжүүлнэ.	1. Улаанбаатар Хөвсгөлийн чиглэлийн транзит автозамын хотын дотуур дайран өнгөрч байгаа трассыг хот тойруулан барих асуудлыг холбогдох газарт тавих.	Хотын төвөөр дайрч байгаа Эрдэнэт-Булганы автозамын трассыг өөрчлөн хот тойруулан явуулах 2 хувилбарыг гарган ЗТБХБЯаманд албан тоотоор хүргүүлээд байна. Хэрэгжих шатандаа 10%
		2. Авто замын сүлжээг сайжруулж, хатуу хучилттай зам шинээр тавих, засварлах	2009 онд улсын төсвөөс хуваарилсан 1,0 тэрбум төгрөгт 3.55 км авто замыг барихаар тендерийг зарлаж “Очир төв” ХХК гэрээ байгуулан ажлыг хийж 1.4 км замд асфальт, 2.1 км замын даланг барьж улирлын байдлаас шалтгаалан ажлыг түр зогсоолоо. 2010 оны хавар замыг үргэлжлүүлэн барина. Хэрэгжиж байна 30%
		3. Гэр хорооллоор дайран өнгөрөх хотын чанартай автозамаас нарийн гудамж руу гарах гарцыг төлөвлөн гаргах.	Гэр хорооллоор дайран өнгөрөх хотын чанартай автозамаас нарийн гудамж руу орж гарах 12 гарцыг “Орхон АЗЗА” ХХК хийж гүйцэтгэж, ашиглалтанд оруулав. Хэрэгжиж байна 50%

		4. Жаргалант суманд авто замын гүүрэн байгууламжийг барьж, ашиглалтад оруулах.	Зураг төсвийг боловсруулах хөрөнгө батлагдаагүй тул хөрөнгийн эх үүсвэр судалж байна. Тасарсан.
		5. Замын хэвтээ болон босоо тэмдэгжүүлэлтийг сайжруулах, хурд сааруулагч тавих, орон сууцны хороолол доторхи авто замыг өргөтгөх, зогсоол байгуулах.	Хотын доторхи автозамын хэвтээ 21.3 км болон босоо тэмдэгжүүлэлтийг 68-г “Орхон АЗЗА” ХХК гүйцэтгэлээ. Өмнө онд дуусаагүй байсан 3.5-р хорооллын авто замын зогсоол өргөтгөлийн ажлыг үргэлжлүүлэн хийж дуусгасан. Биелсэн 100%
		6. Хот доторхи болон хорооллын замын гэрэлтүүлэг, дохиоллын системийг нэмэгдүүлэх.	Хотын доторхи болон гэр хорооллын одоо байгаа гэрэлтүүлгийг сэргээн засварлах ажлыг ХТГазар тухай бүр хийж байна. 2009 онд шинээр барьсан 3 дугаар хорооллоос баруун урагшаа төв зам, нийгмийн даатгалын хэлтсийн баруун, хойд талын шинээр тавигдсан авто замын дагуух гэрэлтүүлгийг шинээр хийлээ. Мөн Сүхбаатарын өргөн чөлөөний гэрэлтүүлгийг бүрэн шинэчлэв. Хэрэгжиж байна 70%
		7. Авто замыг төлөвлөхдөө зураг төслийн үеэс эхлэн дугуйн болон явган зам, замын гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээ, гарцыг давхар шийдвэрлэх	2009 онд шинээр барьсан 3 дугаар хорооллоос баруун урагшаа төв замтай холбогдох 320 м, нийгмийн даатгалын хэлтсийн баруун, хойд талд баригдах 160 м хатуу хучилттай замуудын тэмдэг, тэмдэглэгээ зурагт бүрэн тусгагдаж хийгдсэн ба Дэнж, Эрдэнэ багийн 3,5 км авто замын дагуух гэрэлтүүлэг зураг төсөвт тусгагдсан. Хэрэгжиж байна 50%
3.1.5.	Усны ойрын эх үүсвэрийг ашиглах, ус түгээх цэг, гүний худгийн тоог жил бүр нэмэгдүүлэх замаар усны хангамжийг сайжруулна.	1. Хайгуулаар тогтоогдсон цэвэр усны нөөцийг ашиглах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	Чингэлийн голын дагуу хайгуулаар тогтоогдсон цэвэр усны нөөцийг ашиглан Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслөөр гэр хороололд цэвэр усны шугам барих, ус түгээх цэгүүдийг холбох зураг төслийг “Престиж инженеринг” ХХК шалгарч гүйцэтгээд байна. Уг ажил 2010 онд хэрэгжиж эхлэнэ. Хэрэгжиж байна 50%
		2. Жаргалант сумын усан санг сэргээж, гэр хороолол болон Жаргалант суманд шинээр ус түгээх цэг, гүний худаг барьж,	Баянцагаан, Говил багт ус түгээх цэгийн барилга, Жаргалант суманд гүний худгийн хамгаалалтын бүсийн хашааг Дэлхийн зөн олон улсын байгууллагын

		зарим ус түгээх цэгийн байрыг шинэчлэн усны савыг солих	хөрөнгөөр гүйцэтгээд байна. Хэрэгжиж байна 70%
		3. Нийтийн аж ахуйг хөгжүүлэх Ш шатны төслийн хүрээнд Орхон аймгийн гэр хорооллын усан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлж дуусгах	Чингэлийн голын дагуу хайгуулаар тогтоогдсон цэвэр усны нөөцийг ашиглан Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслөөр гэр хороололд цэвэр усны шугам барих, ус түгээх цэгүүдийг холбох зураг төслийг “Престиж инженеринг” ХХК шалгарч гүйцэтгээд байна. “Гэр хороололд барихаар төлөвлөж буй, цэвэр, бохир усны шугамын маршрут, ус түгээх цэгийн байршлын схемийг гаргаж батлан, маршруттай давхцсан айл өрхийн судалгааг гаргалаа. Хэрэгжиж байна 50%
		4. Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг дэвсгэр дэх усан санг дотоодын цэргийн болон бусад харуул хамгаалалттай болгох	“Эрдэнэт-Ус” ДТСүлжээ ХК-ны харьяа Баян-Өндөр сумын Дэнж баг, Жаргалант сумын гүний худгийг цэрэгжсэн харуул тавих хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй. Хэрэгжих шатандаа 10%
		5. Гүний худгуудын нөөцийн үнэлгээг хийх	“Эрдэнэт-үйлдвэр” ХХК-ийн эрчим хүчний цехийн харьяа Сэлэнгэ мөрний хөвөөн дээр байрлаж буй 14 гүний худгийн нөөцийг шинэчлэн тогтоолоо. Эрдэнэт-Ус ДТСүлжээ ХК-ийн харьяа гүний худгуудын нөөцийг шинэчлэн тогтоогоогүй байна. Хэрэгжиж байна 50%
		6. Ус тээвэрлэх автомашины паркыг шинэчлэх	Хөрөнгийн эх үүсвэргүй. Тасарсан.
		7. Гэр хорооллын багуудын нутаг дэвсгэрт гүний худгуудыг шинээр нэмж гарган шугам хоолойгоор холбон усны эх үүсвэрийг айл өрхүүд хашаандаа татан оруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих гэр хорооллын усан хангамжийг сайжруулах МОН2301 төслийн дараагийн шатанд гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамтай холбох боломжтой. Хэрэгжих шатандаа 30%
3.1.6.	Хотын цэвэр усны шугам сүлжээнд шинэчлэлт хийх хэмнэлттэй, дэвшилтэй техник технологи	1. Шугам сүлжээний шинэчлэлтийг үргэлжлүүлж, металл бус зэвэрдэггүй, цахилгаанждаггүй хоолойгоор барих	2009 онд орон сууцны 5-1-р байрны өмнө талын цэвэр усны 100м шугам, Дэнж багийн цэвэр усны 70 м урт шугам, Говилын 100 айлын 3 байр, 2 орон сууц, халуун усны барилгын гадна дулаан цэвэр усны 217 м

нэвтрүүлж усны алдагдлыг багасгана.		урт шугам, хонхорын 9 байрны дулаан цэвэр усны 320 м урт шугам, 3-24-р байрны өмнө талын цэвэр усны шугам, 2-11-р байрны гадна цэвэр усны шугам, хивсний үйлдвэрийн өмнө талын цэвэр усны шугам, албан бус боловсрол төвийн гадна цэвэр бохир усны шугам, 10-р бага сургуулийн подвэлийн цэвэр бохир усны шугам, 5-14-р байрны подвэлийн бохир усны шугам нийт 1.2 км шугамыг засварлан шинэчилж хотын дулаан цэвэр бохир усны 231 бетон таг хийхэд орон нутгийн төсвөөс 111.3 сая төгрөг зарцуулаад байна Хэрэгжиж байна 90%	
	2. Хотын насосны станцын насосыг шинэчилж, шинээр баригдсан Ф400 мм-ийн шугамд холбох	2009 онд хотын насосны станцын Д 320/70 маркийн насосыг Хятад улсад үйлдвэрлэсэн TPOW 500/90 маркийн насосоор шинэчиллээ. Биелсэн 100%	
	3. Хотын насос станцаас 2х2000 м3 багтаамжтай усан сан хүртэлх шинээр барьж буй цэвэр усны шугамыг дуусгаж, усан санг засварлаж ашиглалтад оруулах	2008 онд “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн хөрөнгөөр “Төмөрхүлэг” ХХК 2х2000м ³ багтаамжтай усан сангаас ф300 мм-ийн 1,3 км шугам барьсан. Цааш үргэлжлүүлэн хотын насосны станц хүртэл ф 300 мм-ийн 494м, 2х500 мм-ийн 105 м шугам барих шаардлагатай. Хэрэгжиж байна 70%	
	4. Орон сууцны айл өрх аж ахуйн нэгж, байгууллагуудыг тоолууржуулж дуусгах	Орон сууцны айл, өрхийн 93 хувийг тоолууржуулаад байна. Хэрэгжиж байна 90%	
	5. Ус, цахилгааны хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулах лабораторийг байгуулах.	Одоо баригдаж байгаа “Эрдэнэт-Амьдрал” ХХК-ийн захиргааны барилгад ус, цахилгааны хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулах лаборатори тусгагдсан. Эрдэнэт-Ус ДТСүлжээ ХК-ны усны тоолуур шалгаж, баталгаажуулах лаборатори байгуулахаар “АБУ” трейд ХХК-тай гэрээ байгуулан, тоног төхөөрөмжийг угсарч дуусгалаа. Хэрэгжиж байна 70%	
	6. Шугам сүлжээг засварлах болон шинэчлэхэд шаардагдах машин механизмын паркыг шинэчлэх	“Эрдэнэт-Амьдрал” ХХК компани хүнд даацын автокран, Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хөрөнгөөр 5 тн даацтай 6 м урт тэвштэй, 8 м сунадаг 3 тн өргөдөг авто кранаар хангагдлаа. Хэрэгжиж байна 90%	
3.1.7.	Эрдэнэт хот, Жаргалант	1. Эрдэнэт хотын цэвэрлэх	Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн

	сумын байгууламжийг шинэчлэх шийдвэрлэнэ. цэвэрлэх өргөтгөн, асуудлыг	байгууламжийн өргөтгөлийн барилгыг барьж дуусгах	өргөтгөлийн барилгын техник, тоног төхөөрөмжийг Франц улсын хөнгөлөлттэй зээлээр шинэчлэхээр тус улсын Дегремонд ХХК, Монголын талтай 2009 оны 6-р сард гэрээнд гарын үсэг зурж хотын цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэхэд техник туслалцаа үзүүлэх талаар Орхон аймгийн, Франц улсын "EGIS BCEOM", компанийн хооронд 2007 онд байгуулсан гэрээний дагуу тус компанийн мэргэжилтнүүд 2009 оны 9 сард ирж ажилласан. Ажиллах хугацаандаа аймгийн ЗДТГазар мэргэжлийн байгууллагуудтай хамтран холбогдох мэдээллүүдийг гаргуулан авч цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ажлыг гүйцэтгэхэд техникийн туслалцаа үзүүлэх ажлын тайланг гаргалаа. 2009 онд Эрдэнэт үйлдвэр ХХК-аас 500 мян.долларын хөрөнгийг шийдвэрлэсэн одоогийн байдлаар өргөтгөлийн барилгын зураг төсвийг "Эрдэнэт Үйлдвэр" ХХК-ны зураг төслийн хэлтэс хийж байгаа бөгөөд 2010 оны 3-р сараас барилгын ажил эхлэнэ. Хэрэгжиж байна 70%
		2. Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн, шинэчлэлт хийх	Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийн гүний худгийг засварлаж ажилд оруулан лагийг цэвэрлэж, барилга, цахилгааны урсгал засвар хийлээ. Хэрэгжиж байна 70%
		3. "Гэр хорооллын нөхцөл сайжруулах төсөл"-ийн хүрээнд ариутгах татуургын хөрөнгийг шийдвэрлэж зохион байгуулах.	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Мон-2301 төслийн хүрээнд Шанд багийн 17 дугаар сургууль Наран багийн 3-р сургуулийн бохир усны шугамыг хотын төвлөрсөн шугамд холбохоор тусгагдсан. Хэрэгжих шатандаа 30%
3.1.8.	Хотын инженерийн байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг оновчтой болгох асуудлыг шийдвэрлэнэ.	1. Орон сууцны 4,5-р хорооллын 9 давхар байруудын цахилгаан шатыг орчин үеийн шинэ техник технологиор шинэчлэх	2009 оны 1-р сард "Монголын цахилгаан шат" ХХК 4-14-ын "Б" 26,27, 5-3-р байранд цахилгаан шатыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэчилсэн. Биелсэн 100%
		2. Хотын үерийн болон борооны ус зайлуулах ил далд шугам сүлжээ, худагт засвар үйлчилгээ хийх, үерийн даланг үргэлжлүүлэн барих хөрөнгийн асуудлыг	Борооны усны худаг, решоктийг цэвэрлэж, засварлахаар хотын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусган, харьяа байгууллагууд засвар үйлчилгээг хийв. Хотын дулаан цэвэр бохир ус, үерийн

		жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх.	усны 231 бетон тагийг орон нутгийн төсвийн 5.2 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ. Гэр хорооллын гол авто замаас 12 гарц доогуур үерийн ус зайлуулах шугам тавьлаа. Хэрэгжиж байна 90%
		3. Хотын автозамын дагуух гэрэлтүүлгийн шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж дуусгах.	Сүхбаатарын өргөн чөлөөний авто замын гэрэлтүүлгийг шинэчлэх зураг, төсвийг боловсруулж, тендер зарлаж Оркон тех ХХК шалгарч хийж гүйцэтгэлээ. Мөн 3 дугаар хорооллоос баруун урагшаа төв замтай холбогдох 320 м, нийгмийн даатгалын хэлтсийн баруун, хойд зүүн талд 160 м хатуу хучилттай замуудын гэрэлтүүлгийг гүйцэтгэлээ. Хэрэгжиж байна 50%
3.1.9.	Шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудын инженерийн хангамж, дэд бүтцийг шийдвэрлэнэ.	1. Хотын 35/6 кв-ын өмнөд дэд станцаас орон сууцны 7,7а хороололд 630 ква-ын хүчин чадалтай 2 дэд өртөө, кабель шугам барих ажлын зураг төсвийг боловсруулж хөрөнгийн эх үүсвэр хайж үе шаттайгаар барих.	Аймгийн Засаг даргын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 138 дугаар захирамжаар батлагдсан 2009-2012 онд хотын инженерийн шугам сүлжээнд шинэчлэлт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна. Хэрэгжих шатандаа 10%
		2. 11-р хорооллын “В” хэсэгт баригдсан 2х630 ква-ын дэд өртөөний тэжээлийн кабель шугам татаж, ДДТөвийн тоног төхөөрөмжийг тавьж цэвэр бохир усны шугам барих ажлын зураг төсвийг боловсруулж үе шаттайгаар барих.	11 дүгээр хорооллын “В” хэсгийн ажлын зураг хийгдсэн. Инженерийн шугам сүлжээ барих хөрөнгө энэ онд батлагдаагүй болно. Хэрэгжиж байна 10%
		3. 11-р хорооллын баруун хойд талын “Зээлийн толгой”-д 2х2500 м3 багтаамжтай усан санг цэвэр усны шугамын хамт барих ажлын зураг төсвийг боловсруулж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, үе шаттайгаар барих.	Зургийн даалгаврыг боловсруулж, зураг төслийн байгууллагад хүргүүлсэн боловч асуудал шийдвэрлэгдээгүй байна. Хэрэгжих шатандаа 10%
		4. 7-р хорооллын зүүн хойд талд дулааны өргөх насос станц барих ажлын зураг төсвийг боловсруулж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, үе шаттайгаар	Хөрөнгийн эх үүсвэргүй. Тасарсан.

		барих. 5. 5-р хорооллын баруун талаас гэр хороолол руу явсан дулаан, цэвэр усны шугамыг өргөтгөж газар дор сувагт оруулах.	Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан боловч хөрөнгийн эх үүсвэр байхгүй байна. Хэрэгжих шатандаа 10%
		6. 1а, 2а, 7, 7а, 10,11-р хорооллуудад инженерийн шугам сүлжээ барих ажлын зураг төсвийг боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэн, барих.	Шинээр баригдах хорооллуудын ажлын болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан боловч, инженерийн шугам сүлжээ барих хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Хэрэгжих шатандаа 10%
3.1.10.	Усны бохирдолтыг багасгаж, хүн амыг ахуйн чанар стандартад нийцсэн усаар хангана.	1. Одоо байгаа болон шинээр баригдсан усан сангийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг шинэчлэх ажлыг зохион байгуулах.	Эрдэнэт-Ус ДТС ХК өөрийн харъяа гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг сэргээн засварлах ажил хийж Жаргалант сумын 3 гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг Дэлхийн зөн ОУБ-ын хөрөнгөөр барьсан Биелсэн 100%
		2. Цэвэр, бохир усны чанарын судалгааны лабораторийг өргөтгөж, орчин үеийн өндөр хүчин чадалтай шинжилгээний нарийвчилсан багаж, тоног төхөөрөмжөөр хангах.	Цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн бүрэлдэхүүнд оруулахаар төлөвлөсөн. Хугацаа болоогүй.
		3. Хотын ундны усыг фторжуулах арга хэмжээ авах.	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-аас хотын ундны усыг фторжуулах төслийг боловсруулсан боловч хөрөнгө шийдэгдээгүй байна. Хэрэгжих шатандаа 10%
		4. Шинэ Хабитат хорооллын цэвэр усны хангамж, ариутгах татуургын сүлжээг шийдвэрлэх.	Зураг, төсөл боловсруулагдсан боловч батлагдаагүй байна. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй. Хэрэгжих шатандаа 10%
3.1.11.	Инженерийн шугам сүлжээний ашиглалт, хамгаалалтанд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлнэ.	1. Гадаргын болон гүний усны эх үүсвэр, өргөх станц, усан сангийн барилга байгууламж, хамгаалалт, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний ашиглалтын байдалд үзлэг шалгалт явуулах.	Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газраас улирал тутам усны шинжилгээ авч үзлэг шалгалт явуулж байна. Нэгдсэн шалгалтыг хагас бүтэн жилээр явуулна. Хэрэгжиж байна 70%
		2. Ус ашиглах болон инженерийн шугам сүлжээний ашиглалттай холбоотой	Үзлэг шалгалтаар ноцтой зөрчил илрээгүй байна.

		аливаа зөрчлийг илрүүлж, таслан зогсоож, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх.	Биелсэн 100%
3.1.12.	Аймгийн орон сууцны санг 20-оос доошгүй хувиар буюу 2000-аар нэмэгдүүлнэ.	1. Орон сууцны 1 ^А , 2 ^А , 7, 7 ^А , 8, 10, 11-р хорооллуудыг барилгажуулан, Говил, Баянцагаан багууд, Жаргалант суманд орон сууцны байруудыг шинээр барих.	11-р хороололд “ОРДУ” ХХК 12 айлын амины орон сууцны барилга барьж байна. Баянцагаан багт “Талст-Өргөө” компани багш нарын 192 айлын орон сууц барихаар 0,6 га газар авч ажлаа эхэллээ. Говил багт “Инаросс” ХХК орон сууцны 5,9 давхар барилга барихаар 4 га газар авч бэлтгэл ажил хийж байна. Стройинвест ХХК-ны барьж буй 12 давхар 390 айлын орон сууцны угсралт өрлөгийн ажил 80 хувьтай байна. Хэрэгжиж байна 30%
		2. Тодотгосон Ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын барилгажсан хэсгийг нягтаршуулах.	1-6-р хорооллын тодотгол ерөнхий төлөвлөгөөг Засаг даргын зөвлөлийн хурлаар дахин хэлэлцэх болсон тул төлөвлөгөөний дагуу газар олголт, барилгажилтын ажил явагдаагүй байна. Хэрэгжих шатандаа 10%
		3. Иргэдийн оролцоотой хувийн орон сууц барих ажлыг дэмжих (гэрийн хороолол, Говил баг, Баянцагаан баг, Жаргалант сум)	Амины орон сууц барихаар ирүүлсэн иргэдийн саналыг дэмжин ажиллаж байна. Говил багийн 3 байрны 30 иргэн байрныхаа дэргэдэх суурин дээр амины орон сууц барих 2 иргэн хуучин суурин дээр амины орон сууц жижиг үйлдвэр үйлчилгээний зориулалтаар барилга барих хүсэлтийг судлаж байна. Хэрэгжиж байна 30%
		4. Гэр хорооллыг оршин суугчдын оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллах	Гэр хорооллын иргэдийн оролцоотой хөгжүүлэх төсөл болон Хабитат хорооллыг инженерийн шугам сүлжээтэй жишиг хороолол болгох төслийг дэмжин ажиллаж байна. Хэрэгжиж байна 30%
		5. Орон сууцны хорооллуудад “Мансарт” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	Мэргэжлийн хяналтын газраас уг төслийг хэрэгжүүлэхийг түр зогсоогоод байна. Хэрэгжих шатандаа 10%
		6. Говил багийн нутаг дэвсгэрт байрлах хуучин барилгын сууриудыг ашиглан барилгын хөнгөн хийцийн материалаар	Говил багийн 3 байрны 30 иргэн байрныхаа дэргэдэх суурин дээр амины орон сууц барих, 2 иргэн хуучин суурин дээр амины орон сууц жижиг үйлдвэр

		орон сууц барих асуудлыг шийдвэрлэх.	үйлчилгээний зориулалтаар барилга барих хүсэлт гаргаад байна. Хэрэгжиж байна 30%
3.1.13.	Барилга байгууламжийн чанарыг дээшлүүлэн, ашиглалтыг сайжруулна.	1. Барилга байгууламжийн тооллого хийж, бүрэн паспортжуулах.	Орон нутгийн өмчит 83 байгууллагын тооллого дахин үнэлгээг сангийн яамнаас ирүүлсэн үлгэрчилсэн зааврын дагуу бүрэн хийж дууслаа. Цаашид орон сууц, хувийн хэвшлийн барилгын хувийн хэрэг хөтлөлтийг хэрэгжүүлэх шинэчилсэн байдлаар хэрэгжүүлэхэд аймгийн комисс ажиллуулж байна. Хэрэгжиж байна 50%
		2. Орон нутгийн зүгээс барилга угсралтын ажлын чанарт хөрөнгийн эх үүсвэр үл харгалзан хяналт тавьж ажиллах	Улсын болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу замын ажил, орон нутгийн төсөв, авто замын сангаас санхүүжигдэх ажлууд, нийтдээ 6 тендерийн үнэлгээний хороо байгуулагдан тендерийн бичиг баримтыг боловсруулан сангийн яамны web сайд, улс орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж, нээлттэй ил тод хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулсан. “Стройинвест” ХХК өөрийн хөрөнгө оруулалтаар барьж байгаа орон сууцны барилгын чанарт МХГ-ын Барилгын улсын байцаагч хяналт тавьж үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоогоод байна. Хэрэгжиж байна 50%
3.1.14.	Хог хаягдлын менежмент төсөл хэрэгжүүлнэ.	1. Хог хаягдлын нэгдсэн цэгийг боловсронгуй болгож, байгаль экологид хор нөлөөгүй ашиглах	Одоо байгаа хог хаягдлын газарт хамгаалалтын зурвас бий болгох зорилгоор шуудуу ухаж, хилийн зааг тогтоож, заагийг тойруулан 230 хайлаас тарьж, 750 м газрыг өргөст торон хашаа хийж хамгаалсан. Хэрэгжиж байна 50%
		2. Хог хаягдлын менежментийг сайжруулж дахин ашиглах боломжтой хаягдал түүхий эдийг боловсруулах жижиг үйлдвэрлэлийг бий болгох, түүхий эдийг худалдан авах нөхцлийг бүрдүүлэх	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох хөтөлбөр батлуулахаар ажиллаж байна. Хог хаягдлыг ялгаж, хоёрдогч түүхий эд болгон ангилж Жаргалант сумын “Поли этилин” ХХК-д нийлүүлэхээр гэрээ хийн ажиллаж байна. Хэрэгжиж байна 70%
		3. Орон сууцны хороолол доторхи хог хаягдал төвлөрүүлэх цэгүүдийг	Эрдэнэт хотын хэмжээнд хог хаягдлын ил задгай түр цэг 41 ширхэг байдгаас 2009 онд 3 дугаар бичил

		боловсронгуй болгох	хорооллын 22, 9, 12, 23, 24, ДГТ-3 дугаар байруудад хог хаягдлын түр цэг 10 ширхэгийг шинээр тавьж багтаамжийг нь сайжруулж шинэчилсэн. Мөн 4 дүгээр бичил хорооллын 5 дугаар байр, 5 дугаар бичил хорооллын 1, 17 дугаар байрууд, 3 дугаар бичил хорооллын 9, 19, 20, 22 дугаар байруудын 9 ширхэг хог хаягдлын түр цэгийн орчны тохижилт хийж 344,000 төгрөг зарцуулсан. 2009 онд хог хаягдлын түр цэгийн засварт 369,000 төгрөг зарцуулсан бөгөөд хог хаягдлын түр цэгийг засварлаж, тохижуулахад нийт 887,000 төгрөг зарцуулсан. Хэрэгжиж байна 70%
		4. Хот тохижуулах газрын хог тээвэрлэх автомашины парк шинэчлэл хийх.	2009 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны хөрөнгө оруулалтаар ажилчид зөөх автобус 1, Бульдозер 1-ийг авч парк шинэчлэлт хийсэн. Цаашид цэвэрлэгээний зориулалттай тусгай тоноглолтой автомашин 2, хаягдал тээвэрлэх зориулалтын төхөөрөмжтэй автомашин 8, гэр хорооллын болон эзэнгүй дүүргийн хог хаягдал тээвэрлэх хүнд даацын автомашин 8, хог хаягдлын төвлөрсөн цэгт хаягдал түрж дарах зориулалттай бульдозер 1, усны тэрэг 1, универсаль трактор 1-ийг шинээр авч паркаа шинэчлэхээр МОН 2301 төсөлд асуудал тавиад байна. Хэрэгжиж байна 90%

Дөрөв: Төрийн захиргаа, хяналт зохицуулалт

Төрийн байгууллага, албан хаагчдын ил тод, нээлттэй шуурхай, шударга, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажил хэрэгч байдлыг хангаж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэнэ.

1. Төрийн захиргааны удирдлагын бодлого

4.1.1.	Ерөнхий менежер болон	1. Төсвийн байгууллагын	Ерөнхий	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн
--------	-----------------------	-------------------------	---------	--

	<p>төрийн жинхэнэ албаны бусад удирдах албан тушаалд томилогдсон төрийн албан хаагчдын манлайлах ур чадварыг хөгжүүлнэ.</p>	<p>менежер, төрийн жинхэнэ албаны бусад удирдах албан тушаалтныг “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж Төрийн байгууллагуудыг суралцагч байгууллага болгон хөгжүүлэх</p>	<p>төрийн захиргааны олон улсын институт /SIPU internal/-тай хамтран хэрэгжүүлж буй “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд тус аймагт 5 удаагийн 3 үе шат бүхий үндсэн сургалт зохион байгуулагдан 100 төсвийн ерөнхий менежер манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамрагдлаа. Энэхүү төслийн хүрээнд манлайллын мастер сургагчаар 2 төрийн албан хаагчийг бэлтгэн орон нутагт манлайллын сургалтыг зохион байгуулж байна. Манлайллын сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Ёс зүйт манлайлал” сургалтад 20 ерөнхий менежер, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран зохион байгуулсан “Үйлчилдэг удирдлага” сэдэвт сургалтад 35 ерөнхий менежерүүд тус тус хамрагдлаа. Хэрэгжиж байна 70%</p>
		<p>2. Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусгасан манлайлах ур чадвар болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтыг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох</p>	<p>Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний өмчлөгчийн зорилт болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах талаар аймаг дахь ТАЗ-ийн салбар зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг үндэслэн Ерөнхий менежерүүдийн Үр дүнгийн гэрээнд манлайллын болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтод шалгуур үзүүлэлтийг тогтоож, аймгийн Засаг даргын захирамжаар батлан мөрдөж байна. Манлайлах ур чадвар болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тодорхой тусгуулах арга хэмжээ авч, гүйцэтгэлд нь Хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг хяналт тавин ажиллаж байна. Биелсэн 100%</p>
<p>4.1.2.</p>	<p>Хүний нөөцийн удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p>1. Аймгийн ЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх</p> <p>2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн сан бүрдүүлэх</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 76 тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. Хэрэгжиж байна 90%</p> <p>Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн систем /HRMIS/-ийн шинэчилсэн программ хангамжийн дагуу</p>

			<p>2008 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг Онлайн хэлбэрээр нэгтгэн гаргалаа. “Орхон аймгийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн сан”-д 65 төрийн байгууллагын 3085 төрийн албан хаагчийн мэдээлэл хамрагдлаа.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>3.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.</p>	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд багуудын Засаг дарга нар болон төрийн бүх байгууллагууд ажлын байраар хангагдсан ба төрийн албан хаагчдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, биеийн тамирын сорилд хамруулан Төрийн албан хаагчдын Чийрэгжүүлэлтийн болон Алжаал тайлах танхимаар графикайн дагуу үйлчилж эрүүлжүүлэх арга хэмжээг системтэйгээр авч хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэгийн сангаас 41 албан хаагчдад 202.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Боловсрол, эрүүл мэндийн нийгмийн дэмжлэгийн сангаас 21 албан хаагчдад 4.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, 240 албан хаагчдад 7,3 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олголоо.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Төрийн албан хаагчдыг орон сууц хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Төрийн албан хаагчийг орон сууцжуулах, орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Орон сууцны сан” байгуулан 41 албан хаагчид 202.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
4.1.3.	<p>Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, хууль дээдлэх, авилгыг үл тэвчих ухамсар, соёлыг хэвшүүлж, ажиллах нөхцөл, баталгааг</p>	<p>1.Төрийн албан хаагчийн ёс зүй, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл зэрэг төрийн төв байгууллагуудтай хамтран “Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Өнөөдрийн хүнд суртал маргаашийн авлигын үндэс”, “Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөлт хийх”, “Төрийн захиргааны байгууллага ба төрийн албаны хаагчийн ашиг сонирхолын зөрчил”, “Авлига, ашиг</p>

	хангана.		сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчийн үүрэг”, ”Авлигын тодорхойлолт, үнэлгээ, авлигатай тэмцэх бодлогын хандлагууд”, ”Төрийн захиргааны байгууллага дахь авлигын хэлбэрүүд, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам”, ”Төрийн байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангахад анхаарах асуудлууд”, ”Төрийн албан хаагчийн ёс зүйн соёл, манлайлал” зэрэг сэдвүүдээр 21 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 600 гаруй төрийн албан хаагчийг хамрууллаа. Хэрэгжиж байна 90%
		2. Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, хянах	Аймгийн Засаг даргын Тамгын газарт 249 төрийн албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд бүртгүүлсэн ба тайлан мэдээг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлээ. Хэрэгжиж байна 90%
4.1.4.	Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдэх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг боловсронгуй болгож, дүн шинжилгээний чадавхи, үр нөлөөг дээшлүүлнэ.	1. Төр засгийн болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж, олон нийт болон дээд шатны байгууллагад мэдээлж, тайлагнаж байх.	Төр засгийн болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг сайжруулах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран 2 өдрийн сургалтыг өөрийн аймагт зохион байгууллаа. 2009 онд төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргаас газрын харилцааны чиглэлээр гарсан захирамжууд, Санхүү, эдийн засгийн хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн ажлын явц зэрэг баримт бичгүүдэд ХШҮ хийлээ. Хэрэгжиж байна 90%
		2. Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад, сумдын Засаг дарга нарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн, жил бүр харъяа агентлаг, сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааг дүгнэж байх.	Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад, сумдын Засаг дарга нарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 386 дугаар захирамжаар баталлаа. Аймгийн ЗДТГ-ын газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийг

			байгуулан ажиллаж байна. Биелсэн 100%
4.1.5.	Багийн хөгжлийг дэмжих замаар төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцлийг бий болгоно.	1. “Сум, багийн хөгжлийн сан” байгуулах асуудлыг шийдвэрлэх.	“Багийн хөгжлийн сан”-г байгуулж 2008 онд 22 баг тус бүрт 1.0 сая төгрөг зарцуулсан. Уг сангийн зарцуулалтанд хагас, бүтэн жилд шалгалт хийж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан ба 2009 онд 500.0 мянган төгрөгийг сангийн чиглэлээр төсөвт тусган ажиллаж байна. Хэрэгжиж байна 50%
		2. “Нийгмийн хөгжилд иргэдийн оролцоо” хөтөлбөр, боловсруулж хэрэгжүүлэх.	“Орон нутгийн хөгжилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо” хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэн баталлаа. Хөтөлбөрийг 2010-2013 онд хэрэгжүүлэх ба хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Хэрэгжиж байна 90%
		3. Засаг захиргааны анхан шатны нэгж багуудын ажиллах нөхцлийг сайжруулж, Хүрэнбулаг, Жаргалант багуудыг ажлын байртай болгох асуудлыг шийдвэрлэх	2008 онд Жаргалант сумын Цагдаагийн хэсгийн кабоны байранд Дулаан-Уул багийн ажлын байрыг шилжүүлж, Жаргалант багийг ажлын байртай болгосон ба аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2009 оны 14 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын шийдвэрээр Захиргааны II байранд үйл ажиллагаа явуулж байсан төрийн байгууллагуудыг Оюут багийн нутаг дэвсгэрт захиргааны II байранд шилжүүлэн байршуулсантай холбогдуулж Хүрэнбулаг багийг ажлын байраар түр хангаж, ажиллах нөхцлийг сайжруулах арга хэмжээг авлаа. Цаашид Хүрэнбулаг багт өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсэг, багийн нэгдсэн байртай болгох шаардлага байгаа болно. Хэрэгжиж байна 50%
		4. Баг тус бүрт орон тооны нийгмийн ажилтныг ажиллуулах асуудлыг шийдвэрлэх	Багт нийгмийн ажилтан ажиллуулах асуудал шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд уг асуудлаар холбогдох тооцоо, судалгааг хийж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

			Хэрэгжиж байна 10%
		5. Багуудын боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, багт ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн зайны сургалтын төвийг түшиглэн багийн Засаг дарга, зохион байгуулагчдыг богино хугацааны болон давтан сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах	Удирдлагын академийн зайны сургалтын төвийг түшиглэн Германы техник хамтын ажиллагааны Нийгэмлэгийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын Эрдэнэт Хөгжлийн хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран 22 багийн Засаг дарга, зохион байгуулагчдад төрийн удирдлагын болон хууль эрх зүйн чиглэлээр “Хүний нөөцийн хөгжил, манлайлал”, “Төрийн удирдлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Үйлчилдэг удирдлага” ,”Орон нутгийг хөгжүүлэхэд иргэдийн оролцоо”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Архив, албан хэрэг хөтлөлт”, “Захиргааны эрх зүй” зэрэг сургалтуудыг зохион байгууллаа. Биелсэн 100%
4.1.6.	Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.	1. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг жил бүр зохион байгуулан, гэрээг дүгнэн, хяналт тавих.	Аймгийн ЗДТГ болон аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг Тэргүүн шадар сайдын ажлын алба, Монголын ХЭАХН, Стандартчилал хэмжилзүйн газар, Оюуны өмчийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран 2009 онд “Шударга өрсөлдөөн ба хэрэглэгчийн эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтанд Дархан-Уул, Булган, Архангай, Сэлэнгэ аймгуудын төлөөлөгчид оролцлоо. Аймгийн хэмжээнд хууль дүрэм сахиулах, тогтоол шийдвэр, захирамжуудын биелэлт, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал , ариутгал халдваргүйжүүлэлт болон стандарт нормыг хангуулах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс ХЭАХН болон Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэгийн аймгийн салбар зөвлөл болон аймгийн ЗДТГ, холбогдох газар, албадууд хамтран байнгын эргүүл, шалгалтыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг дарга болон аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо хамтарсан 3 талт хэлэлцээрийг жил бүр байгуулан үр дүн , хэрэгжилтийг дүгнэж байна. “Уртын дууны нийгэмлэг”, “Бие биелэг холбоо” ТББ-уудтай хамтран 90 орчим бие даан суралцагчдыг ардын

			<p>урлагийн чиглэлээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. “Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг” ТББ-тай хамтран “Ирээдүй төв” эмнэлэг дээр хамтран өсвөр үеийн нөхөн үржихүйн чиглэлээр 3 цогцолбор сургуулийн ахлах ангийн 3749 охид, хөвгүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сургалт зохион байгуулав. “Тус дэм” ТББ-тай хамтран эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гарган “Бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт”-ыг давхардсан тоогоор 165 хүнд явуулж, эдгээр иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авлаа. Аймгийн ЗДТГ болон ХАҮТ хамтран “Эрдэнэт түншлэл-2009” ба “Хангайн бүсийн түншлэл-2009” үзэсгэлэн яармагуудыг 2009 оны 6-р сарын 27-28, 10-р сарын 23-24-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Уг үзэсгэлэн яармагт манай аймгийн ААН, компаниудаас гадна Улаанбаатар хот болон бусад аймгуудын 60-аад аж ахуй нэгжүүд оролцож бараа бүтээгдэхүүнээ сурталчлан борлууллаа. Мөн аймгийн Залуучуудын холбоотой хамтран “Аймгийн залуучуудын хөгжлийн 2009-2012 он хүртэлх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Оюутны холбоотой хамтран Хангайн бүсийн их, дээд сургуулиудын дунд ерөнхий эрдмийн олимпиадыг уламжлал болгон зохион байгууллаа. 2009 оны 11 сарын байдлаар орон нутгийн төсвөөс зайлшгүй шаардлагатай 40.6 сая төгрөгийн санхүүжилтыг төрийн бус байгууллагуудад олгоод байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 70%</p>
		<p>2. Хотын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд “Эрдэнэт-Үйлдвэр” ХХК болон бусад аж ахуйн нэгж, байгууллагатай хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах.</p>	<p>Аймаг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд 2009-2012 онд хийх ажлын төлөвлөгөөг:</p> <p>1.Шинээр барих инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн, 2.Барилга, инженерийн шугам сүлжээ, авто замын засвар, шинэчлэлтийн, 3.Соёл урлаг, нийтийн спорт, ногоон байгууламжийн, 4.Хууль эрхзүй, төрийн удирдлага, санхүүгийн бодлогын гэсэн 4</p>

			<p>үндсэн чиглэлд 46 ажлыг хийн гүйцэтгэхээр батлаад хэрэгжүүлж байна. “Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлын хүрээнд 223 аж ахуйн нэгж, байгууллагатай гадна орчны тохижилтын гэрээ хийсэн бөгөөд үүний дагуу 1272 ширхэг мод, 3510 ширхэг бут сөөг тарьж, 244 ширхэг цэцгийн мандал байгуулан хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ орууллаа. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 1239 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийн төрийн анхан шатны байгууллага /багууд/-тай хамтран ажиллахын зэрэгцээ томоохон хөрөнгө оруулалтын ажлуудад ч идэвхтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Биелсэн 100%</p>
4.1.7.	<p>Хамтын ажиллагаатай муж, хотуудтай нийгэм, эдийн засгийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр гадаад улс орны муж, хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтооно.</p>	<p>1. Ах дүүгийн болон найрсаг хамтын ажиллагаатай муж, хотуудтай ажил хэрэгч харилцаагаа өргөжүүлж, үр дүнтэй бодит ажлуудыг зохион байгуулах.</p>	<p>Улаан-Үд хотын Хурлын даргын орлогч бөгөөд мандат, ёс зүйн хорооны дарга С.И.Шабаклова тэргүүтэй шинээр сонгогдсон депутатуудын бүрэлдэхүүн 2009 оны 06-р сард аймгийн хурлын байгууллагын үйл ажиллагаатай танилцан, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан ба Улаан-Үд хот болон Орхон аймгийн хурлын байгууллагын хамтын ажиллагааг улам идэвхжүүлэн гэрээ байгуулан ажиллахаар тогтоод байна.</p> <p>Улаан-Үд хотын Ахмадын зөвлөлийн дарга В.В.Фалилеев тэргүүтэй 10 ахмадуудыг 2009 оны 7-р сард ахмадын саам эмчилгээнд амраалаа.</p> <p>Аймгийн ардын хувьсгалын баяр наадмын үйл ажиллагаанд 2009 оны 7-р сард Улаан-Үд хотыг төлөөлөн гадаад харилцааны хэлтсийн дарга А.А.Хантаев нарын албаны хүмүүс оролцсон бол 2009 оны 9-р сард зохиогдсон Улаан-Үд хотын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд аймгийн Засаг дарга болон ИТХ-ын нарийн бичгийн дарга тэргүүтэй аймгийн хурал, захиргааны байгууллагын төлөөлөгчид оролцлоо.</p> <p>Хоёр хотын хоорондын гэрээний дагуу Орхон аймгийн 150 хүүхдийг Улаан-Үд хотноо Байгаль далайн эрэгт хүүхдийн зусланд амраахын зэрэгцээ мөн Улаан-</p>

			<p>Үд хотын 150 хүүхдийг “Найрамдлын Эрдэнэс” зусланд солилцон амраав.</p> <p>Файрбанк хоттой байгуулсан гэрээний дагуу манай аймаг дахь ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн 2 оюутан хөнгөлөлттэй /40.000 ам.долларын төлбөрөөс чөлөөлнө / нөхцөлөөр Аляскийн их сургуулийн Файрбанк хотын салбар сургуульд, мөн 2 оюутан Анкорэжийн сургуульд суралцаж байна.</p> <p>Манай аймаг нь 2006 онд БНСУ-ын Пухан хотноо болсон ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ, Монгол улсуудын 69 муж , хязгаар, аймгуудыг эгнээндээ нэгтгэдэг Зүүн Хойд Азийн орнуудын бүс нутгийн Засаг захиргааны холбооны /NEAR / 6-р чуулганаар энэ холбооны гишүүнээр нь элссэнээс хойш идэвхтэй хамтран ажиллаж байна. Мөн холбооны шугамаар 8-р сард БНХАУ-ын Хенан мужийн Жөнжөү хотноо зохион байгуулагдсан хуралд болон БНХАУ-ын Циньдао хотноо 2009 оны 9-р сард зохион байгуулагдсан Зүүн Азийн архивын гишүүн орнуудын “Хямралын үеийн менежмент” сэдэвт бүгд хуралд аймгийн холбогдох төлөөлөгчид оролцлоо.</p> <p>Хамтран ажиллах гэрээнд заагдсаны дагуу 2009 оны 08-р сард БНУУлсын Секешфехервар хотноо зохиогдсон “Хааны бүжгийн олон улсын өдрүүд” наадамд “Эрдэнэт” дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид амжилттай оролцов. Монгол улс, БНХАУ-ын хооронд найрамдалт харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд найрсаг харилцаа, хамтын ажиллагаат БНХАУ-ын Бугат хоттой байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус хотын соёлын хэлтсийн дарга тэргүүтэй төлөөлөгчид, Манхайн театр болон зургийн хүрээлэнгийн уран бүтээлчид 2009 оны 10-р сарын 14-нөөс 18-ны хооронд манай аймагт айлчлан уран зургийн үзэсгэлэн гаргаж, уран бүтээлийн тоглолтоо аймгийн иргэдэд толилууллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		2. Хөрш зэргэлдээ хоёр улс, өрнийн	Польш улсын Лубин хоттой харилцаа, хамтын

			<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр, нийгмийн халамж - Газрын харилцаа - Нийгмийн даатгал - Бизнес ширээ буюу үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөгөө өгөх - Нотариат - Мэдээлэл зөвлөгөө өгөх - Татвар хураамжийн үйлчилгээ /НЦҮ дэх банкиар дамжуулан/ <p>Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд нэг цэгээс хэд хэдэн үйлчилгээг авч, тэдний цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх төдийгүй, үйлчилгээ нь шуурхай, нээлттэй болох боломж бүрдээд байна. Тайлангийн хугацаанд тус төвөөр нийт 10000-аад иргэдэд үйлчилгээ үзүүлээ.</p> <p style="text-align: center;">Биелсэн 100%</p>
4.1.9.	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нээлттэй харилцан, хамтран ажиллаж, аймгийн иргэд хөдөлмөрчдөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг шуурхай хүргэнэ.	1. Аймгийн төр захиргааны байгууллагын ажлын талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж ажиллах.	<p>Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн телевизүүд нь бүгд өдөр тутмын мэдээллийн хөтөлбөртэй бөгөөд ИТХ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ЗДТГ-ын үйл ажиллагааны талаар өдөрт 25-30 минутын мэдээ мэдээлэл дамжуулж байна.</p> <p>Аймаг орон нутгийн зүгээс зохион байгуулж буй бүх төрлийн үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг чөлөөтэй оролцуулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, ажиллах боломж нөхцлөөр хангаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
		2. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллах	<p>Төвийн хэвлэл мэдээллээр аймгийнхаа амьдрал, төр захиргааны байгууллагын үйл ажиллагааг сурталчлах талаар санаачилга гарган ажиллаж байна. Энэ жил МҮОНТ-ийн “Цагийн хүрд” хөтөлбөр, НТВ, С-1, UBS, ТВ-9, ТВ-5 телевизүүдээр сард 2-3 мэдээ сурвалжлага, “Зууны мэдээ” сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр 30-аад мэдээ мэдээлэл нийтэллээ.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 30%</p>

2. Эрхзүйн бодлого, зохицуулалт

<p>4.2.1.</p>	<p>Эрх зүйн сургалт, сурталчилгаа мэдээллийн ажилд иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг идэвхитэй оролцуулж эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сургалт сурталчилгааг орчин үеийн арга хэлбэрээр зохион байгуулна.</p>	<p>1. “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган, эрх зүйн албан бус сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулах.</p>	<p>Эрх зүйн албан бус сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах төлөвлөгөө гарган Баян-Өндөр, Жаргалант сумын 22 багийн Засаг дарга нарт зориулан “Иргэдийн эрх зүйн хөтөч” , “Иргэдийн хөтөч” номоор 50 CD гарын авлага бэлтгэн олгож, Эрдэнэт хууль зүйн мэдээ сонины 6 дугаарт 10 гаруй төрлийн хууль тогтоомжоор нүүр бэлтгэн гаргаж төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудад 5000 ширхэгийг хэвлүүлэн хүргүүллээ.</p> <p>Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны 8 цехэд өдрийн сургалт зохион байгуулж сургалтад 640 гаруй ажилтнууд оролцсон байна.</p> <p>”Эрх зүйн сургалт сурталчилгааны төв”-ийг шинээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэв. Эрх зүйн сургалт сурталчилгааны албан бус сургалт явуулах сэдэв, сургагч багш нарын мэдээллийг харъяа агентлаг, хэлтэс, газарт албан бичиг хүргүүлсний дагуу хүлээн авч 2009 оны төлөвлөгөөг боловсруулан хуваарь гарган сургалт хэвийн явагдаж байна. “Хар тамхины эсрэг” аяны хүрээнд хар тамхи мансууруулах бодисыг хэрхэн таних, тэдгээрийн тархац, хэрэглээ, хор хөнөөлийн талаар сургалтыг зохион явууллаа. Сургалтанд төрийн болон төрийн бус байгууллагын 32 хүн хамрагдав. Эрх зүйн туслалцаа үзүүлэх паралегалуудад зориулсан байнгын сургалтыг эрх зүйн туслалцааны төвөөс зохион явуулж,18 багийн 100 гаруй паралегалуудад хууль эрх зүйн мэдлэгийг системтэйгээр өгөх зорилгоор 5 хэсэгт хуваан хууль зүйн тодорхой сэдвүүдээр долоо хоног бүрийн лхагва гаригт албан бус сургалтыг явуулан хэвшиж байна. Иргэдийн сонирхсон сэдвийн хүрээнд баасан гараг бүрийн 14-16 цагийн хооронд холбогдох байгууллагын мэргэжилтэнг урин авчирч сургалт,</p>
---------------	--	---	--

			<p>нээлттэй ярилцлага, асуулт хариулт, зөвөлгөө хэлбэрээр зохион байгуулж байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>
		<p>2. Эрх зүйн туслалцааны төв"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эрх зүйн сургагч багш нарын багийг бүрдүүлэх, сургаж бэлтгэх.</p>	<p>Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр болон ХЗДХЯам, Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны зорилго чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Орхон аймагт “Эрх зүйн туслалцааны төв”-ийн салбарыг байгуулан ажиллаж байна. Дээрх хугацаанд тус төвд нийт 58 төлбөрийн чадваргүй иргэн хандсанаас хүлээн авсан хэрэг 53, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг 47, шийдвэрлээгүй хэрэг 6, хүлээн авахаас татгалзсан хэрэг 2, анхан шатны зөвлөгөө авсан 700-аад иргэн байна.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		<p>3. Орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа гадаадын болон дотоодын хөтөлбөр, төслүүдийн үйл ажиллагааг “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”-тэй уялдуулах.</p>	<p>“Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр, Албан бус боловсрол төв, Хууль хяналтын байгууллагуудтай хамтран Баян-Өндөр сумын 19 багийн 450 гаруй иргэд, хэсгийн ахлагч нарт 10-аад төрлийн хууль тогтоомжуудаар, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 163 ажилтнуудад Мэргэжлийн байгууллагуудаас хийж буй хяналт, шалгалт, татвар хураамжийн давхардлыг арилгах нь сэдэвт сургалтыг зохион байгуулж, ЛХА, Номин, TV10 телевиз, Эрдэнэт үйлвэрийн FM-107.1-ээр 16 удаагийн нэвтрүүлэг хийгээд байна.</p> <p>ХЗДХЯам, Нээлттэй нийгэм форум, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх төсөлтэй хамтран эрх зүйн туслалцааны төвүүдийн сургалт, сурталчилгааны ажилтан болон өмгөөлөгч нарт зориулсан сургалтанд оролцсон байна. Багийн Засаг дарга нарт Чехийн сургагч багш гэр хорооллын худаг байгуулах асуудлаар, Дэлхийн зөн ОУ-ын байгууллагаас Удирдахуйн хичээлийг тус тус эрх зүйн туслалцааны төвийн хичээлийн танхимаар явуулав.</p> <p>Хэрэгжиж байна 50%</p>
		<p>4. Прокурор, цагдаа, шүүх, өмгөөлөл,</p>	<p>Шүүгч өмгөөлөгч нарын дунд Эрүүгийн хууль болон</p>

		<p>нотариат зэрэг хуулийн байгууллагуудтай эрх зүйн албан бус сургалтыг хамтран зохион байгуулах.</p>	<p>Иргэний хуулийн зарим заалт түүнийг практикт хэрхэн хэрэглэх тухай сургалт-семинар, ШШГА, Цагдаагийн газраас алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх хуульчийн ёс зүйн чиглэлээр 7 удаа сургалт зохион байгуулж сургалтанд давхардсан тоогоор 139 ажилтан, алба хаагч нар оролцсон байна. Захиргааны хэргийн шүүхийн шүүгчидтэй хамтран захиргааны эрх зүйн акт, газрын харилцааны талаар сургалт зохион байгуулж, 2 сум, аймгийн Тамгын газрын болон газрын харилцааны 20 гаруй ажилтнууд сургалтанд оролцлоо.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>5. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, нээлттэй өдөрлөг олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар хорооны үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 1.5 сая төгрөг хуваарилсан.</p> <p>Хэсгийн ахлагч нарт улирал бүр Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Газрын тухай хууль, тогтоомжуудаар сургалт явуулж давхардсан тоогоор 360 гаруй хэсгийн ахлагч хамрагдсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хууль хяналтын болон ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан нийт 120 хүн хамруулсан сургалт зохион байгуулсан. Сургалтыг хүн худалдаалах, шинэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам сэдвээр явуулж, салбар хорооноос 770.000 төгрөгний хөрөнгө гаргасан байна. Хүний эрхийн өдрийг угтаж Шүүх, прокурор, Цагдаагийн газар, ШШГА, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтсийн удирдах ажилтнууд хүний эрхийн сэдвээр иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, зөвлөгөө өгөв.</p> <p style="text-align: right;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>6. Хүүхдэд эрх зүйн анхан шатны ойлголт, мэдлэг олгох сургалтыг зайны сургалтын хэлбэрээр, тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар</p>	<p>“Хот хоорондын замын хяналт”, “Хүүхдийн замын хөдөлгөөн”, “Хяналт”, “Гарц” зэрэг сэдвүүдээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нийт 39 удаа, “Явган гарц” 3 хоногийн аян, “Хар сүлд” хүүхдийн сайн дурын</p>

		зохион байгуулах.	бүлгэмтэй хамтран “Явган зорчигчийн үүрэг” нэг өдрийн аяныг зохион байгуулж, Номин, ЛХА, ТВ10 сувгуудаар сурталчилсан. Хэрэгжиж байна 30%
4.2.2.	Хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичгийн системчлэл, мэдээлэл, лавлагааны ажлыг боловсронгуй болгож сайжруулна.	1. Шинээр батлагдсан эрх зүйн актаар сангаа баяжуулж өөрчлөлт хөдөлгөөнийг цаг хугацаанд нь хийх.	2009 онд батлагдсан нийт 6 хууль, 15 нэмэлт өөрчлөлт, Монгол улсын хуулийн эмхтгэл 4 боть номоор лавламжийн сангаа баяжуулсан. Аймаг, сумын ЗДТГ, Эрдэнэт-Амьдрал, Боловсрол, соёлын газар зэрэг байгууллага аж ахуйн нэгжүүд Монгол улсын хуулийн эмхтгэл 4 боть ном худалдаж авахад 2,0 сая төгрөг зарцуулсан байна. Хэрэгжиж байна 90%
		2. Хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн сан, эрх зүйн нэгдсэн системээс лавлагаа өгөх шуурхай ажиллагааг ханган ажиллах.	Хууль тогтоомжийн лавламжийн сангаас нийт 1100 гаруй иргэн, аж ахуйн нэгжид лавлагаа, зөвлөгөө өглөө. Хэрэгжиж байна 90%
		3. Сум, багт эрх зүйн системчилсэн лавламжийн сан, фонд бүрдүүлж, ажиллуулах.	Баян-Өндөр, Жаргалант сум, 22 баг 12 хууль, эрх зүйн акт бүхий ном, CD-ээр лавламжийн сангаа шинэчилсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт сум, багуудын албан хэрэгцээнд “Хууль зүйн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдийг захиалан олгож байна. Хэрэгжиж байна 90%
4.2.3.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийх хяналт шинжилгээ үнэлгээний ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх.	1. Төр захиргааны байгууллагуудын дарга, захирагч нараас гаргаж байгаа захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллах.	Баян-Өндөр, Жаргалант сум, 19 агентлагийн захирамж, тушаал, дотоод журмыг хянаж, Засгийн газрын 1995 оны Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай 53 дугаар тогтоолын биелэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд Боловсрол соёлын газар, Татварын хэлтсийн архив хангалтай сайн, 17 байгууллага дунд, Жаргалант сумын ЗДТГ, Хотын захирагчийн алба хангалтгүй дүн үзүүлсэн байна. Хэрэгжиж байна 50%
		2. Аймгийн хэмжээнд хийгдэх хяналт шалгалтын ажлын чанарыг сайжруулан,	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хяналт шалгалтын байгууллагуудын хамтарсан үзлэг

		<p>хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх.</p>	<p>шалгалтын хуваарийг улирлаар гарган баталж, мөрдүүлж эхэллээ.</p> <p>Хууль тогтоомжийн хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийж байгаа бөгөөд 2009 оны эхний хагас жилийн байдлаар 82,9 хувийн хэрэгжилттэй байна. Гадаадын иргэдийн бичиг баримтын шалгалтыг хийж, зөрчил гаргагчдад 1.7 сая төгрөгийн торгууль ногдууллаа. Эрх зүйн ажлыг шалгах шалгалтын удирдамжийг батлан сургалт сурталчилгаа, авлигатай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, хүний эрхийн чиглэлээр үндэсний хөтөлбөр хуулийн хэрэгжилтийн талаар зохиож байгаа ажлууд, хяналтдаа авсан байдал зэргийг харъяа хэлтэс, агентлагуудад шалгалаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 70%</p>
4.2.4.	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын 6-11 дүгээр ангийн сурагчдад Ухаарал, Хүүхэд хөгжил төв, Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сангаас эрхлэн гаргасан “Нэг л алдвал”, “Надад хүүхэд нас байгаагүй” зэрэг баримтат кинонуудыг үзүүлж, 10 гаруй сургуулийн 2500 орчим хүүхдийг хамруулсан байна.</p> <p>“Эрдэнэт” хууль зүйн сонины 3 дугаарт авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар нийтэлж, ТВ-10 сувгаар 30 минутын шууд ярилцлагаар Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрүүдийг сурталчиллаа.</p> <p>Засаг даргын зөвлөлийн хурлаар Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа ажил, цаашид авах арга хэмжээний талаарх илтгэлийг хэлэлцсэн. Үүний үр дүнд Замын цагдаагийн тасагт зайлшгүй шаардлагатай байгаа согтуурал хэмжих багаж, плакат, санамж хэвлүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр боллоо.</p>

			Хэрэгжиж байна 70%
	2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, төрийн бус байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжин тэднийг энэ ажилд өргөнөөр татан оролцуулах, туслалцаа үзүүлэх.		<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон 11 аж ахуй нэгж, байгууллага, ГХУСАЗЗ, Цагдаагийн газар гурвалсан гэрээ байгуулж, бүх нийтээр амардаг баярын өдрүүдийг гэмт хэрэг зөрчилгүй тэмдэглэн өнгөрүүлэх талаар цагдаагийн газрын албан мэдэгдлийг 72 байгууллага, аж ахуй нэгжид өгч хариуг тооцон ажиллаа. Мөн 13 банк, банк бус санхүүгийн байгууллагууд дээр шалгалт хийн зөрчилтэй газруудад нь албан мэдэгдэл өгч дутагдлыг нь арилгуулах арга хэмжээ авлаа. 7 хоног тутам орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар 187 удаа мэдээлэл хийж зарим тохиолдолд танхайн гэмт хэргийн талаар тусгай нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд сэрэмжлүүлж байна. Багуудад хөршийн холбоо байгуулах ажлыг эхлүүлж, Хүрэнбулаг багийн санаачилгаар 2009 оныг хөршийн холбоо өрнүүлэх жил болгон тус багт нийт 110 хөршийн холбооны ахлагч ажиллаж байна.</p> <p>Бүх шатны сонгуулийн санал хураалтын өдрүүдэд аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ явуулахыг хориглож, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьлаа.</p> <p>Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 9 аж ахуйн нэгжийн удирдлатай объектоо камержуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах гэрээ байгуулсан.</p>
	3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тотоомжийн явц, үр дүнгийн талаар нийтэд мэдээлэх сурталчлах ажлыг зохион байгуулж, ГХУСАЗЗ-ийн дэргэд “Мэдээллийн төв” байгуулж ажиллуулах.		<p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Эрх зүйн сургалт сурталчилгааны төв”-ийг шинээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн бөгөөд уг ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тотоомжийн явц, үр дүнгийн талаар нийтэд мэдээлэх сурталчлах ажлыг зохион байгуулж байна.</p>
	4. Хулгайн болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх.		<p>Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцэх талаар зохиож буй ажлын тухай салбар зөвлөлийн мэдээллийг</p>

			<p>ГХУСА33-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн Засаг даргын зөвлөлийн хурлаар Цагдаагийн газраас гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын тайланг хэлэлцсэн.</p> <p>Бүх төрлийн хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хөдөлгөөнт эргүүлийн 34 алба хаагчдыг 24 цагийн турш үүрэг гүйцэтгүүлсэнээр бүх төрлийн хулгайн гэмт хэрэг буурсан байна. Үүний дотор Бусдын өмчийн хулгай 32.8 хувиар, Иргэдийн өмчийн хулгай 31.8 хувиар, Уулын Баяжуулах үйлдвэрийн хулгай 77.8 хувиар тус тус буурсан байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд Малчин багийн иргэдэд яриа, таниулга хийсэн. Жаргалант суманд 150 гаруй малчид оролцсон зөвлөгөөн хийж, “Уриалга” гаргасан байна.</p> <p>Энэ хугацаанд 10.9 сая төгрөгний хохиролтой, 14 холбогдогчтой 14 хэрэг, үйлдлийг илрүүлэн шалгаж, 12 хэргийг харьяалалын дагуу Булган аймгийн Цагдаагийн газарт шилжүүлж, 2 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>5. Гэмт хэргийн гаралт их байгаа цэгүүд, хүн ам олноор төвлөрдөг болон автомашины хөдөлгөөн ихтэй газруудад телекамер суурилуулах, квадратын систем нэвтрүүлж, хөдөлгөөнт эргүүлийг 24 цагаар ажиллуулах.</p>	<p>Аймгийн хэмжээнд 2009 оны 02 дугаар сараас эхлэн Дэнж-Эрдэнэ баг, Говил-Тосгон-Баянцагаан баг, 6-р микр, 5 дугаар микр, Хорооллын 6 цэгт хөдөлгөөнт эргүүлийн 6 машиныг ажиллуулж, хөдөлгөөнт эргүүлийн шатахууны зардалд нийт 12.240.000 төгрөг зарцуулаад байна. Хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчид 10716 хүн 6865 объект, 6580 тээврийн хэрэгсэл шалгаж, 4268 автомашины ачаа тээшинд үзлэг, шалгалт хийсэн байна. Хоногт дунджаар нэг чиглэлд 15 дуудлага хүлээн авч, согтууруулах ундаагаар үйлчилдэг бар, бөөний цэг болон 8 нэрийн хүнсний дэлгүүр, зочид буудал, гудамж, талбайд хяналт тавин ажилласны үр дүнд гэмт хэрэг өмнөх оноос 20.4 хувиар, илрээгүй хэрэг 20.6 хувиар, илрүүлэлтийн хувь 2.4 пунктээр, хулгайн гэмт хэрэг 44 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 23.6 хувиар тус тус буурлаа.</p>

			Хэрэгжиж байна 50%
		6. Хорих ял эдлээд суллагдсан хүмүүст захиргааны хяналт тавих ажлын үр нөлөөг сайжруулж, тэднийг нийгэмшүүлэх, ажлын байраар хангах арга хэмжээ авах.	Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, захиргааны хяналтанд байдаг насанд хүрсэн 87, 30 хүүхдээс 109 хүний хяналтыг зогсоож, 2009 оны 7-р сарын 9-ны өдөр батлагдсан “Өршөөл үзүүлэх” тухай хуулиар суллагдсан 95 хүнд итгэл найдварын хуудас гардуулах, нийгэмшүүлэх уулзалтыг зохион байгуулж, аймаг сумын ИТХТ-ийн дарга нар болон Цагдаагийн газрын удирдлага, хэсгийн төлөөлөгчид, Багийн засаг дарга нар, Хууль зүйн хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Бүртгэлийн хэлтсийн ажилтнууд болон өршөөлөөр суллагдсан иргэд хамрагдлаа. Уулзалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж багийн Засаг дарга нар, цагдаагийн хэсгийн төлөөлөгчид өршөөлд хамрагдсан иргэдтэй нэг бүрчлэн уулзаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох эрхийн актаар зөвлөгөө өглөө. Мөн шүүхийн шинжилгээний албатай хамтран хүн нэг бүрийн гар, хурууны хээ, зургийг хаягийн санд оруулсан.
			Хэрэгжиж байна 70%
		7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрыг баривчлах ял эдлүүлэх байртай цогц байдлаар барих ажлыг эхлүүлэх.	Тасарсан
		8. Цагдаагийн газрыг тусгай хэрэгсэл, гар утас, холбооны станц, эргүүлийн автомашинаар хангах ажлыг зохион байгуулах.	Орон нутгийн төсвөөс энэ онд хөдөлгөөнт эргүүлийн авто машин, тусгай хэрэгсэл, холбооны станц авахад зориулан 28.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.
			Хэрэгжиж байна 90%
		9. Замын Цагдаагийн тасаг, эрүүлжүүлэх, баривчлах байрыг барьж, ашиглалтанд оруулах.	Өнгөрсөн онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус байрны суурин хэсгийг барьсан бөгөөд үргэлжлүүлэн барихад шардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ХЗДХЯаманд санал хүргүүлсэн боловч шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлээд байна.

			Хэрэгжих шатандаа 10%
		10. Архинд донтох өвчтэй иргэнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг сайжруулан, албадан эмчилгээний бүсийн төв байгуулах асуудлыг тавьж, шийдвэрлүүлэх.	<p>Аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Согтуурал” нэгдсэн арга хэмжээнд байнга архидан согтуурдаг гэр бүлийн таагүй уур амьсгал бүрдүүлдэг 185 архаг архичдын нэгдсэн судалгааг шинэчилж, архинд донтох өвчтэй иргэдийг эрүүлжүүлэх бодлогын хүрээнд нийт 30 хүнийг Төв аймгийн Баян сумын албадан эмчилгээний газарт явуулав. Энэ ажлын хүрээнд орон нутгаас 3.4 сая төгрөг зарцууллаа.</p> <p>Байнга архидан согтуурдаг 630 хүнд ЗХТХуулиар 7-30 хоног баривчлах арга хэмжээ авлаа.</p> <p>Хэрэгжиж байна 30%</p>
		11. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулах.	<p>Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж 8125 тээврийн хэрэгсэл шалгаж, 2315 зөрчил илрүүлж, 1459 жолоочийг 5.750.000 төгрөгөөр торгож, 315 зөрчлийг газар дээр нь арилгуулж, шугам замын байцаагч нар шийтгэврээр 21 жолоочийг 270.0 мянган төгрөгөөр торгосон байна. Зорчигч, Гарц зэрэг нэгдсэн ба хэсэгчилсэн арга хэмжээг 6 удаа явуулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 3 удаа мэдээлэл хийж “Хамгаалах бүс” нэгдсэн арга хэмжээг сарын хугацаатай зохион байгуулж байна. Үүний үр дүнд Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 42.9 хувиар буурсан байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал угтаж 45 хоногийн Согтуу нэгдсэн арга хэмжээг явуулсны үр дүнд 1 шөнө 17 согтуу жолооч эрүүлжүүлэгдэж байсан бол 5-6 болж буурлаа. Хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх, гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт самбар 5 ширхэг байрлуулж, 100 плакат, 300 ширхэг санамж хэвлүүлэн тараалаа. Тайлангийн хугацаанд гарсан осол гэмтэл, хохирлыг өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Хэрэгжиж байна 90%</p>

		<p>12. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жолооны курсуудыг аттестатчилж, жолооч бэлтгэх ажлыг чанаржуулах.</p>	<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 16 жолооны сургуулийн хичээлийн танхим, жолоодлогын талбайн хүрэлцээ зэргийг шалгаж шаардлага хангахгүй байгаа “Мөнгөн од” жолооны сургуулийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.</p> <p>Тээврийн улсын үзлэгт 5700 тээврийн хэрэгсэл үзлэг, оношлогоонд хамрагдсанаас 1540 зөрчил дутагдал илэрч үүнээс 1340 нь зөрчлөө арилгасан байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>13. Архи худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэгүүдийн тоог бууруулах бодлого баримтлан ажиллах.</p>	<p>Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдийн тоог бууруулах зорилгоор 400 гаруй цэгийг шалгаж, аттестатчиллаа. Аймгийн Засаг даргын 2009 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 221 тоот захирамжаар 73 цэгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд “Захирамж” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, 12 цэгийн тусгай зөвшөөрөл, 806 ширхэг архи, 58 ширхэг пиво, 6 вино хурааж, үйл ажиллагааг нь бүр мөсөн зогсоолоо.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
<p>4.2.5.</p>	<p>Хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, ажлын үр нөлөөг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.</p>	<p>1. Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд уруу татагдахаас урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх.</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар Цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт 12 цагийн сургалт явуулж, хохирогчтой ажиллах талаар зөвлөмж өглөө. 4 цогцолбор сургуулийн дунд, ахлах ангийн 150 гаруй охидод сургалт явуулж, гарын авлага, материал тараалаа. Багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар болон Цагдаагийн газрын хүүхдийн алба, Хүүхдийн төлөө хэлтсийн ажилтнуудыг хамруулан нийт 200 хүнд хөтөлбөрийн талаар ярилцлага зохион байгууллаа. ЕБ-ын “Наран” цогцолбор сургуулийн дунд, ахлах ангийн 51 охидод энэ гэмт хэргийн талаар сургалт явуулж гарын авлага тараав.</p> <p>“Эрвээхэй” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, зочид буудал, бар, цэнгээний газруудад үзлэг, шалгалт</p>

			<p>хийж, биеэ үнэлдэг 26 эмэгтэйг шинжилгээнд хамруулж, 18 хүнийг шинээр хяналтанд авч, 18 эмэгтэйг 7-14 хоногоор баривчлууллаа. Бусдад биеэ үнэлэх нөхцлийг бий болгож, удаа дараа зөрчил гаргасан “Анар” зочид буудлын үйл ажиллагааг зогсоолоо.</p> <p>Улсын мөрдөн байцаах газар, Эрүүгийн Цагдаагийн газартай мэдээлэл солилцон хамтран ажилласнаар бусадтай бүлэглэж Монгол охидыг Монгол улсын хил дамнуулан худалдсан Орхон аймгийн харъяат Ж.Шинэсүх гэгчийн хэргийг илрүүлж эрүүгийн 20825514 тоот хэрэг үүсгэн Улсын Мөрдөн Байцаах газарт шилжүүлсэн. Хүн худалдаалах шинэ төрлийн гэмт хэргийн талаарх сургалтад Хүүхдийн төлөө хэлтэс, ЕБС-ын нийгмийн ажилтнуудыг хамрууллаа</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
		<p>2. Хүүхдийг ахуйн болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, жил бүр энэ чиглэлээр сарын ажил зохион байгуулах.</p>	<p>Хүүхэд ба хөдөлгөөн” сэдэвт аяныг зохион байгуулж, их, дээд болон ерөнхий боловсролын сургуулиудад албан мэдэгдэл өгч, замын хөдөлгөөний дүрмийн хичээл заасан. Мөн “Хот хоорондын замын хяналт” , “Хүүхдийн замын хөдөлгөөн” , “Хяналт” зэрэг бусад сэдвүүдээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нийт 14 удаа, “Явган гарц” 3 хоногийн аян, “Хар сүлд “ хүүхдийн сайн дурын бүлгэмтэй хамтран “Явган зорчигчийн үүрэг” нэг өдрийн аяныг зохион байгуулж энэ талаар Номин, ЛХА, ТВ10 телевизүүдээр нэвтрүүлэг хийсэн байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 90%</p>
		<p>3. Нийгмийн хамгаалал зайлшгүй шаардлагатай хараа хяналтгүй, гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийг хүмүүжүүлэх хөдөлмөр хүмүүжлийн төв байгуулах.</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, сахилга хариуцлагыг сайжруулах талаар 2009-2012 онд хийх ажлын төлөвлөгөөнд тусгаад байна. Холбогдох судалгаа хийж, тооцоо хийж байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжих шатандаа 10%</p>
		<p>4. Сургууль цогцолбор бүрт хүүхдийн</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулиудын Хүүхэд</p>

		<p>гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр анги, кабинет байгуулж байнгын үйл ажиллагаатай болгох .</p>	<p>хөгжлийн төвийг түшиглэн 16 сургууль дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх кабинет байгуулаад байна. Сургалтад шаардлагатай гарын авлага, материалаар 2009-2010 оны хичээлийн жилээс хангаж эхэллээ. Хэрэгжиж байна 50%</p>
		<p>5. Хүүхэд өсвөр үеийг ахуйн болон зам тээврийн аюул ослоос сэргийлэхэд чиглэсэн сургалт арга хэмжээг нэмэгдүүлэх.</p>	<p>Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж Хууль зүй дотоод хэргийн сайдын 73, Замын цагдаагийн газрын даргын 150 дугаар тушаалаар 8125 тээврийн хэрэгсэл шалгаж, 2315 зөрчил илрүүлж, 1459 жолоочийг 5.750.000 төгрөгөөр торгож, 315 зөрчлийг газар дээр нь арилгуулж, шугам замын байццагч нар шийтгэврээр 21 жолоочийг 270.0 мянган төгрөгөөр торгосон байна. Зорчигч, Гарц зэрэг нэгдсэн ба хэсэгчилсэн арга хэмжээг 6 удаа явуулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 3 удаа мэдээлэл хийж “Хамгаалах бүс” нэгдсэн арга хэмжээг сарын хугацаатай зохион байгуулж байна. Үүний үр дүнд Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 42.9 хувиар буурсан байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал угтаж 45 хоногийн Согтуу нэгдсэн арга хэмжээг явуулсаны үр дүнд 1 шөнө 17 согтуу жолооч эрүүлжүүлэгдэж байсан бол 5-6 болж буурсан. Хэрэгжиж байна 50%</p>
		<p>6. Гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллээс хүүхдийг хамгаалах бичил хөтөлбөр төслийг төсвөөр хэрэгжүүлэх.</p>	<p>Тасарсан.</p>

4.2.6.	Нийгмийн дэг журам, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн идэвхи санаачлага, оролцоог нэмэгдүүлнэ.	1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийг нийгмийн дэг журам сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажилд татан оролцуулж, дэмжих, урамшуулах арга хэмжээ авах.	<p>2008 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажлын тайланг хэлэлцээд “хангалттай” гэсэн үнэлгээг өгч 2009 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг ГХУСАЗ зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталлаа.</p> <p>2009 оны эхэнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон 11 аж ахуй нэгж, байгууллага, ГХУСАЗЗ, Цагдаагийн газар гэсэн гурвалсан гэрээг хийж, Монгол Улсын хөдөлмөрийн хуулиар бүх нийтээр амардаг баярын өдрүүдийг гэмт хэрэг зөрчилгүй тэмдэглэн өнгөрүүлэх талаар Цагдаагийн газрын албан мэдэгдлийг 72 байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргүүлж хариуг тооцон ажиллаж байна.</p> <p>Цагдаагийн газрын нээлттэй хаалганы өдрийг сар бүрийн 2 дахь 7 хоногийн Пүрэв гаригт зохион байгуулан 232 иргэдээс ирүүлсэн санал гомдлыг хүлээн авч 155 шийдвэрлэн хариу өгч 4500 ширхэг зөвлөмж анхааруулгыг тараалаа.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p>
4.2.7.	Хууль, хяналтын байгууллагуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулна.	<p>1. Аймаг, сум, багт Үндэсний бүртгэлийн нэгдсэн интернет сүлжээг ашиглах боломжийг бүрдүүлж, төр захиргааны байгууллагуудын бүртгэл, мэдээллийн сан, системийн нэгдмэл байдлыг хангах.</p> <p>2. Аймгийн Архивын байр барих, архивын болон албан хэрэг хөтлөлтийн программ нэвтрүүлэх, түүнд шаардагдах техник</p>	<p>Аймгийн төрийн байгууллагуудын “Цахим Эрдэнэт” нэгдсэн сүлжээнд ажиллаж байгаа байгууллагууд компьютерийн дотоод сүлжээндээ болон интернетэд холбогдон мэдээллийн технологийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хадгалах, хамгаалах журмыг боловсруулан 2009 оны 02 дугаар сарын 25 ны өдрөөс эхлэн мөрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Багийн зохион байгуулагч нарын программ хангамж, сүлжээний сургалтыг зохион байгуулж цахим сүлжээнд ажиллах чадварыг дээшлүүлсэн.</p> <p>Өнөөгийн байдлаар “Цахим Эрдэнэт” нэгдсэн сүлжээнд 63 төрийн байгууллага холбогдож, мэдээ мэдээлэл солилцож байна.</p> <p style="text-align: center;">Хэрэгжиж байна 50%</p> <p>Архивын байрны зураг, төсвийг хийлгэх хөрөнгийн эх үүсвэргүй байна.</p> <p>Төрийн архивын программ хангамж суурилуулах</p>

		хэрэгслээр хангах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлэх.	ажил хийгдэж, хүлээн аваад байна. Байгууллагын архивын программ нэвтрүүлэх ажлыг 2010-2011 онд нийт 9 байгууллагад хэрэгжүүлэхээр Архивын Ерөнхий газарт саналаа хүргүүллээ. Хэрэгжиж байна 30%
		3. Аймгийн Онцгой байдлын хэлтэс, гал унтраах ангиудын ажиллах боломжийг сайжруулж, шаардлагатай техник хэрэгсэл, тусгай зориулалтын автомашинаар хангах.	2009 онд гал гамшгийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ОХУ-д үйлдвэрлэсэн гал унтраах зориулалт бүхий /АЦ-40/ маркийн автомашиныг 142,0 сая төгрөгөөр авч олгоод байна. Хэрэгжиж байна 50%
4.2.8.	Нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол, уламжлалт бус бусад аюулын үед хүн, байгаль орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бэлтгэлийг дээшлүүлнэ.	1. Болзошгүй аюулын үед тохиолдож болох хохирлыг арилгах, таслан зогсоох бэлтгэлжилтийг дээшлүүлэх.	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дадлага олгох зорилгоор сум аж ахуйн нэгж, байгууллагын 14 нөхөрлөлийн 210 гишүүн оролцсон “Аврагч-2009” тэмцээнийг явуулав. Гамшгаас хамгаалах иргэний хамгаалалтын чиглэлээр 6 их, дээд сургуулийн 1200 гаруй оюутнуудад 36 цагийн хичээл заав. 2009 оны 9 дүгээр сард цаг агаар муудаж гамшигт үзэгдэл болж болзошгүй нөхцөл байдал зарласан үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажилд удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллалаа. Хэрэгжиж байна 50%
		2. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх.	Орон нутгийн хамгаалалтыг нутаг дэвсгэрт бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг “Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах төлөвлөгөө”-ны дагуу явуулж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Зэвсэгт хүчний 186 дугаар ангид оногдуулан данслагдсан хүн хүч, машин техникийг 2 удаа тодотголоо. Хэрэгжиж байна 90%
		3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх.	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хичээлийн байр, сургалтын төвийг түшиглэн дайчилгааны бэлтгэл нөөцийн цэрэг, түрүүч-40 хүнтэй 10 хоногийн хугацаатай сургалтыг зохион байгуулан оногдуулан данслагдсан цэргийн бага мэргэжилтэнг бэлтгэж, тайлан мэдээг БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар хэлтэст

			хүргүүлэв. Хэрэгжиж байна 90%
		4. Гамшиг осолд өртсөн хүмүүсийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Аврах-105” бүлгийг шинээр байгуулах	Онцгой байдлын газрын дэргэд 6 хүний бүрэлдэхүүнтэй аврах бүлэг байгуулсан бөгөөд цаашид аврах шуурхай бүлгийг шаардлагатай авто машин, техник хэрэгслээр хангах шаардлагатай. Хэрэгжиж байна 50%

БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д. ОЮУНБАТ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТЗУХ-ИЙН
ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ